**“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ**

# МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН БЭЛТГЭЛ БОЛОН СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭХЛЭЛИЙН ТАЙЛАН

2018 ОН

**ЗАХИАЛАГЧ:** “БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ”

**ГҮЙЦЭТГЭГЧ:**”БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”

# МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН БЭЛТГЭЛ БОЛОН СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭХЛЭЛИЙН ТАЙЛАН

**ТАНИЛЦСАН:**
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

**ЗАХИАЛАГЧ:**
**Гүйцэтгэлийг хүлээн авч хянасан:**
БАРИЛГА,ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ХБГХБХЗГ-ЫН ДАРГА

Б.ГҮНБОЛД

БАРИЛГА,ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ХБГХБХЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Э.АРИУННЯМ

**ГҮЙЦЭТГЭГЧ:**
**Гүйцэтгэл хүлээлгэн өгсөн:**

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Ц.АМАРСАНАА

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ДЭД ЗАХИРАЛ

Б.ЭНХБОЛД

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН СТХХ-ИЙН ДАРГА

Г.ГАНТУУЛ

БХТ-ИЙН ХАНБНСТХ-ИЙН ДАРГА

С.ДАВААНЯМ

БХТ-ИЙН ХСДБСТХ-ИЙН ДАРГА

Д.ЧИНЗОЛБОО

2018 ОН

## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт ........ 4
Гүйцэтгэсэн ажлын товч тайлан ........ 5
I.БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН ........ 6
II.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ ........ 7
2.1 Төсөл боловсруулах үндэслэл ........ 7
2.2 Төсөл боловсруулах шаардлага ........ 7
III.БЭЛТГЭЛ АЖИЛ ........ 11
3.1 Ажлын даалгавар, зургийн даалгавар, календарчилсан төлөвлөгөө ........ 11
3.2. Орон нутагт ажлын хэсэг байгуулах ........ 11
3.3 Салбарын уулзалт хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах ........ 12
IV. СУУРЬ СУДАЛГААНЫ ХЭСЭГ ........ 19
4.1.Судлагдсан байдал ........ 19
4.2.Онолын үндэс, аргачлал ........ 22
4.3. Хууль, эрх зүйн байдлын судалгаа ........ 27
4.5. Гадаад улсуудын туршлага, сургамж ........ 35
4.5.1 Хүн амын суурьшлын засаг захиргааны хуваариудаарх дэлхийн улсуудтай харьцуулсан судалгаа ........ 39
4.4.Нийгэм эдийн засгийн судалгаа ........ 43
4.5. Хүн ам, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа ........ 44
4.6.Амралт сувилал, аялал жуулчлалын судалгаа ........ 45
4.7. Газар ашиглалт, газар зохион байгуулалтын судалгаа ........ 46
4.8. Хүрээлэн буй орчин ба хүн амын нутагшилт суурьшил ........ 46
4.9. Хот суурин газруудын засаг захиргааны бүтэц зохион байгуулалтын судалгаа ........ 52
4.10. Судалгаа, шинжилгээ, харьцуулалт дүгнэлт ........ 63
V. ОРОН НУТГИЙН СУДАЛГАА ........ 78
5.1 ГОВЬСҮМБЭР АЙМАГ. ........ 83
5.2 ДОРНОГОВЬ АЙМАГ. ........ 86
5.3 ӨМНӨГОВЬ АЙМАГ ........ 94
5.4. ДУНДГОВЬ АЙМАГ ........ 98
VI. ДҮГНЭЛТ ........ 102
Ашигласан материалууд ........ 104
ХАВСРАЛТ 1. Орон нутагт томилолтоор ажилласан байдал ........ 106
ХАВСРАЛТ 2. Томилолтоор ажиллах хугацаанд цуглуулсан мэдээ материалуудын жагсаалт ........ 142
Хавсралт 3. Орон нутагт томилолтоор ажиллах маршрутын газрын зураг ........ 145

# Товчилсон үгийн жагсаалт

БХБЯ – Барилга, хот байгуулалтын яам

БХТ – Барилгын хөгжлийн төв

ХАНСХЕТ – Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл

ХАНБНСТХ – Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа төлөвлөлтийн хэлтэс

ХСДБСТХ - Хот суурин, дэд бүтцийн судалгаа төлөвлөлтийн хэлтэс

УИХ – Улсын Их Хурал

ДБ – Дэлхийн банк

АХБ – Азийн хөгжлийн банк

ГХГЗЗГ – Газрын харилцаа, геодези зурагзүйн газар

ЗДТГ – Засаг даргын тамгын газар

ЗЗНДХ – Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь

ЕБС – Ерөнхий боловсролын сургууль

## Гүйцэтгэсэн ажлын товч тайлан

1. “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын зургийн даалгавар”-ийн төсөлд 15 чиглэлээр өөрчлөлт оруулж, мөн агуулгын холбогдох өөрчлөлтүүдийг шинэчлэн боловсруулж БХБЯ-нд хүргүүлсэн. Мөн ХАНСХЕТ боловсруулах ажлын даалгаврыг батлуулан хэрэгжүүлж байна.
2. 1996 онд боловсруулагдсан “Монгол Улсын хүн амын нутагшилт хөгжлийн ерөнхий төсөл”-ийн цаасан болон цахим материалыг тухайн үед оролцож байсан хүмүүсээс цуглуулж бүрдүүлсэн.
3. Монгол Улсын хүн амын ачаалал, Дотоодын нийт бүтээгдэхүүн, Сумдын хүн амын тооны өөрчлөлт, Аймгуудын хүн амын шилжилт хөдөлгөөн, Нийслэл рүү чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн /бүсээр/, Хүн амын нягтшил, Хот хөдөөгийн хүн ам, Томоохон гол мөрд дагасан суурьшил зэрэг зургуудыг 2017 оны байдлаар ArcGis программ ашиглан зураглал хийж мэдээллийн санг үүсгэсэн.
4. ХАНСХЕТ боловсруулах багийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, орон нутагт ажиллахад дэмжлэг үзүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулахад хамтарч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг аймаг бүрт байгуулж, тэдгээрт хамтран ажиллаж холбогдох мэдээ материалыг бүрдүүлсэн.
5. Салбарын тэргүүлэх эрдэмтэн, судлаачдыг хамруулсан цуврал лекцийг 10 удаа зохион байгуулсан.
6. Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах календарчилсан төлөвлөгөөг 2020 оны 6 сар хүртэл эхний байдлаар боловсруулсан.
7. ХАНСХЕТ боловсруулах ажлын хүрээнд туршлага судлах үүднээс ОХУ-ын Улаан-Үд хот болон Байгаль нуурын аялал жуулчлалын онцгой бүс, БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүс, Япон улсын Китакюшю болон Саппоро хотод томилолтоор ажиллаж, тухайн улсын хүн амын нутагшилт суурьшлын бодлого, бүсчилсэн хөгжил, тогтвортой хот байгуулалтын талаархи туршлага, сургамжийг судалсан.
8. Төвийн бүсийн өмнөд хэсгийн говийн аймгууд болох Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь аймгийн сумдууд болон Увс, Архангай, Дорнод, Орхон аймгийн сумд болон Замын-Үүд, Алтанбулагийн чөлөөт бүс, боомтод томилолтоор ажиллаж, ХАНСХЕТ-өө танилцуулж, аймгийн ажлын хэсгийн хурлыг хийж, холбогдох мэдээ материалаа цуглуулж, тэдгээрт анхдагч боловсруулалт хийсэн.
9. ХАНСХЕТ боловсруулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй Үндэсний хорооны хуралд танилцуулсан илтгэлийг боловсруулж, Ерөнхий сайдаар ахлуулсан тус хорооны гишүүдэд 2017 оны 7-р сарын 9-нд танилцуулж, холбогдох санал, чиглэлиг авсан.
10. Үндэсний хорооны дарга Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн УИХ-ын чуулганд ХАНСХЕТ-ийн ажлын явцын талаархи мэдээллийг танилцуулахад шаардлагатай мэдээ, материалыг боловсруулж өгсөн.

# I.БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Овог нэр | Албан тушаал | Мэргэжил |
|---|---|---|---|
| **Зөвлөхүүд** | | | |
| 1 | Энэбишийн Дондмаа | Хот төлөвлөлтийн зөвлөх архитектор | Архитектор |
| 2 | Пүрэвийн Энхээ | Хот төлөвлөлтийн зөвлөх эдийн засагч | Нийгэм эдийн засгийн газар зүйч |
| **Удирдах болон инженер техникийн ажилтнууд** | | | |
| 1 | Сүрэнжавын Даваанyaм | Хэлтсийн дарга | Газарзүйч, бүс нутаг судлаач |
| 2 | Дандарбаатарын Чинзолбоо | Хэлтсийн дарга | Архитектор |
| 3 | Дамбажанцангийн Отгонбат | Газарзүйч, бүс нутаг судлаач | Газарзүйч |
| 4 | Сономдагвын Гүнчинсүрэн | Хот төлөвлөлтийн архитектор | Архитектор |
| 5 | Балдоржийн Батхишиг | Хот төлөвлөлтийн архитектор | Барилгын инженер |
| 6 | Гомбосүрэнгийн Балжмаа | Газарзүйч, бүс нутаг судлаач | Газарзүйч, бүс нутаг судлаач |
| 7 | Гомбосүрэнгийн Баттуяа | Хот төлөвлөлтийн эдийн засагч | Эдийн засагч |
| 8 | Базарын Батзаяа | Газар зохион байгуулагч | Газар зохион байгуулагч |
| 9 | Болдбаатарын Идэрхангай | Газар зохион байгуулагч | Газрын кадастр |
| 10 | Жамъянхорлоогийн Түвшинбаяр | Инженер геологич | Геологич |
| 11 | Амгалангэрэлийн Сугар | Хот төлөвлөлтийн эдийн засагч | Хот ба бүс нутгийн төлөвлөлт |
| 12 | Баатарсүрэнгийн Ганпүрэв | Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн | Барилгын инженер |
| 13 | Амарсайхангийн Цолмон | Авто тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Барилгын инженер |
| 14 | Батбилэгийн Цолмон | Архитектор | Интерьер дизайнер |

# II.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

## 2.1 Төсөл боловсруулах үндэслэл

Хүн амын суурьшлын асуудлаар 1996 онд Стамбул хотод болсон НҮБ-ын II бага хурлаас нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг хангахад бүс нутгийн хөгжлийг тууштай хэрэгжүүлэхийг тухайн улс орнуудын Засгийн газруудын хүлээх үүрэг гэж тодорхойлсон.

Олон улсын жишгээр авч үзвэл, манай улсын хүн амын амьдрах тохиромжтой орон зай, тааламжит орчинг өөрийн хөгжиж ирсэн онцлог, газар нутгийн нөөц, баялаг, байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөлтэй уялдуулан, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан тодорхойлох, энэ үндсэн дээр нийгэм, эдийн засгийн ойр ирээдүйн хөгжил, соёлын түвшинг илэрхийлэх, нийгмийн дэвшилд идэвхитэй нөлөөлөх бодит үр дагавар бүхий нутаг дэвсгэрийг зохион байгуулах, хүн амыг зохистой байдлаар нутагшуулах төслийг боловсруулж, төрийн бодлогын түвшинд авч үзэн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсаар байна.

“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 119 тоот гэрээ

Монгол Улсын Ерөнхий сайдын баталсан 2018 оны ... сарын ... өдрийн ...дугаартай “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын даалгаврыг үндэслэл болголоо.

## 2.2 Төсөл боловсруулах шаардлага

Дараах хууль эрхзүйн болон бодлогын баримт бичгүүдэд ХАНСХЕТ-ийг боловсруулж хэрэгжүүлэхийг тодорхой заасан. Үүнд:

- Монгол Улсын Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.3,7.1.8,11.1.1,11.5.1,12.1,15.1.1 дэх заалт
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4,3.5,3.6, дахь хэсэг
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 он” ын 2.1.5,дахь хэсгийн зорилт 5-д 2016-2020 онд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах
- Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан **“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т** “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Тодруулбал Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.79-д “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах”-аар тусгагдсан. Түүнчлэн УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-

ын 2.1.5 дахь хэсгийн Зорилт 5-д 2016- 2020 онд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 35 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.1 дэх заалтад “2017- 2030 онд Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулна”, УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн“Стратегийн зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхид нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ”, УИХ-ын 2014 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 11.1 дэх хэсэгт “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах”, УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.4.1.6-д “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах”-аар тус тус заасан.

Бүс нутаг, аймаг, орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн дагуу хүн ам төвлөрөн суурьших тооцоо судалгааг гаргаж, хот, суурин газрын төлөвлөлтийг хийх, тэдгээрийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, хүнс, ажлын байр, орон сууцны хангамжийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хүн амын шилжилт хөдөлгөөн, нутагшил, суурьшлын судалгааг хийх шаардлагатай билээ. Үүнээс үүдэн  үйлдвэрлэлийн хөгжил, түүнийг даган бий болох хүн амын шилжилт хөдөлгөөний судалгаа хийх шаардлага ч гарч байна.

Монгол Улсын эдийн засаг эрчимтэй өсч буй хандлага ирэх жилүүдэд хадгалагдах төлөвтэй байгаа бөгөөд үүний үр дүнд дэд бүтэц, уул уурхай, хүнд аж үйлдвэр, эрчимжсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нэмэгдэж, хүний хөгжил, амьдрах орчин сайжрах бодит нөхцөл бүрдэж, үйлдвэрлэлийг дагаж хүн амын ажлын байр дагасан шилжих хөдөлгөөн, суурьшилт нутагшлийн шинэ төвлөрөл бий болохоор байна.

- Монгол Улсын хүн ам 3 177 899 болж өссөн (2017 оны жилийн эцсийн  байдлаар),

- Малын тоо 66 сая 218 мянгад хүрсэн (2017 оны жилийн эцсийн малын тооллогын дүнгээр),

- Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 5.1 хувь (2017 оны байдлаар) болсон байна.

Уул уурхайн болон барилгын салбарт өсөлт бий болж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ордуудаас гадна уул уурхайн ордууд нээгдэж, тэдгээрийг дагасан хот, суурин байгуулагдаж байна.

- Сайншандын аж үйлдвэрийн парк, Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудал зэрэг мега төслүүдийг түшиглэн шинэ суурьшил, хот суурин үүсэх нөхцөл байдал бүрдэх боллоо.

- Монгол Улсын бүх аймгийн төвүүд нь нийслэл хоттой хатуу хучилттай замаар холбогдсон, мөн уул уурхай, аж үйлдвэрүүдийг холбосон зам, тээврийн сүлжээ (төмөр зам, хурдны зам)-г барих ажлыг эхлүүлээд байна.

- Зарим бүс нутгийг газар тариалангийн чиглэлээр хөгжүүлснээр өөрийн орны дотоод хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдэж байна.

- Гадаад болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ чиглэл, маршрут гарч, бүс нутгийг хамарсан шинэ цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх болсон. Үүнийг дагасан аялал жуулчлал, үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүд бий болно.
- ОХУ, БНХАУ-тай хил орчмын хамтын ажиллагаа идэвхжиж, хилийн боомтууд шинээр нээгдэж, байнгын үйл ажиллагаатай боомтуудын тоо нэмэгдэх болсноор хил орчмын суурьшлын бүсүүд бий болох хандлагатай байна.
- Дэлхийн байгаль, цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор улс орны хэмжээнд “ухаалаг” болон “ногоон” хөгжлийн асуудлыг шинээр авч үзэж, нутагшилт, суурьшлын төсөлд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Нийслэлийн хэт төвлөрлийг сааруулах, орон нутагт хөгжлийг бий болгож, хүн амыг тогтвортой суурьшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай холбогдуулан шинэ бодлого, төлөвлөлт шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, 1940-2010 онд дэлхийн түвшинд дулаарал +0.85°С байхад Монгол оронд +2.07°С буюу дэлхийн дунджаас 2.4 дахин их байгаа бөгөөд улмаар Монгол Улс уур амьсгалын эрсдэлд эмзэг байдлаар дэлхийн 100 гаруй орноос 8 дугаарт орж байна.

Манай оронд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нь усны нөөц, горимд өөрчлөлт орох, олон жилийн цэвдэгт хөрс болон өндөр уулын мөстлөг хайлах, нуур цөөрөм, булаг шанд ширгэх, хөрсний усны түвшин доошлох, зуны хэт халалт, хуурайшилт болон агаарын мандлын гаралтай конвекцийн үзэгдлийн улмаас хөрс, бэлчээр доройтон ургамлын төрөл зүйлийн бүрдлийн тоо цөөрч, цөлжих үйл явц идэвхжих, зэрлэг амьтадын тархалтын бүс нутаг өөрчлөгдөх, ой хээрийн түймрийн давтагдал нэмэгдэх зэргээр илэрч байна.

Монгол орны өргөн уудам газар нутагт хүн амын нутагшилт, суурьшлын орон зайн төлөвлөлтийг өнгөрсөн 70 гаруй жилийн уур амьсгалын өөрчлөлт, цаашдын хандлагатай уялдуулан авч үзэх нь хот, суурин газрын тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дасан зохицох үндсэн нөхцөл болно.

Өнгөрсөн 70 гаруй жилийн хугацаанд орон зайн хувьд уур амьсгалын өөрчлөлт 20С-ээс дээш дулаарч буй бүсэд Улаанбаатар болон 9 хот, 55 сумын төв оршиж байна. Энэхүү бүсэд нийт хүн амын 60 хувь амьдарч байгаа нь Монгол Улсын хүн амын дийлэнх хэсэг нь уур амьсгалын өөрчлөлт, дулаарлаас үүдэлтэй эрсдэл өндөртэй бүсэд суурьшиж байгааг харуулж байна.

Түүнчлэн эрчимтэй хотжилт нь зүй бус газар ашиглалтыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт хотуудын эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Хуурай, эрс тэс уур амьсгалтай, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монгол Улсын хувьд хамгийн их хохирол дагуулдаг байгалийн гамшиг болох ган, зудын давтамж болон хохирлын хэмжээ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр нэмэгдэж байна. Тухайлбал, 1999-2002 онд болон 2009-2010 онд нийт нутгийн 80-90% хамарсан ган, зуд дараалан тохиолдсон жилүүдэд олон сая мал зүй бусаар хорогдож, олон мянган малчин өрх малгүй болсон бөгөөд улмаар гамшгийн дараах жилүүдэд хөдөөнөөс хот руу шилжин суурьшсан хүн амын тоо эрс нэмэгдсэн байдаг.

Хот, суурин газрын 75 орчим хувь газар хөдлөлтийн Рихтерийн 7 ба түүнээс дээш, 12 сум 9 баллаас дээш газар хөдлөлтийн идэвхитэй бүсэд, нийт хүн амын 86 хувь нь

эдгээр газар нутагт амьдарч байна. 2005 оноос Улаанбаатар хотод 20 км орчим зайд газар хөдлөлтийн идэвхжилт ажиглагдан 6 орчим хагарлыг илрүүлэн судалж байна. Улаанбаатар хот орчимд 2005 онд 1000, 2009 онд 2000, 2010 онд 2500 удаагийн газар хөдлөлтийн чичирхийлэл бүртгэгдсэн.

Уур амьсгалын өөрчлөлт нь нийт Монгол Улсын хүн ам, эдийн засагт эрсдэлтэй, олон сөрөг үр дагаврыг авчрах төлөвтэй байгаа бөгөөд энэ нь ус, ой, бэлчээр, газар, хөрс зэрэг нөхөн сэргээгдэх нөөцийн ашиглалтын менежмент, хүн амын нутагшилт, суурьшил, эрүүл мэндийн үйлчилгээ, технологийн стандартыг сайжруулахыг шаардаж байна.

Монгол Улсын эдийн засагт томоохон хот, суурины үзүүлэх нөлөө жил ирэх бүр нэмэгдсээр байгаа нь эдийн засгийн хөгжлийг орон зайн хувьд тэнцвэртэй хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Хөдөө аж ахуй, газар тариаланд суурилсан эдийн засгийн бүтцэд өөрчлөлт орж, энэ салбарт ажиллагсдын тоо буурах хандлагатай болсон. Мөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн уламжлалт мал аж ахуй, газар тариалан нь тогтвортой орших нөхцөл хумигдсаар байна. Үүнтэй холбоотой шилжилт хөдөлгөөн жилээс жилд өсөн нэмэгдэж, хүн амын төвлөрөл цөөн тооны томоохон хот, сууринд бий болсон нь бүс нутгийн хөгжлийн бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлэх, томоохон тулгуур төвүүдийг хоцронгуй бүсүүдэд бий болгох бодит хэрэгцээг үүсгээд байна.

Иймд Монгол орны газар нутаг, байгалийн нөхцөл, нөөц, хүн амын уламжлалт нүүдлийн болон эрчимжиж буй суурин хэвшлийн амьдрал, соёл иргэншлийн зохистой харьцаа, өвөрмөц онцлогт нийцсэн төрийн цогц бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг дунд болон урт хугацааны төлөвлөлт, үзэл баримтлалаар илэрхийлж, түүндээ цаашид байнга тодотгол оруулан боловсронгуй болгож байх нь зүйтэй юм.

Монгол Улсын Үндсэн хуулинд ”... хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, амрах эрхтэй...” гэж заасан нь бүхэлдээ хот байгуулалтын тухайлбал, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд дараагийн үе шатны бүс нутгийн төслүүд болон хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр дамжин хэрэгжиж байх ёстой билээ.

# III.БЭЛТГЭЛ АЖИЛ

## 3.1 Ажлын даалгавар, зургийн даалгавар, календарчилсан төлөвлөгөө

Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 2018/199 тоот гэрээг БХБЯ-тай байгуулсан. Уг төсөл нь Монгол улсын нийт 1,564,116 км$^2$ нутаг дэвсгэрийг хамарч 2020 он хүртэл боловсруулагдана. Төслийг эхний ээлж 2021-2030, төлөвлөлтийн хугацаа 2031-2040 он хүртэл 2 үе шаттай хэрэгжүүлнэ. Төсөл боловсруулах ажлын зургийн даалгаварт санал өгч, календарчилсан төлөвлөгөө, ажиллах хүчний хуваарийг гарган ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний хорооны хурлын илтгэлийг бэлтгэж 2018 оны 7-р сарын 9-нд гишүүдэд танилцуулсан. Мөн хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн ажлын явцын талаархи мэдээллийг Үндэсний хорооны дарга, Ерөнхий сайд УИХ-ын чуулганд танилцуулахад шаардлагатай мэдээ мэдээллийг боловсруулж өгсөн.

## 3.2. Орон нутагт ажлын хэсэг байгуулах

Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах багийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, орон нутагт ажиллахад дэмжлэг үзүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулахад хамтарч ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах албан бичгийн төсөл, орон нутаг дахь ажлын хэсгийн бүрэлдэхүүний саналыг боловсруулан БХБСайдын 2018.07.09-ний өдрийн 01/2797 тоот албан бичгийг аймгуудын засаг дарга нарт хүргүүлсэн. Үүний дагуу нийт 21 аймагт ажлын хэсэг байгуулсан засаг даргын захирамж гарсан байна. Улмаар аймгуудын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болон гишүүд, Аймгийн ерөнхий архитектор болон Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэсийн мэргэжилтнүүдтэй холбогдож, мэдээ мэдээлэл солилцон ажиллаж байна.

Хүснэгт 1. Ажлын хэсгийн захирамж, огноо

| № | Аймгууд | Захирамжийн дугаар | Огноо |
|---|---|---|---|
| 1 | Дорнод | А/323 | 2018.07.24 |
| 2 | Сүхбаатар | А/383 | 2018.08.03 |
| 3 | Хэнтий | А/280 | 2018.08.13 |
| 4 | Орхон | А/488 | 2018.07.30 |
| 5 | Дархан-Уул | | |
| 6 | Төв | А/506 | 2018.08.03 |
| 7 | Өмнөговь | А/836 | 2018.07.25 |
| 8 | Дорноговь | А/576 | 2018.07.20 |
| 9 | Говьсүмбэр | А/248 | 2018.07.27 |
| 10 | Дундговь | А/371 | 2018.09.15 |
| 11 | Увс | | |
| 12 | Баян-Өлгий | | |
| 13 | Ховд | А/465 | 2018.08.09 |
| 14 | Говь-Алтай | | |
| 15 | Сэлэнгэ | | |
| 16 | Баянхонгор | | |
| 17 | Хөвсгөл | А/427 | 2018.08.03 |
| 18 | Өвөрхангай | А/464 | 2018.07.19 |
| 19 | Архангай | А/402 | 2018.08.10 |
| 20 | Булган | А/496 | 2018.08.08 |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | Завхан | | |

## 3.3 Салбарын уулзалт хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах

Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын хүрээнд “Эрдэмтдийн цуврал лекц”-ийг календарчилсан төлөвлөгөөний дагуу 2018 оны 10 дугаар сарын 11,12,16-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг лекцийг зохион байгуулснаар салбар бүрийн эрдэмтдийн олон жилийн судалгаа шинжилгээ, тэдгээрийн үр дүнгийн талаар мэдээлэл авах, хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох ач холбогдолтой юм.

Хүснэгт 2. Эрдэмтэн судлаачдийн лекцийн сэдвүүд

| № | Нэр | Албан тушаал | Сэдэв | Утас |
|---|---|---|---|---|
| 1. | Д.Баттогтох доктор | ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн захирал, судлаач | Аж үйлдвэрийн байршил төлөвлөлтийн судалгаа | 99991769 |
| 2. | Ц.Сүхбаатар, профессор, ш/у-ны доктор | Олон Улсын Улаанбаатарын Их сургуулийн дэд захирал | Монгол Улсын хөгжлийн бодлогыг орон зайн төлөвлөлт, бүсчилсэн хөгжилтэй уялдуулах нь | 99116271 |
| 3. | Ц.Болормаа, доктор | МУИС, Хүн амын сургалт судалгааны төвийн захирал | Хүн амын шилжилт хөдөлгөөний судалгаа | 99078000 |
| 4. | Б.Чинзориг | АХБ-ны судлаач | Хөрөнгө оруулалтыг орон нутагт үр ашигтайгаар төлөвлөх нь | |
| 5. | А.Дашцэрэн, доктор | ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, цэвдэг судлаач | Монгол оронд тархсан цэвдгийн онцлог ба нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө | 99800180 |
| 6. | М.Алтанбагана, дэд профессор, доктор | ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, | Хөгжлийн орон зайн төлөвлөлт ба нутагшилт, суурьшлын асуудал | 90118868 |
| 7. | Т.Чулуун, доктор | МУИС, ТХХ-ийн захирал, уур амьсгалын өөрчлөлт, экосистем судлаач, | Хүн амын нутагшилт суурьшлын тогтвортой хөгжил | 88114416 |
| 8 | Д.Пүрэвбаяр, судлаач | Эрчим хүчний хөгжлийн төлөө Монголын нийгэмлэгийн захирал, | Эрчим хүчний салбарын бодлого төлөвлөлт, хот суурингийн эрчим хүчний хангамж, техник технологи | 88682888 |
| 9 | Ж.Энхмаа, доктор | Стратегийн судалгааны хүрээлэн | Хүн амын удмын сан, төрөл ойртолтын өнөөгийн байдал | 99012859 |
| 10 | Б.Цэцэгсайхан, доктор | Хавдрын үндэсний зөвлөл | Эрүүл мэндийн үйлчилгээний газруудын байршил, төлөвлөлтийн судалгаа | 94009898 |




*Аж үйлдвэрийн байршил төлөвлөлтийн судалгаа танилцуулга лекц*




*Монгол Улсын хөгжлийн бодлогыг орон зайн төлөвлөлт, бүсчилсэн хөгжилтэй уялдуулах нь лекц*







*Хүн амын шилжилт хөдөлгөөний судалгаа лекц*




*Хөрөнгө оруулалтыг орон нутагт үр ашигтайгаар төлөвлөх нь лекц*




*Хөгжлийн орон зайн төлөвлөлт ба нутагшилт, суурьшлын асуудал лекц*




*Монгол оронд тархсан цэвдгийн онцлог ба нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө лекц*




*Хүн амын нутагшилт суурьшлын тогтвортой хөгжил лекц*






*Хүн амын удмын сан, төрөл ойртолтын өнөөгийн байдал*




*Эрүүл мэндийн үйлчилгээний газруудын байршил, төлөвлөлтийн судалгаа лекц*



*Эрчим хүчний салбарын бодлого төлөвлөлт, хот суурингын эрчим хүчний хангамж лекц*

# IV. СУУРЬ СУДАЛГААНЫ ХЭСЭГ

## 4.1.Судлагдсан байдал

Хөгжлийн орон зайн оновчтой төлөвлөлт, засаг захиргааны хуваарийн шинэчлэл, хот суурин газрын хөгжил, хөрөнгө оруулалтыг оновчтой хуваарилах асуудлыг шийдвэрлэх нэг үндэс нь хүн амын нутагшилт суурьшлын зохистой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх явдал юм.

Монгол Улсын хүн амын нутагшилт, хот, суурин газрын сүлжээг бүс нутгийн түвшинд тэдгээрийн уялдаа холбоо, харилцан үйлчлэлийн хүрээнд системийн хандлагад тулгуурлан цогцоор нь судалсан судалгаа, шинжилгээний ажил ховор байна[1].

Хүн амын нутагшилт, суурьшилтай холбоотой судлагдсан байдлын судалгааг дараах 3 сэдвийн хүрээнд ангилж болно. Үүнд:

- Хүн амын нутагшилт, суурьшил
- Бүсчилсэн хөгжил
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийнн хуваарь

<u>Бүсчилсэн хөгжлийн хүрээнд:</u>

Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгааг ЖАЙКА-гийн дэмжлэгтэйгээр 2016 онд хийсэн бөгөөд тус судалгаагаар коридорын зарчмаар хөгжүүлэх үндсэн санаанд тулгуурлан Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн стратегийн хүрээнд нутгийн хойд хэсгийн газар тариалан, мал аж ахуйн бүс, өмнөд хэсгийн уул уурхайн бүс, түүнчлэн аялал жуулчлал, үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг хөгжиж буй салбарууд байрласан бүс орон нутгийг эдийн засгийн корридор болгон авч үзэж, хөгжлийн тэнхлэг, корридорийн зарчмаар хөгжүүлэх боломжийг авч үзсэн.

Л.Цэдэндамба (2005) нарын эрдэмтэд эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох арга зүйн асуудлыг[2] онолын үндэс, судалгааны аргазүйгээр тодорхой дэвшүүлэн тавьсан. Тэрээр бүс, аймгийн хөгжлийн дэд бүтцийн индексийг тооцох аргачлалыг тодорхойлсон байдаг.

<u>Хүн амын нутагшилт, суурьшлын хүрээнд:</u>

Судлаач М.Баянтөр “Манай улсын хот суурин газруудын хүн амын тооны 1956-1969 оны хоорондох өсөлтөд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тэдгээрийг бага хот (10 мянга хүртэл хүн амтай), дунд зэргийн хот (10-100 мянган хүн амтай),том хот (100-аас дээш мянган хүн амтай) гэж 3 ангилсан байна[3]. Мөн тэрээр өөрийн судалгааны бүтээлдээ хот суурин газруудын нийгэм-эдийн засаг, засаг захиргааны чиг үүргийн ялгаа, хэв шинжийг тод томруун гаргаж ирсэн байдаг. Гэхдээ энэхүү судалгаа нь хот, суурин газрын зөвхөн энгийн ангилалд түлхүү тулгуурласан байна.

[1] Л.Цэдэндамба ба бусад. Эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох арга зүйн асуудалд. ҮХХ, Монгол Улсын хөгжлийн судалгаа
[2] Л.Цэдэндамба ба бусад. 2002. Эдийн засгийн бүсийн хөгжлийн тулгуур төвийг илрүүлэн тогтоох аргазүйн асуудалд.
[3] М.Баянтөр. 1973. БНМАУ-ын Хот суурингийн газарзүй

Дэд бүтцийн хөгжлийн яамны (*хуучин нэрээр*) Зураг төсөл, судалгааны үндэсний төвөөс боловсруулсан “Монгол Улсын хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төсөл”-д манай орны хот тосгоны ангилал, томоохон хотуудын хөгжлийн хэтийн төлөвийг бүлэг суурингийн тогтолцоонд үндэслэн тодорхойлжээ. Судлаачдын үзэж байгаагаар эхлээд хүн амын нутагшилтын янз бүрийн түвшний тогтолцоог судлан илрүүлж, улмаар энэхүү тогтолцооны хүрээнд тэдгээрийн бүтэц, үүрэг, хувьсал өөрчлөлт, нөлөөлж буй хүчин зүйлс (эдийн засгийн, нийгмийн, байгалийн г.м)-ийг нь тооцон үнэлэх замаар хот, суурин газрын сүлжээг зэрэглэх учиртай гэж үздэг.

Судлаач Д.Сайн-Эр: “... Дэд бүтцийн үндсэн сүлжээний хувьд улсын хөгжлийг тэтгэх хэвтээ гол тэнхлэг болон бүс нутгийн хөгжлийн босоо тэнхлэгийн огтлолцол дээр бүс нутгийн тулгуур төвүүд Ховд, Улиастай, Арвайхээр, Улаанбаатар, Чойбалсан хот байх болно ...” гэж үзжээ[4]. Судлаач Д.Пүрэв Монгол Улсын хотуудын улс орны хөгжилд нөлөөлсөн түүхэн хүчин зүйл, ерөнхий үүргээр нь тоймлон нийслэл хот, аж үйлдвэрийн зангилаа хот (Дархан, Эрдэнэт, Багануур, Тосонцэнгэл, Зүүнхараа, Бор-Өндөр), аймгийн төв гэж 3 ангилжээ[5]. Барилга, архитектурын корпораци 1996 онд “Архитектур, хот байгуулалт–1”, “Архитектур, хот байгуулалт–2” төслийн хүрээнд Монгол Улсын хот, суурин газрын үүсэл хөгжлийн түүх, тэдгээрийн архитектур, орон зайн төлөвлөлт, бүтэц, ангиллыг судалснаас гадна хүн амын нутагшилтыг системийн хандлагын үүднээс судалж, хүн амын нутагшилтын 4 бүс, 12 дэд бүс бүхий системийг анх удаа илрүүлж, товч тодорхойлолт өгчээ[6].

Мөн газарзүйч доктор Д.Базаргүр хүн амын нутагшилтын систем зах зээлийн харилцааны нөхцөлд төв зам, тэнхлэгүүдийг дагасан хүн амын төвлөрөл, түүнийг дагасан хөгжил, засаг захиргааны хуваарь бүхий тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлалыг гаргаж ирсэн. Тэрээр нүүдэлчдийн соёл иргэншлийг суурьшмал иргэншилд шилжүүлэх асар их “шинэчлэл” хийх хувьсагч шинж чанартай бөгөөд энэхүү шинэчлэл нь тэнхлэгийн бүс нутгийн хүрээнд тод илэрнэ гэж газарзүйч Д.Базаргүр (2008) үзсэн[7].

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн хүрээнд:

Судлаач Б.Баттүвшин (2006) нар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх нь зайлшгүй бөгөөд энэхүү шинэчлэлийг хийхдээ орон нутаг бие даан хөгжих, нутгийн өөрөө удирдлагын механизмд тулгуурласан байх нь илүү оновчтой гэж үздэг. Мөн судлаач Т.Чулуун (2005) нар олон зууны туршид уламжлагдсан хөгжиж ирсэн сэргэн хөгжих, дасан зохицох чадавхи бүхий хэд хэдэн сумдыг багтаасан хэд хэдэн байгалийн бүсийг багтаасан хангай говь хосолсон засаг захиргааны хуваарийг тогтоох саналыг дэвшүүлсэн бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах ач холбогдолтой гэж үзсэн байдаг.

Судлаач доктор Г.Жаргал “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь” (2018 он) бүтээлдээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийфн хувуурийн түүхэн хөгжил, өөрчлөлтийг үе шаттайгаар тодорхойлон гаргаж ирж, улс орнуудын орон нутгийн засаг захиргааг байгуулдаг нийтлэг аргаар өөрийн орныг харьцуулан жишиж, үр

[4] Д.Сайн-Эр. 1999. Монголыг хөгжүүлэх шинэ төсөл. Монголын барилга сэтгүүл х6
[5] Д.Пүрэв. 1987. Вопросы формирования и развития городов и поселков в МНР. х278-282
[6] Д.Хайсамбуу, Л.Цэдэндамба, С.Намжилмаа. 1996. Архитектур хот байгуулалт-II төслийн эш тайлан
[7] Д.Базаргүр. 2008. Монголын Эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлалын агуулга.

дүнгээ тодорхойлж гаргаж ирснээс гадна засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг боловсронгуй болгох нээлттэй саналуудыг гаргаж дэвшүүлсэн.

Монголын хүн ам дахь гэрлэлт ба цус ойртолтын талаархи судалгааны бүтээлдээ доктор Ж.Батсуурь болон Э.Энхмаа (2010 он) нар бүтээлдээ Монгол Улсын хүн ам дахь гэрлэлтийн тогтолцоонд нэг баг, нэг сум, нэг аймгийн хүмүүс хоорондоо гэрлэх үзэгдэл илт давамгайлах болсон нь хүн амын дотор шууд болон алсуур цус ойртолтын түвшинг өсгөх ноцтой шалтгаан болж байгааг дурьдсан. Тухайлбал хүн амын нягтшил сийрэг говийн бүс болон сумдын хөдөөгийн багт энэ үзүүлэлт өндөр байгааг судалгааны үндэслэлтэйгээр гаргаж ирсэн.

Урьд өмнө хийгдсэн томоохон төслүүд, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх, харьцуулах зорилготой 1996 онд боловсруулсан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн зураглал болон тайлбар бичгийн материалуудтай танилцах чиглэл тус бүрээр мэдээллийн сан үүсгэх, хот байгуулалтын чиглэлээр өмнө хийгдсэн төсөл хөтөлбөрүүдийг судлах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 1992-1995 онд Дэд бүтцийн хөгжлийн яамны харьяа байгууллага болох Зураг төсөл, судалгааны үндэсний төвд “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг анх боловсруулсан. 2000 оноос “Хот байгуулалт” ТӨҮГ-т УИХ, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу уг төслийн зарим хэсэгт тодотгол хийсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2000 оны 49 дүгээр захирамжаар “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг “Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-тай уялдуулан боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажилласан бөгөөд “Улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэг-Мянганы зам болон дэд бүтцийн босоо таван тэнхлэгийн чиглэл”-ийг УИХ-ын 2001 оны 09 дүгээр тогтоолоор “Бүсийн тулгуур төв хотууд”-ыг УИХ-ын 2003 оны 01 дүгээр тогтоолоор тус тус батлуулсан. Монгол орны нутаг дэвсгэрт төр, засгаас хэрэгжүүлэх хүн амын нутагшилт, ойрын ирээдүйн хөгжлийн бодлогыг цогцолбороор тодорхойлох оролдлогыг агуулсан анхны энэ ерөнхий төсөлд урьд өмнө боловсруулсан томоохон төсөл төлөвлөгөөнүүд болон 20 гаруй жилийн судалгааны материалыг ашигласнаас гадна бүх салбарын холбогдох эрдэмтэд судлаачид мэргэжилтнүүд оролцсон.Төслийн бүрдэл нь 9 бүлэг бүхий тайлбар бичиг, үндсэн зураг 3, нэмэлт 21 зургаас бүрдэнэ.

Монгол улсын нийгмийн дэвшил, хөгжлийн шинэ зорилт өмнөө тавьж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд тууштай шилжихтэй холбогдуулж 1992 онд тунхагласан шинэ Үндсэн хууль түүний хүрээнд улс орны хөгжлийн чиг баримтлалыг тодорхойлон хэрэгжүүлэх нийтлэг хандлага 1995 оны ерөнхий төслийг боловсруулах үндэслэл болсон.

1995 онд 1993 оны үнэлгээгээр дотоодын нийт бүтээгдэхүүний бодит хэмжээ 180.7 тэрбум төгрөг, үүнээс 79 хувь буюу 309.1 төгрөгийн бүтээгдэхүүн аж үйлдвэр, хөдөө аж ахуй худалдаа, материал техник хангамжийн салбарт оногдож байжээ.

1996 оны төслөөр хүн амын хэтийн төлөвийг гурван хувилбараар тооцож гаргасан бөгөөд 2017 оны жилийн эцсийн хүн амын тоотой харьцуулан дүгнэхэд хамгийн ойртсон 1 дүгээр хувилбар нь 216650 –аар хүн амаа өсгөж тооцжээ.

Хүснэгт 3. 1996 оны төслийн хүн амын төлөвлөлт

| № | Агуулга | он | Хувилбар | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 |
| 1 | 1995 төслөөр | 2017 | 3,348,400 | 3,395,500 | 3,433,300 |
| 2 | 2017 оны жилийн эцэс | 2017 | 3,131,750 | 3,131,750 | 3,131,750 |
| | Зөрүү | | 216,650 | 263,750 | 301,550 |

Улсын Их Хурал 2001 онд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан бөгөөд Монгол Улсад Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн 4 бүсийг тогтоож Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэхээр тусгаж, 2003 онд бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги /2010 он хүртэл/-ийг, мөн Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохиуцуулалтын тухай хуулийг тус тус баталсан. Бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих бодлогын гол чиглэл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, тэдгээрийн орчмын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл удирдлагын төвлөрөл, экологийн тэнцвэр алдагдлыг сааруулж бүсүүдийн хөгжлийн түвшинг дээшлүүлэх зорилготой байв. Монгол Улсыг тухайн үед бүсчилсэн байдал одоогийн нөхцөлд таарахгүй, хүн амын хэт төвлөрөл Улаанбаатар хот руу чиглэсэн нүүдэл өнгөрсөн 17 жилийн хугацаанд хэвээр байгаа нь нутаг дэвсгэрийг дахин бүсчлэн хөгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Өмнө боловсруулагдсан төслийн хүрээнд УИХ-ын архив, Улсын төв архиваас УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, тухайн үеийн “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэгдсэн мэдээлэл зэргийг судалж судлагдсан байдлын судалгааг гаргахаар ажиллаж байна.

## 4.2.Онолын үндэс, аргачлал

Судлаачид хот, суурин газрын зэрэглэл, эдийн засгийн бүсийн хөгжлийн тулгуур төвийг судлахдаа юуны өмнө “*Аливаа улсын болон бүс нутгийн хэмжээний хот, суурин газрын орон зайн байршил, тархалт нь ямар нэгэн зүй тогтлыг агуулж байна уу?*” гэдэг асуултад хариулт өгөхийг зорьсоор иржээ. Эрдэмтэд тодорхой нэг хот хөгжүүлэх үзэл баримтлалаас хот, суурин газрын сүлжээ байгуулах үзэл баримтлалд шилжсэн.

*Тогтвортой хөгжил бүхий хүн амын нутагшилт суурьшлын бодлого*

1990 он гарснаас дунд зэргийн болон хөгжиж буй орнуудад хотжилт эрчимтэй хөгжжээ. 2009 онд дэлхийн нийт хүн амын 50.0 хувь хотод суурьших болсон бөгөөд ялангуяа том хотуудын хүн амын энэхүү эрчимтэй өсөлтийг дагаад хүрээлэн буй орчны доройтол, хотын дэд бүтцийн даац хэтрэх, хот, хөдөө орон нутгийн хөгжлийн ялгаа ихсэх, хотын ажилгүйдэл, ядуурал, бүс нутгийн тэнцвэрт бус хөгжил, ядуусын хороолол тэлэх зэрэг нийгэм-эдийн засгийн сөрөг үр дагавар ихээр гарсан. Иймэрхүү сөрөг үр дагаврыг хамгийн ихээр мэдэрсэн орнууд нь Латин Америкийн Мексик, Бразил, Африкийн Египет, Ардчилсан Конго, Сенегал, Кот Д’Ивуар, Нигери, Азийн Бангладеш, Монгол, Энэтхэг, Пакистан, Индонез зэрэг орнууд юм. Иймд хүн амын тогтвортой хөгжил бүхий нутагшилт суурьшлын бодлого шинээр гарч ирсэн. Үндсэн санаа нь хэт том хотын төвлөрлийг сааруулахын тулд дунд хотуудыг дэмжих, мөн том хотын дэргэд дагуул шинэ хот байгуулах хандлага юм[8]. Энэхүү бодлогыг Латин Америкийн орнууд хэрэгжүүлж, хотын

[8] Sustainable development of human settlements: Achievements and challenges in housing and urban policy in Latin America and the Caribbean, UN, 1998

ядуурлыг бууруулж нийгмийн тэгш байдлыг бий болгох, хотын хүн амын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, засаглалыг сайжруулж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, үр ашигтай бодлого, удирдлагыг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Шилжих хөдөлгөөнийг судалдаг эдийн засгийн хөгжлийн загварууд, шилжих хөдөлгөөний хүчин зүйлс, "хэмжээлшгүй том хот"-ын онол зэрэг хэд хэдэн онолын урсгал байдаг. **Луисийн онол** нь 1954 онд анх гарсан бөгөөд хөгжиж буй орныг уламжлалт хөдөө аж ахуй, орчин үеийн аж үйлдвэр гэсэн эдийн засгийн үндсэн хоёр салбартай гэж үздэг. Уламжлалт хөдөө аж ахуйн салбарыг бүтээмж муутай, орлого багатай, санхүүгийн хуримтлал үүсгэх боломж муу, бүрэн бус ажил эрхлэлттэй гэж төсөөлдөг. Эдийн засгийн систем нь ийм хоёр салбартай байхад хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн явагдана гэж Луис үзсэн. Луисийн загвараар бол шилжих хөдөлгөөний урсгал нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой юм. Хөгжиж байгаа орны шилжих хөдөлгөөнийг тайлбарладаг эдийн засгийн өөр нэг загвар бол **Харрис болон Тодарогийн (1970) загвар** юм. хөгжиж буй улс оронд ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлтийн түвшин өндөр байдаг тул хөдөөгөөс хот руу шилжихэд шууд ажил олох магадлал өндөр биш байдаг гэж үздэг[9].

Шилжих хөдөлгөөний онолын бас нэг урсгал нь **шилжих хөдөлгөөний хүчин зүйлс** юм. Ихэнхи тохиолдолд гэрэлтэй хот өндөр цалин, орлого зэрэг хүчин зүйлд татагдан хүмүүс шилжих хөдөлгөөнд ордог гэж үзэж байсан. Гэтэл Ли (1956) анх удаа татах хүчээс гадна түлхэх хүч байдаг гэж үзсэн. Түүнээс хойш түлхэх, татах хүчин зүйлсийн онол гарсан байдаг.

Зураг 1. Шилжилт хөдөлгөөний хүчин зүйлс




Шилжих хөдөлгөөний онолын өөр нэг урсгал бол "**хэмжээлшгүй том хот**"-ын онол юм. Газарзүйч Мак Жефферсон (1939) анх удаа хэмжээлшгүй том хотын онолыг бий

[9] ҮСХ. 2012. Шилжих хөдөлгөөн суурьшил: Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого

болгосон. Энэхүү хот нь хүн амын тоогоор бусдаасаа ядаж 2 дахин том байдаг. эдгээр хот нь ихэнхи тохиолд тухайн улсынхаа нийслэл байдаг. Жишээлбэл Францын Парис, Их Британийн Лондон, Тайландын Бангкок хотуудыг нэрлэж болно. Гэтэл хүн ам олонтой зарим хотод хэмжээлшгүй том хот байдаггүй. Тухайлбал Энэтхэгт хамгийн том хот Мумбай 16 сая хүнтэй байхад 2 дахь том хот Калькутта 13 сая хүнтэй байдаг. Мөн Хятад, Канад, Австрали, Бразил зэрэг улс оронд хэмжээлшгүй том хот байдаггүй. Хөгжиж буй улсын хувьд хэмжээлшгүй том хот нь үйлдвэржсэн хот биш ч гэсэн хүн амын тоо, дотоод зах зээл, боловсрол эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг үзүүлэлтээрээ хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг зайлшгүй татдаг. Үүний нэг тод жишээ нь Улаанбаатар хот бөгөөд primate city index буюу хамгийн том хот нь 2 дахь том хотоосоо 15 дахин их хүн амтайгаар дэлхийд 4-рт орж байна. Иймд хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулахын тулд хүн амын шилжих хөдөлгөөнийг татах болон түлхэх хүчин зүйлсийг оновчтой байршуулахад анхаарах хэрэгтэй юм.

**Хүснэгт 4.** Дэлхийн улсуудын хамгийн том болон хоёрдогч том хотуудын харьцуулсан судалгаа

| № | Том хотууд | Улс | **Primate city index** | Хүн ам, мянгаар | | Том хотын хүн амын өсөлтийн хувь | Нийт хотын хүн амд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хамгийн том | Хоёрдогч | 2005-2015 | 2015 |
| 1 | Бангкок | Тайланд | **22.2** | 5686 | 256 | 2.49 | 27.3 |
| 2 | Монрови | Либери | **17.9** | 1021 | 57 | 0.50 | 56.5 |
| 3 | Ломе | Того | **17.5** | 1859 | 106 | 2.79 | 33.4 |
| **4** | **Улаанбаатар** | **Монгол** | **14.7** | **1396** | **95** | **3.89** | **65.4** |
| 5 | Монтевидео | Уругвай | **12.5** | 1304 | 104 | 0.57 | 52.2 |
| 6 | Минск | Беларусь | **12.5** | 1834 | 147 | 0.76 | 27.0 |
| 7 | Лима | Перу | **11.4** | 9886 | 869 | 2.03 | 40.4 |
| 8 | Бужумбура | Бурунди | **10.6** | 497 | 47 | 6.00 | 57.6 |
| 9 | Хартум | Судан | **10.4** | 5129 | 492 | 2.54 | 38.3 |
| 10 | Аддис-Абеба | Этиоп | **9.8** | 3352 | 343 | 2.06 | 16.8 |
| 11 | Ереван | Армен | **8.8** | 1060 | 121 | -0.40 | 55.7 |
| 12 | Конакри | Гвиней | **8.5** | 1660 | 195 | 3.06 | 42.2 |
| 13 | Буэнос-Айрес | Аргентин | **8.4** | 13473 | 1613 | 1.30 | 39.2 |
| 14 | Абижан | Кот Д'Ивуар | **8.2** | 4395 | 536 | 3.15 | 42.1 |
| 15 | Наукшот | Мавритани | **8.1** | 958 | 118 | 3.70 | 39.6 |
| 101 | Хо Ши Мин | Вьетнам | **2.0** | 7298 | 3629 | 5.19 | 11.6 |
| | Нийт том хотууд | | **3.9** | 364555 | 94067 | 2.26 | 30.63 |

ХБНГУ-ын эрдэмтэн В.Кристаллер "Өмнөд Герман дахь төв байршил" номондоо анхны гол санааг дэвшүүлж, түүнийг "Төв байршлын онол"[10] гэж нэрлэжээ. Хэрэв хүн амын нягтшилт, зам тээврийн нөхцөл, байгалийн нөөц, хүн амын худалдан авах чадвар зэрэг нь тодорхой нутаг дэвсгэр дээр жигд үзүүлэлттэй, өөрөөр хэлбэл ялгаа байхгүй

[10] В.Кристаллер. Өмнөд Герман дахь төв байршил. 1933.

байна гэж хийсвэрлэн авч үзвэл тийм нутагт байгаа суурин газрууд нь тодорхой зүй тогтлын дагуу байршсан байх ёстой гэж үздэг (В.Кристаллер, 1966).

Гол төв болох суурин газар нь 6 өнцөгт торны төвд байх бөгөөд 6 суурин газар нь уг торны 6 өнцөгт байршсан байх зүй тогтол байна гэж үздэг. 7 суурин газраас бүрдсэн уг 6 өнцөгтийг хүрээлээд бүс нутгийн хот суурингийн сүлжээг буюу 49 (7*7) суурин газар бүхий сүлжээг бүрдүүлэх зүй тогтолтой гэж үзжээ.

Байгалийн нөөц, хүн амын нягтшилт, үйлдвэржилт, зам тээврийн боломж, ажил эрхлэлт, хүмүүсийн худалдан авах чадвар зэрэг нь тухайн бүсийн хэмжээнд ямар ч ялгаваргүй жигд байх тохиолдол ховор байх учраас энэхүү онолыг шууд хэрэгжүүлэх боломжгүй байж болно. Гэхдээ В.Кристаллерийн санаа нь хүн амын нутагшилт болон хот, суурин газрын сүлжээний орон зайн зохион байгуулалт, харилцан үйлчлэлийн хүрээг илрүүлэх эрэл хайгуулын эхлэлийг тавьснаараа онолын сэтгэлгээний хөгжилд онцгой нөлөө үзүүлсэн гэж олонхи судлаачид үздэг. Энэхүү онол нь хэвтээ чиглэлээр хот суурин газруудын зэрэглэл, оновчтой байршлыг тодорхойлоход чиглэж байгаа юм.

Хот, суурин газрын тухайн бүс нутагт эзлэх байр суурийг босоо чиглэлээр оновчтой загварчлах талаархи “Цифпийн дүрэм”-ээр аливаа хотын хүн амын тоо (жишээлбэл “А” хот) нь тухайн нутгийн хамгийн том хотын (“В” хот гэе) хүн амын тоог “А” хотын ангиллын дугаарт харьцуулсан утгатай тэнцүү болохоор өсч тэмүүлж байдаг гэсэн дүгнэлт юм. Цифпийн дүрэм нь нутагшилтын тогтолцоог судлахад тохиромжтой гэж судлаачид үздэг.

Өнгөрсөн зууны 60-аад оноос системийн хандлагад тулгуурлан хүн амын нутагшилт, хот, суурин газрын сүлжээний хөгжлийн асуудлыг судлах чиглэл түлхүү хөгжиж, бүс нутгийн төлөвлөлт, хот байгуулалтын холбогдолтой судалгаа шинжилгээний бүтээлүүдэд **“бүлэг суурингийн тогтолцоо”** гэсэн ойлголтыг авч үзэх болжээ. Хот, суурин газрын сүлжээний **нягтшилт, байршилтад** тулгуурлан тэдгээрийн орон зайн буюу нутаг дэвсгэрийн тогтолцоог илрүүлэхэд гол агуулга нь чиглэсэн байдаг.

XX зууны 80-аад оноос энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний ажил системийн хандлагад тулгуурлах явдал улам бүр гүнзгийрч, хот суурин газрыг дангаар нь бус харин тэдгээрийг улсын болон эдийн засгийн бүсийн хэмжээний **хүн амын нутагшилтын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг** гэж авч үздэг болж, юуны өмнө улсын болон эдийн засгийн бүсийн хүн амын нутагшилтын янз бүрийн түвшний тогтолцоог илрүүлсний дараа нөлөөлж буй хүчин зүйлсийг тооцон тэдгээрийн түвшинд, хот, суурин газрын сүлжээнд дүн шинжилгээ хийх замаар ангилал, зэрэглэлийг нь тогтоох хандлагыг түлхүү баримтлах болжээ. Орчин үеийн хотжилтын үйл явц, түүний хүрээнд экологийн асуудлуудыг шийдвэрлэхэд ч ихээхэн анхаарах болсон байна[11].

Өнөө үед энэ чиглэлийн судалгаанд хот, суурин газрын үүрэг, тэдгээрийн харилцан үйлчлэлийн төлөв байдал, хувьсал өөрчлөлт, нягтшилт, байршилтыг гол шалгуур үзүүлэлт болгож байна.

**ХАА-н газар ашиглалтын загвар буюу Тюнений цагирган сүлжээ:** Зах зээл, тээврийн өртөг зардал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн улирлын онцлог зэргээс хамаарч

[11] Л.Цэдэндамба ба бусад. 2002. Эдийн засгийн бүсийн хөгжлийн тулгуур төвийг илрүүлэн тогтоох аргазүйн асуудалд.

хотыг хүрээлсэн цагирган хэлбэртэй газар ашиглалтын тогтолцоог В.Тюнен (1826) загварчлан гаргасан.

**Зураг 2. Тюнений загвар**




Тюнений загвараар цагаан тойрог доторхи хар цэг нь хот, 1 буюу цагаан тойрог нь сүү, цагаан идээний аж ахуй, 2 нь түлш, барилгын материалд зориулагдсан ойн аж ахуй, 3 нь газар тариалангийн аж ахуй, 4 нь бэлчээрийн мал аж ахуй, гаднах хар ногоон өнгөтэй хэсэг нь онгон зэлүүд газрыг төлөөлдөг (Зураг 1)[12]. Зах зээл, тээврийн өртөг, газрын түрээс, газар ашиглалтын хэлбэрийг тооцсон хэдий ч тухайн бүс нутагт хөрсний үржил шим, газрын гадаргын хэлбэр, тээврийн зардал зэрэг нь харилцан адилгүй байдаг тул тэр бүр энэ загварыг хөгжүүлэх боломж хязгаарлагдмал юм.

Хүн амын суурьшил нутагшлыг судлахад 1970-аад оноос математик загварчлалын аргуудыг өргөн хэрэглэх болжээ. Мөн газар зүйн зураглалын арга хэрэглэдэг.

Тодорхой нутаг дэвсгэр дээр хүн ам хэр зэрэг жигд нутагшиж суурьшсан байгаа нь хүн амын нутагшилт суурьшлын гол илэрхийлэл юм. Үүнийг тодорхойлохын тулд зэргэлдээ оршдог суурин газруудын хоорондын зайг тооцож, тэдгээрийн дунджаар шинжилгээ хийх арга хэрэглэдэг:

$$R_n = \frac{\bar{D}}{0.5\sqrt{\frac{S}{n}}},$$

Үүнд:

$R_n$ – суурин газруудын бөөгнөрлийг тодорхойлох үзүүлэлт;
$\bar{D}$ – зэргэлдээ орших суурин газруудын хоорондын зайны дундаж;
S – судалж буй газар нутгийн хэмжээ;
n – суурин газрын тоо.

Хэрвээ суурин газрууд жигд байрласан бол энэ үзүүлэлт хамгийн их утга буюу 2,15-д дөхнө. Хэрвээ хүн ам нэг сууринд амьдардаг бол үзүүлэлт 0-той тэнцүү, эмх замбараагүй суурьшсан бол 1-тэй тэнцүү байдаг.

Тодорхой нутаг дэвсгэр дээр хүн ам хэр зэрэг жигд нутагшиж суурьшсан байгааг нутаг дэвсгэрийн бөөгнөрлийн индексээр мөн илэрхийлж болно.Уг индексийг дараах томьёогоор тодорхойлдог:

[12] http://en.wikipedia.org/wik i/Johann_Heinrich_von_Th%C3%BCnen

$$К_{т.к.} = 1/2\ |S_i - P_i|\ 100\%,$$

Үүнд:

$S_i$ – Тухайн улсын нийт нутаг дэвсгэрт i дугаар бүсийн газар нутгийн эзлэх хувийн жин;

$P_i$ – Тухайн улсын нийт хүн амд i дугаар бүсийн хүн амын эзлэх хувийн жин.

## 4.3. Хууль, эрх зүйн байдлын судалгаа

Хот байгуулалт, нутагшилт суурьшилтай холбоотой эрхзүйн баримт бичгүүдийг уншиж судлах, эрх зүйн баримт бичгийн сан үүсгэх, хүн амын нутагшилт, суурьшилтай холбоотой зүйл заалтуудыг тодруулах, ажлуудыг эхний байдлаар хийж гүйцэтгэж байна. Монгол Улсын үндсэн хууль, Хот байгуулалтын тухай хууль, бусад салбар хууль тогтоомж, үзэл баримтлал, бодлого төсөл хөтөлбөрүүдэд тусгагдсан байдлыг судлах ажлуудыг хийж байна. Мөн өмнө нь УИХ, Засгийн газраас гарсан тогтоол шийдвэрүүд, хуралдааны тэмдэглэлийг УИХ-ын архив мөн Улсын төв архивт сууж танилцах ажлуудыг хийж байна.

“Хот байгуулалтын тухай” Монгол Улсын хуулийн “Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлага” гэсэн 12 дугаар зүйлийн 1-д: “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх шаардлагыг хангасан байна” гэсэн зарчмыг энэхүү судалгаанд баримталсан болно.

Энэхүү хуулийн 12.2 дугаар зүйлд: “Бүс нутгийн хөгжлийн төсөл нь тухайн нутаг дэвсгэрт хот байгуулалтын тодотгосон үнэлгээ хийсний үндсэн дээр бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсийн хөгжлийн тулгуур төв болон нийгэм, соёл ахуйн үйлчилгээний зохистой хүрээгээр бүлэг суурингийн төвийг тогтоон бусад бүс нутагтай харилцан уялдаатай харьцангуй бие дааж хөгжих шаардлагыг хангасан байна”, мөн хуулийн 12.3 дугаар зүйлд: “Чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө нь хот байгуулалтад тавигдах үндсэн шаардлагыг бүрэн хангасан худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал эрхлэх, дэд бүтцийн хангамж нөхцлийг тооцож төлөвлөсөн байна” гэж заасныг удирдлага болголоо.

Хүснэгт 5. Хууль эрхзүйн баримт бичигт тусгагдсан байдал

| | |
|---|---|
| МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ | Тав дугаар зүйл.<br>4. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.<br>**Арван зургадугаар зүйл.**<br>2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; |
| 4 дүгээр бүлэг.<br><br>МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА | Тавин долдугаар зүйл.<br>3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.<br>Тавин наймдугаар зүйл.<br>1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн. |
| ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ | |
| 4 дүгээр зүйл. Хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчим | 4.1 Хот байгуулалт, төлөвлөлтөд дараахь үндсэн зарчим баримтлана<br>4.1.1 Монгол Улсыг хөгжүүлэх Үндэсний хөгжлийн стратегийг хангах<br>4.1.2 Хүний аюулгүй байдал, байгаль, экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах<br>4.1.3 Хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч этгээдийн эрх ашгийг тэгш хангах |
| 11 дүгээр зүйл. Хот байгуулалтын баримт бичиг | 11.1 Хот байгуулалтын баримт бичиг нь дараахь зүйлээс бүрдэнэ:<br>11.1.1 хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл<br>11.1.2 бүсийн хөгжлийн төсөл<br>11.1.3 чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө<br>11.1.4 хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө<br>11.1.5 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө<br>11.1.6 хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө<br>11.1.7 барилга байгууламжын зураг төсөл<br>11.1.8 хот төлөвлөлтийн суурь судалгаа<br>11.1.9 хот суурин газрын дахин хөгжүүлэх төсөл |
| 12 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлага | 12.1 Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл нь Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх шаардлагыг хангасан байна |
| 15 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын санхүүжилт | 15.1.1 хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн ерөнхий төсөл, чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн суурь судалгааг улсын төсвөөс |
| 21 дүгээр зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх | 21.1 хот байгуулалтын үйл ажиллагааг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ<br>21.1.1 хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэхдээ эхний ээлжинд зам тээвэр, эрчим хүч, холбоожуулалтын үндсэн сүлжээг барьж |

| | |
|---|---|
| | байгуулах ажлыг хэрэгжүүлж зохицуулах |
| ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ | Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн үндэс, удирдлагын үйл ажиллагааны зарчим, тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлж, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулахад оршино. |
| 4 дүгээр зүйл. Хотын зэрэглэл | 2. 50000-с дээш /шаардлагатай гэж үзвэл 50000 хүртэл/ оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно. |
| ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ | |
| 5 дугаар зүйл. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэхэд баримтлах зарчим | 5.1 Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д заасан хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:<br>5.1.1 нийтийн эрх ашгийн эрхэмлэх<br>5.1.2 олон нийтийн оролцоог хангах |
| БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ | 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ | Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино. |
| 13 дугаар зүйл.Бүсчилсэн хөгжлийн бодлого | 13.1.Бүсчилсэн хөгжлийн бодлого нь байгалийн баялаг, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглах үндсэн дээр хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулах, төвлөрлийг сааруулах, аймаг, бүс нутаг хоорондын хөгжлийн түвшинг ойртуулах, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэхэд чиглэнэ. |
| 17 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, тавигдах шаардлага | 17.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг доор дурдсан дарааллын дагуу боловсруулна:<br>17.1.1.хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;<br>17.1.2.асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах;<br>17.1.3.бодлогын хувилбарыг доорх шалгуурын дагуу үнэлж, оновчтой хувилбарыг сонгоно:<br>17.1.3.а.дэлхий нийтийн болон бүс нутгийн хөгжлийн хандлага, хамтын ажиллагааг харгалзан өөрийн орны хөгжлийн онцлогийг тусгасан эсэх;<br>17.1.3.б.эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэрт байдалд суурилан тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэх;<br>17.1.3.в.олон нийтийн эрх, ашиг сонирхолд нийцсэн эсэх;<br>17.1.3.г.тэгш, хүртээмжтэй байдлыг хангасан эсэх;<br>17.1.3.д.бодлогын үр ашиг, хэрэгжих үндэслэл бодитой эсэх.<br>17.1.4.хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна. |

| | |
|---|---|
| ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ | |
| 10 дугаар зүйл.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал | 10.1.Монгол Улсын газрын нэгдмэл санг дараахь байдлаар ангилна:<br>10.1.1.хөдөө аж ахуйн газар;<br>10.1.2.хот, тосгон, бусад суурины газар;<br>10.1.3.зам, шугам сүлжээний газар;<br>10.1.4.ойн сан бүхий газар;<br>10.1.5.усны сан бүхий газар;<br>10.1.6.тусгай хэрэгцээний газар. |
| 25 дугаар зүйл.Газар зохион байгуулалтын үндсэн баримт бичгүүд, тэдгээрт тавигдах шаардлага | 25.1.1.улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;<br>25.1.2.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;<br>25.1.3.хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл;<br>25.1.4.нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө;<br>25.1.5.шинээр хот суурин байгуулах, атар газар эзэмших, тусгай хамгаалалттай газар нутгийг бий болгох, томоохон үйлдвэр, уурхай, зам, шугам сүлжээ, бүс нутгийг хамарсан олон улсын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх газар болон чөлөөт бүс байгуулахтай холбогдсон схем, техник эдийн засгийн үндэслэл, газар зохион байгуулалтын зураг, төслүүд;<br>25.1.6.газрын кадастрын зураг, бүртгэл, судалгаа, үнэлгээний материал.<br>25.2.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль, газар зүйн нөхцөл, газрын нөөц, түүний экологи, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхид зохицсон газрын менежментийн бодлогоор улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 16-20 жилийн хэтийн чиглэлийн баримжаатай зураг төслийн баримт бичиг байна.<br>25.3.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь энэ хуулийн 25.2-т заасан хүрээнд боловсрогдсон 12-16 жилийн хугацаанд хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна.<br>25.4.Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх, байршлыг тодорхойлсон жилдээ хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна.<br>25.5.Газрын кадастрын зураг, бүртгэл, судалгаа, үнэлгээний материалууд нь холбогдох хуулийн шаардлагыг хангасан байна. |
| МОНГОЛ УЛСЫН ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ | |
| 3 дугаар зүйл.Инновацийн тэргүүлэх чиглэл | 13.1.Шинжлэх ухаан, технологийн ололтыг эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, өндөр технологийн болон өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох, өндөр үр ашигтай үйлчилгээний төрөл, хэлбэрийг бий болгоход чиглүүлэх, инновацийн чадавх, нөөцийг оновчтой байршуулах, төрийн дэмжлэгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор инновацийн тэргүүлэх чиглэлийг тогтооно.<br>13.2.Инновацийн тэргүүлэх чиглэлийг стратегийн болон дунд хугацааных гэж ангилна.<br>13.3.Стратегийн тэргүүлэх чиглэл 10 жилийн хугацаатай байх бөгөөд Улсын Их Хурал батална.<br>13.6.Дунд хугацааны тэргүүлэх чиглэл нь стратегийн тэргүүлэх чиглэлийг үндэсний, салбарын, бүс, орон нутгийн түвшинд үе шаттайгаар хэрэгжүүлэхтэй уялдаатай боловсруулагдсан байна. |

| | |
|---|---|
| МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ | 1.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна. |
| 18.1.2.Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар: | а/нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;<br>е/ бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжил, хэтийн төлөвийг уялдуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх; |

| | |
|---|---|
| МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ | Монгол Улсын Үндсэн хуулийн "Төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна" гэсэн заалтыг үндэслэл болгон боловсруулсан "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх /цаашид "бүсчилсэн хөгжил" гэх/ арга замыг боловсруулж, бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, **хүн амын нутагшилт**, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдааг хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох чиглэл, үйл ажиллагааны зарчмын үндсийг тодорхойлж байна. |
| | 2.3.5 **Хүн амын нутагшилт**, хот байгуулалтын хүрээнд: тухайн бүсийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн **хүн амын нутагшилт,** суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бүрдүүлж, нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг тэтгэх чадвар бүхий бүс нутаг, хотжилтын нэгдмэл орчныг бий болгох. |
| | 3.2.3. "Бүс нутаг" гэж аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот, тосгоны хоорондын нийгэм, эдийн засгийн харилцаа холбоо, тусгай хамгаалалттай газар нутаг, тэдгээрийн орчны бүс, хүн амын нутагшилт, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон аж ахуйн бусад салбар /салбар хоорондын/-ын уялдаа холбооны орон зайн хөгжил, байршлын хүрээг хамарсан Монгол Улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг буюу эдийн засаг, нийгмийн цогцолборыг; |
| | 3.10.3. **Хүн амын нутагшилт**, суурьшилтын олон төвтэй тогтолцоог бүрдүүлж, суурин болон нүүдлийн амьдралын хэв маягийг оновчтой хослох. |
| | 4.7.4.з. Тухайн бүсийн хүрээнд хот, хөдөөгийн хүн ам амьдрах арга ухаан, хөдөлмөрлөх дадлага, туршлагаа харилцан солилцох, уугуул нутгаа хөгжүүлэх талаар орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах явдлыг хөхүүлэн дэмжих. |

| | |
|---|---|
| | 4.7.5. Хүн амын нутагшил, хот байгуулалтын хүрээнд: |
| | 4.7.5.a. Бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх агуулгаар "**Хүн амын нутагшилт**, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг"-ыг боловсруулж, шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх |
| МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030 | **Зорилт 5.Хүн амын нутагшилт, суурьшлын** зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. |
| | Iүе шат (2016-2020): **“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын** хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг үе шаттай хэрэгжүүлэх, аймгийн төвүүдийн хөгжлийн болон улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх |
| МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2010 ОНЫ 36 ДУГААР ТОГТООЛЫН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ<br><br>"ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР | **4.1.1.1.Хүн амын нутагшилт, суурьшлын** зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтын оновчтой бодлого хэрэгжүүлэх замаар хот, суурины газар ашиглалтыг сайжруулж, эрчим хүч, авто зам, инженерийн дэд бүтцийг шинэ түвшинд хөгжүүлэх; |
| ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ<br><br>БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧИЛСАН ЗААВАР | 1.2.Монгол улсын Үндсэн хуулийн "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна..." гэсэн заалт нь **хүн амын нутагшилт, суурьшил,** бүс нутгийн хөгжлийн бүх шатны төслийн үзэл баримтлал болно |
| | **1.5. Хүн амын нутагшилт, суурьшлын** ерөнхий төсөл нь үндсэн бүсүүдийн хөгжлийн төсөл боловсруулах, бүсийн хөгжлийн тулгуур болон дэд төвүүдийн хөгжлийг тодорхойлох, үндсэн бүсүүдийн хөгжлийн төсөл нь бичил бүс, тэдгээрийн төв, бүлэг суурин болон хот орчмын бүсийн хөгжлийг тодорхойлох үндэслэл болно. |
| | **2.1. Хүн амын нутагшилт, суурьшлын** болон бүс нутгийн хөгжлийн төслийг Хот байгуулалтын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж гүйцэтгэнэ. |
| | 2.9. **Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн** бүх үе шатны ( аймгийн хөгжлийн, бичил бүсийн хөгжлийн, хот орчмын бүсийн хөгжлийн ) төслүүдийг батлуулахын өмнө төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас дүгнэлт гаргуулна |

| | |
|---|---|
| | 2.10. **Хүн амын нутагшилт**, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон бүс нутгийн үе шатны төслүүд тусгайлсан бүс (эдийн засгийн чөлөөт бүс, аялал жуулчлал, амралт сувиллын хөгжлийн төсөл )-ийн төслүүдийг батлахад Хот байгуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөнө |
| | . **Хүн амын нутагшилт**, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл ( улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд) |
| | б. Хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан үндсэн бүс нутгийн хөгжлийн төсөл |
| | в. Аймгийн нутаг дэвсгэрийн хөгжлийн төсөл |
| | г. Нийслэлийн нутаг дэвсгэр (Улаанбаатар муж )-ийн хөгжлийн төсөл |
| | д. Хот орчмын бүс ( дагуул хотуудын тогтолцоо )-ийн хөгжлийн төсөл |
| | е. Сум дундын нутаг дэвсгэрийн хөгжлийн төсөл |
| | 7 /Бүсүүдийн хүрээнд хүн амын нутагшилт, суурьшлыг зохистой болгох нийгэм, соёл, ахуйн үйлчилгээний харьцангуй жигд нөхцөлийг бүрдүүлэх. |
| | **Зорилт 2-ын хүрээнд:**<br><br>**а/хүн амын суурьшин** амьдрах таатай орчныг хангах үүднээс Төв, Сэлэнгэ аймгийн нутагт байгуулагдсан хот, тосгон (Сүхбаатар, Алтанбулаг, Зүүнхараа, Баянчандмань, Баруунхараа, Мандал г.м)-ы нутагшилтын тогтолцоонд гүйцэтгэх үүргийг тодорхой болгож, аж ахуйн зохистой чиглэлээр сэргээн хөгжүүлэх чиглэл баримтлах; |
| УЛСЫН ИХ ХУРЛЫН 2003 ОНЫ 24 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХАВСРАЛТ<br><br>МОНГОЛ УЛСЫН БҮСҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ (2010 ОН ХҮРТЭЛ) | **б/** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд говийн аймаг, сумдад хүн ам хоршин амьдрах "голомт" нутаг (ашиг шимт болон шилмэл омгийн малын бэлчээр нутаг, баян бүрд, мод үржүүлгийн газар, аялал жуулчлалын бааз, уурхайн тосгон г.м)-ууд, тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн судлал, туршилтын төвүүдийг олшруулах, ирээдүй сайтай байрласан сум, аймгийн төвүүдийн хоорондын дэд бүтцийн уялдаа, хоршилтыг сайжруулах зэргээр хүн амын нутагшилт, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын одоогийн тогтолцоог боловсронгуй болгох алхам хийх; |
| | 25/ Бүс нутгийн хөгжил, **хүн амын нутагшилт**, нийгэм, соёлын үйлчилгээний тогтолцоонд хот, суурингийн гүйцэтгэх үүргийг тодорхой болгох, говийн бүсэд, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтцийг сайжруулах хандлагаар бүс нутаг-хот төлөвлөлтийн нэгдмэл арга, зохион байгуулалтыг бүрдүүлж эхлэх; |

| | |
|---|---|
| | **1.** Бүс нутгийн газар, түүний баялгийн төрөл, нөөцийн тархалт нь экологийн эмзэг орчинтойгоо нарийн уялдсан, уугуул хүн амын тоо цөөн, тэдгээр нь ихэвчилэн суурьшин амьдрах (буриад, үзэмчин угсаатнууд сүү, тос боловсруулах, өвс хадлан, мод бэлтгэх, мужаан, дарханы урлал эрхлэх дадлага, туршлагатай) сонирхолтой зэргийг харгалзан хүн амын нутагшилтын тогтолцоог дараахь чиглэлээр өөрчлөн сайжруулна: |
| МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2001 ОНЫ 57 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТ<br><br>МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ | Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх /цаашид "бүсчилсэн хөгжил" гэх/ арга замыг боловсруулж, бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдааг хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох чиглэл, үйл ажиллагааны зарчмын үндсийг тодорхойлж байна. |
| | 2.3.5. **Хүн амын нутагшилт**, хот байгуулалтын хүрээнд: тухайн бүсийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бүрдүүлж, нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг тэтгэх чадвар бүхий бүс нутаг, хотжилтын нэгдмэл орчныг бий болгох. |
| | 3.2.3. "Бүс нутаг" гэж аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот, тосгоны хоорондын нийгэм, эдийн засгийн харилцаа холбоо, тусгай хамгаалалттай газар нутаг, тэдгээрийн орчны бүс, хүн амын нутагшилт, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон аж ахуйн бусад салбар /салбар хоорондын/-ын уялдаа холбооны орон зайн хөгжил, байршлын хүрээг хамарсан Монгол Улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг буюу эдийн засаг, нийгмийн цогцолборыг; |
| | 3.10.3. Хүн амын нутагшилт, суурьшилтын олон төвтэй тогтолцоог бүрдүүлж, суурин болон нүүдлийн амьдралын хэв маягийг оновчтой хослох. |
| | 4.7.5.а Бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх агуулгаар **"Хүн амын нутагшилт, суурьшлын** хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ыг боловсруулж, шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх; |
| МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР | **2.83 Монгол Улсын хүн амын нутагшилт,** суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна. |

| | |
|---|---|
| ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 261 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХАВСРАЛТ ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО (2016-2025 ОН) | **4.2.2 Хүн амын нутагшилт, суурьшлын** зохистой тогтолцоог бүрдүүлж, хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хот, суурин газар, орон нутгийн тогтвортой хөгжлийг газар зохион байгуулалт, хот байгуулалт, дэд бүтэц, аж үйлдвэр зэрэг бусад салбарын бодлоготой уялдуулах; |
| ЗАСГИЙН ГАЗРЫН 2003 ОНЫ 264 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХАВСРАЛТ<br><br>УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ | 2.6. Хүн амын суурьшлын бүс газар хөгжлийн чиг хандлага **хүн амын нутагшилт, суурьшлын** хөгжлийн ерөнхий төслөөр хотуудын гүйцэтгэх үүргийн хувьд бүсийн төв хот, бүсийн тулгуур төв хот гэсэн ангиллаар авч үзсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганаар баталгаажих түвшинд 8 хотыг "бүсийн төв" статусаар батласныг төлөвлөлтөд үндэслэв. |
| | Улсын хэмжээнд хөгжлийн нутаг дэвсгэрийн тогтолцоо нь эдийн засгийн бүс, аймаг, бүсчлэгдсэн сумд, сум гэсэн хэлбэртэй, харин суурьшлын тогтолцоо нь улсын нийслэл, эдийн засгийн бүсийн төв, аймгийн төв, сум дундын тулгуур төв, сумын төв, бусад суурин гэсэн хэлбэртэй байна |
| ДБХ-ЫН САЙДЫН 2000 ОНЫ 95 ТООТ ТУШААЛЫН ХОЁРДУГААР ХАВСРАЛТ | 1.4. Нийслэл Улаанбаатар хот болон бүс нутгийн хөгжлийн тулгуур төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Улсын **хүн амын нутагшилт,** хөгжлийн ерөнхий төслийн үндсэн шийдэлтэй уялдуулан тэдгээрийн улсын хэмжээнд болон бүсийн түвшинд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг харгалзан боловсруулна. |
| | Тухайн хот болон хот орчмын бүсийн **хүн амын нутагшилт,** хот байгуулалтын тогтолцоо, тэдгээрийн харилцан үйлчлэлийн уялдаа, гүйцэтгэх үүрэг, барилгажилт, инженерийн шугам сүлжээний хангамж, тохижилт, архитектур гоо зүйн түвшинг хот суурин тус бүрээр гаргана. |
| | 6.4. Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний шинэчлэлтэд **Хүн амын нутагшилт,** хөгжлийн ерөнхий төслийн үндсэн шийдэлтэй уялдан боловсрол, шинжлэх ухааны зарим салбаруудыг бүс нутгийн тулгуур төвүүдэд байгуулах, Улаанбаатар хот орчмын дагуул хотуудыг эрчимтэй хөгжүүлэх замаар нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг аажмаар сааруулах чиглэлийг баримтлах: |

## 4.5. Гадаад улсуудын туршлага, сургамж

Хотжилтын үйл явц 1990-ээд оноос эхлэн дэлхийн хөгжиж буй болон дунд зэргийн орлоготой орнуудад эрчимтэй явагдаж байна. 2017 оны байдлаар дэлхийн нийт хүн амын 53 хувь нь хот, суурин газруудад оршин суух болсон бөгөөд хүн амын энэхүү эрчимтэй өсөлтийг дагаад ялангуяа том хотуудад хүрээлэн буй орчны доройтол, хотын дэд бүтцийн даац хэтрэх, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа ихсэх, бүс нутгийн тэнцвэрт

бус хөгжил, хотын ажилгүйдэл, ядуурал ихсэх, хэт төвлөрөл нэмэгдэх зэрэг нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бий болгожээ.

Энэхүү сөрөг үр дагавар хамгийн их нөлөөлсөн орнууд нь Латин Америкийн Мексик, Бразил, Африкийн Египет, Сенегал, Нигер, Азийн Бангладеш, Энэтхэг, Пакистан, Индонези, Монгол зэрэг улсууд юм. Иймд хэт том хотуудын төвлөрлийг саарлуулахын тулд бага, дунд хотуудын хөгжлийг дэмжих, мөн шинэ суурьшлын төвүүдийг байгуулах замаар хүн амын тогтвортой хөгжил бүхий нутагшилт, суурьшлын бодлогыг шинээр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай болсон.

Даян дэлхийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрт том хот руу шилжин суурьших явдлыг багасгахын тулд аливаа улс орон хөдөөд амжиргааны нөхцлийг сайжруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, бүсийн хөгжилд тэргүүлэх төв, дагуул хотуудын хөгжлийг дэмжихийг чухалчлан, улмаар улс орнуудын Засгийн газар үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүднээс хүн амын хэт төвлөрлөөс шалтгаалан гарч болох сөрөг үр дагавруудаас сэргийлэн тусгай бодлого, төлөвлөлтийн урт хугацааны баримт бичгүүдийг батлан гаргаж хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, БНСУ-д "Үндэсний нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого ба стратеги", Япон Улсад "Үндэсний төлөвлөгөө", ОХУ-д "Нутагшилт, суурьшлын ерөнхий схем", БНТУ-д "Хот, суурин газрын хөгжлийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө бэлтгэх төсөл" юм.

Түүнчлэн, эрдэм шинжилгээ, судалгаа, төлөвлөлтийн чиглэлээр мэргэжлийн байгууллага, хүрээлэнгүүдийг байгуулан ажиллуулдаг. Үүнд, БНЭУ-ын "Хүн амын нутагшилтын институт", БНСУ-ын "Хүн амын нутагшилт, суурьшлын судалгааны институт", БНХАУ-ын "Хот, сууринтийн систем төлөвлөлтийн институт", ОХУ-ын ГИПРОГОР зэрэг болно.

***Хот суурин газрын болон бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэлхийн улсууд зарим улсууд засаг захиргааны нэгжийн хуваарилалтаар давхар хэрэгжүүлж байна.***

***БНСУ***

БНСУ-ын хувьд Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн төлөвлөгөө хэмээх стратегийн бодлогын баримт бичгийн гол зорилго нь иргэн бүрээ оршин буй газартаа эрүүл аюулгүй, тохь тухтай, нийгэм-эдийн засгийн тааламжтай орчинд амьдрах нөхцлийг нь хангахад чиглэдэг. Нийгмийн эмзэг давхаргын нийгмийн хамгаалал, халамжийг нэмэх, хүн амыг тогтвор суурьшилтай ажлын байраар хангах, зээлийн хүү бага орон сууцны ипотекээр иргэдээ хангах, хотын эрүүл орчныг нэмэгдүүлэх, хүн амын амьжиргааны түвшний ялгааг хот хөдөөгөөр байхгүй болгох, тэдгээрт орчныг бий болгоход орчин үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг ашиглахыг зорьдог. Ингэснээр хүн амын шилжилт хөдөлгөөнийг бууруулахыг зорьдог.

Хүснэгт 6. БНСУ-ын хот сууринтийн ангилал болон засаг захиргааны нэгжийн бүтэц

| *№* | *Нэгжүүд* | *Тайлбар* |
|---|---|---|
| ***1.*** | ***Засаг захиргааны нэгжийн хуваарийн бүтэц*** | |
| | *1-р түвшний нэгж: нийт 17 нэгжид хуваагддаг. 6 метрополис хот (1 саяас дээш хүнтэй 6* | *Бие даасан удирдлага, засаглал, эдийн засаг,* |

| | | |
|---|---|---|
| | *хот) + 1 тусгай хот (Сөүл) + 1 тусгай автономит хот (Сэжон) + 9 муж* | *санхүүгийн эрх мэдэлтэй* |
| | *2-р түвшний нэгж:* | |
| | *Хот, хотхон, дүүрэг, хороо, тосгон*<br>*Хот гэдэг нь 150 мянгаас 1 сая хүнтэйг хэлнэ. Эдгээр хотууд нь хорооноос бүрддэг.*<br>*Хотхон нь 20-500 мянган хүнтэй. Хотхон нь 6000-аас дэш хүнтэй тосгонуудаас бүрдэнэ.* | *1 саяас дээш хүнтэй метрополис 6 хот болон мужууд нь дүүргээс бүрддэг. Дүүргийн хүн ам нь 150-аас дээш мянган хүнтэй байдаг.* |
| ***2. Хот суурин газруудын ангилал*** | | |
| ***2.1*** | *Улсын ач холбогдол, онцгой статустай хот нь 1 саяас дээш хүн амтай.*<br>*Мужийн ач холбогдол, статустай хот нь 50 мянгаас дээш хүнтэй*<br>*Тосгон нь 3000-с дээш хүн амтай бөгөөд хүн амын 2/3-оос доошгүй хэсэг нь ХАА-н бус аж үйлдвэр, үйлчилгээ, барилга, дэд бүтцийн салбарт ажиллагсад байна.* | *1-р түвшний 4 хотоос бусад хот, суурин газрууд нь засаг захиргааны хувьд мужуудад харьяалагдана.* |

БНСУ-ын Засгийн газар нь Сөүл хотыг чиглэсэн хүн амын хэт төвлөрлийг сааруулахын тулд Сэжон хотод төр захиргааны байгууллагуудын цогцолборыг байгуулж байна. Энэхүү цогцолбор нь нийт 36 яамд болон агентлагийг хамрах төлөвлөгөөтэй байна. Нийслэл Сөүлээс 113 км зайтай, 281 мянган хүнтэй тус хотод 2007 онд 9 яам, 4 агентлагийг шилжүүлэн байршуулж, тусгай статустай 1-р түвшний засаг захиргааны нэгжийн статус олгосон. Тус хотыг 2030 он гэхэд 500 мянган хүнтэй болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн. Өмнө нь ган, хөлөг онгоц, автомашин, химийн зэрэг аж үйлдвэрийн гол төвүүдийг хөгжүүлэх, хотуудын хоорондын дэд бүтцийг хөгжүүлж хотуудыг хөгжүүлэхэд бүсчилсэн хөгжлийн гол бодлогоо барьж байсан одоо шинэ эдийн засгийн газарзүйн онолын дагуу хотуудын кластер болон 5 (бүс) + 2 (Сөүл+Жежү арал) загвараар хөгжүүлэхийг зорьж байна.

Хүснэгт 7. 5+2 эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн стратеги

| № | Бүсийн нэр | Төрөлжилт | Хөгжлийн стратеги |
|---|---|---|---|
| 1 | Нийслэл | Мэдээллийн технологийн үйлдвэрлэл | Дэлхийн лидерийн хэмжээнд бизнесийн төв зангилаа болох |
| 2 | Чунчеон | Био, ангаах ухаан, эм, шинэ мэдээллийн технологи | Цахиурын хөндий, өндөр технологийн шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн төв |
| 3 | Хонам | Соёл, урлаг, ногоон аж үйлдвэрийн бүс | Сэргээгдэх эрчим болон түүний тоног төхөөрөмж үйлдвэрлэл |
| 4 | Гангвон | Аялал жуулчлал, амралт сувилал, гоо сайхан, эрүүл мэнд | Аялал жуулчлал, эрүүл мэндийн тоног төхөөрөмж үйлдвэрлэл |
| 5 | Даегонг | Мэдээллийн технологи, ногоон эрчим хүчний | Уламжлалт соёл, өндөр технологийн аж үйлдвэрийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | үйлдвэрлэл | шинэ өсөлтийн бүс |
| 6 | Донгнам | Автомашин болон түүнтэй холбоотой аж үйлдвэрлэлүүд | Сууръ аж үйлдвэр, ложистикийн төв |
| 7 | Жэжу | Аялал жуулчлал, чөлөөт цаг, энтэртайнментийн үйлдвэрлэл | Азийн олон улсын чөлөөт хот |

Эх сурвалж: Jae-Hong Jang, 2009. PCRD

**Казахстан улс**

Казахстан улс нь хүн амын нягтшил сийрэг, эх газрын эрс тэс уур амьсгалтай, шилжилтийн эдийн засагтай, далайд гарцгүй, уул уурхай хөгжсөн улс гэдгээрээ Монголтой төстэй бөгөөд хэдий Монголоос 5 дахин их хүн амтай ч засаг захиргааны 1-р түвшний нэгжийн тоо нь 18 бөгөөд улсын зэрэглэлтэй онцгой статустай 4 хот нь бие даасан засаг захиргааны 1-р түвшний нэгж болж явдаг. Түүнчлэн бүсчилсэн хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэхдээ эдгээр 18 нэгжид тулгуурлан явуулдаг.

Хүснэгт 8. Казахстан улсын хот суурингийн ангилал болон засаг захиргааны нэгжийн бүтэц

| № | Нэгжүүд | Тайлбар |
|---|---|---|
| ***3.*** | ***Засаг захиргааны нэгжийн хуваарийн бүтэц*** | |
| | *1-р түвшний нэгж: 14 муж + 4 хоттой Нийслэл Астана, Алма-Аты, Чимкент, Байконур хотууд. Үүнээс Астана, Алма-Аты, Чимкент хотууд ямар нэгэн мужид харьяалагддаггүй* | *Бие даасан удирдлага, засаглал, эдийн засаг, санхүүгийн эрх мэдэлтэй* |
| | *2-р түвшний нэгж:* | |
| | *Мужууд нь дүүргүүдэд хуваагддаг.* | |
| ***4.*** | ***Хот суурин газруудын ангилал*** | |
| ***2.1*** | *Улсын ач холбогдол, онцгой статустай хот нь 1 саяас дээш хүн амтай.*<br>*Мужийн ач холбогдол, статустай хот нь 50 мянгаас дээш хүнтэй*<br>*Тосгон нь 3000-с дээш хүн амтай бөгөөд хүн амын 2/3-оос доошгүй хэсэг нь ХАА-н бус аж үйлдвэр, үйлчилгээ, барилга, дэд бүтцийн салбарт ажиллагсад байна.* | *1-р түвшний 4 хотоос бусад хот, суурин газрууд нь засаг захиргааны хувьд мужуудад харьяалагдана.* |

**Япон улс**

Япон улс нь аж үйлдвэржилтийн хөгжлийн эхэн үедээ улсаа бүс нутгийн хувьд орон зайн оновчтой төлөвлөлтөөр хөгжүүлж ирсэн. Хүнд аж үйлдвэрийн бүсийг нутгийн баруун өмнөд хэсэгт байгалийн нөөц (ус, нүүрс) болон импорт, экспортын гадаад худалдаанд ойр байршлыг харгалзаж тогтоосон. Тухайлбал Кюшю арлын Китакюшю хотод ган, эрчим хүч, төмөрлөгийн болон усан онгоцны үйлдвэрийг хөгжүүлж эхэлсэн бол нутгийн хойд болон дунд бүс нутагт хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх бодлого барьж ирсэн. Япон улсын хувьд бүсчилсэн хөгжлийн хуваарь буюу бүсүүдийг тогтоож, тэдгээрт хөрөнгө оруулалт, санхүүгийн ялгавартай бодлого баримтлахдаа экспортод чиглэсэн аж үйлдвэрийн салбаруудын хөгжил болон хот

доторхи болон хотуудын хоорондын дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарж ирсэн. Өнөө үед тогтвортой хот байгуулалтыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийг оролцоог дэмжиж, орчин үеийн техник технологи болон ногоон хөгжлийг гол бодлогоо болгон барьж байна. Хүн амын насжилт өндөрсөж, төрөлтийн түвшин буурч, хөдөөнөөс хотыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор хөдөөд залуучуудын суурьшлыг дэмжих үүднээс хөдөөд гадаадын харьяат иргэд ажиллаж амьдрахад дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

**Хүснэгт 9. Японы хот суурин газрын ангилал нэгж болон түүний засаг захиргааны хуваарьтай уялдаж буй байдал**

| № | Нэгжүүд | Тайлбар |
|---|---|---|
| 5. | Засаг захиргааны нэгжийн хуваарийн бүтэц | |
| | 1-р түвшний нэгж: 47 муж + 20 хоттой Нийслэл Токио метрополис хот нь засаг захиргааны хувьд 47 мужийн нэг болдог. | Бие даасан удирдлага, засаглал, эдийн засаг, санхүүгийн эрх мэдэлтэй |
| | 2-р түвшний нэгж: | |
| | | |
| 6. | Хот суурин газруудын ангилал | |
| 2.1 | 20 Том хот-500 мянгаас дээш хүн амтай | Засаг захиргааны 1-р түвшин болж явдаг. Хот нь 47 мужийн адилаар бие даасан эдийн засаг, удирдлага, эрх мэдэлтэй. |
| 2.2 | Төв хот (300 мянгаас дээш хүнтэй, 100 км2-аас их газар нутагтай)<br>Тусгай хот – 200 мянгаас дээш хүнтэй<br>Хот – 50 мянгаас дээш хүнтэй, хүн амын 60-с их хувь хотын төвд амьдардаг. | Мужуудад харьяалагдана. |
| 2.3 | Тосгон | Муж, хотдоо харьяалагддаг. |

## 4.5.1 Хүн амын суурьшлын засаг захиргааны хуваариудаарх дэлхийн улсуудтай харьцуулсан судалгаа

Суурьшмал амьдралыг эрт цогцлоосон, засаглал захиргааны олон жилийн түүхтэй орнууд XX зууны сүүлч, шинэ мянганы эхээр засаг захиргааны хуучин тогтолцоогоо үеэ өнгөрөөсөн, хэт жижиг хэсэгт хуваж, улс орны хүч чадлыг тарамдуулсан зэрэг үндэслэлээр шинэчлэл хийж эхлээд байна. Энэ хандлага нь даяаршлын нөлөөгөөр олон улс, бүс нутгийн хүрээнд ч хийгдэж байна. Тухайлбал Европын холбоо нь 27 орныг эгнээндээ нэгтгэж, нэгдсэн мөнгөн дэвсгэрт, хил хязгаартай болж, бүс нутгийн нийгэм, эдийн хөгжлийг хурдасгах нааштай алхам хийсэн.

Мөн Франц улс олон зуунаар уламжилж ирсэн засаг захиргааны 96 нэгжээ 22, Польш 49 нэгжийг 16 болгон цомхотгосон бол Япон, ОХУ, Хятад улс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өөрчлөлтийг аажмаар хэрэгжүүлж байна.

Хүснэгт 10. Дэлхийн газар нутаг томтой зарим улсуудын засаг захиргааны анхдагч болон хоёрдогч нэгжүүдийн тооны харьцуулсан судалгаа

| | Улсын нэр | Газар нутгийн хэмжээ, мян.км2 | Хүн амын тоо, саяар | I түвшний нэгжийн тоо | II түвшний нэгжийн тоо | I түвшний нэг нэгжид ногдох хүн амын тоо, саяар | II түвшний 1 нэгжид ногдох хүн амын тоо | I түвшний 1 нэгжид ногдох газрын хэмжээ, мян.км2 | II түвшний 1 нэгжид ногдох газрын хэмжээ, мян.км2 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ОХУ | 17098 | 142.9 | 83 | 1868 | 1.7 | 0.08 | 206.0 | 9.2 |
| 2 | Канад | 9985 | 34.6 | 13 | 201 | 2.7 | 0.17 | 768.1 | 49.7 |
| 3 | АНУ | 9827 | 312.2 | 52 | 3143 | 6.0 | 0.10 | 189.0 | 3.1 |
| 4 | Хятад | 9597 | 1339.7 | 33 | 330 | 40.6 | 4.06 | 290.8 | 29.1 |
| 5 | Бразил | 8515 | 190.7 | 27 | 5564 | 7.1 | 0.03 | 315.4 | 1.5 |
| 6 | Австрали | 7741 | 22.7 | 9 | 562 | 2.5 | 0.04 | 860.1 | 13.8 |
| 7 | Энэтхэг | 3287 | 1210.1 | 35 | 640 | 34.6 | 1.89 | 93.9 | 5.1 |
| 8 | Аргентин | 2780 | 40 | 22 | 376 | 1.8 | 0.11 | 126.4 | 7.4 |
| 9 | Казахстан | 2724 | 16.5 | 17 | 319 | 1.0 | 0.05 | 160.2 | 8.5 |
| 10 | Судан | 2500 | 39 | 15 | 86 | 2.6 | 0.45 | 166.7 | 29.1 |
| 11 | Алжир | 2382 | 36.3 | 48 | 553 | 0.8 | 0.07 | 49.6 | 4.3 |
| 12 | Ардчилсан Конго | 2345 | 66 | 10 | 192 | 6.6 | 0.34 | 234.5 | 12.2 |
| 13 | Саудын Арави | 2150 | 27.1 | 13 | 118 | 2.1 | 0.23 | 165.4 | 18.2 |
| 14 | Мексик | 1964 | 112.3 | 32 | 2438 | 3.5 | 0.05 | 61.4 | 0.8 |
| 15 | Индонез | 1904 | 237.5 | 38 | 430 | 6.3 | 0.55 | 50.1 | 4.4 |
| 16 | Ливи | 1760 | 6.3 | 22 | | 0.3 | | 80.0 | |
| 17 | Иран | 1648 | 75.6 | 30 | 310 | 2.5 | 0.24 | 54.9 | 5.3 |
| 18 | Монгол | 1564 | 3.2 | 22 | 330 | 0.1 | 0.008 | 71.1 | 4.7 |
| 19 | Чад | 1284 | 11.2 | 22 | 40 | 0.5 | 0.28 | 58.4 | 32.1 |
| 20 | Ангол | 1247 | 19.1 | 18 | 163 | 1.1 | 0.12 | 69.3 | 7.7 |
| 21 | Мали | 1240 | 14.5 | 8 | 49 | 1.8 | 0.30 | 155.0 | 25.3 |
| 22 | Этиоп | 1104 | 82.1 | 11 | 68 | 7.5 | 1.21 | 100.4 | 16.2 |
| 23 | Боливи | 1099 | 10.4 | 9 | 112 | 1.2 | 0.09 | 122.1 | 9.8 |
| 24 | Мавритани | 1030 | 3.4 | 12 | 44 | 0.3 | 0.08 | 85.8 | 23.4 |
| 25 | Египет | 1001 | 80.8 | 29 | 232 | 2.8 | 0.35 | 34.5 | 4.3 |
| 26 | Нигери | 924 | 158.4 | 37 | 774 | 4.3 | 0.20 | 25.0 | 1.2 |
| 27 | Намиби | 823 | 2.1 | 13 | 107 | 0.2 | 0.02 | 63.3 | 7.7 |
| 28 | Ботсвана | 587 | 1.8 | 9 | 19 | 0.2 | 0.09 | 65.2 | 30.9 |
| 29 | Швед | 450 | 9.4 | 21 | 289 | 0.4 | 0.03 | 21.4 | 1.6 |
| 30 | Финланд | 338 | 5.4 | 20 | 86 | 0.3 | 0.06 | 16.9 | 3.9 |
| 31 | Норвеги | 324 | 5 | 22 | 430 | 0.2 | 0.01 | 14.7 | 0.8 |
| 32 | Польш | 313 | 38.2 | 16 | 379 | 2.4 | 0.10 | 19.6 | 0.8 |
| 33 | Литва | 65 | 3.2 | 10 | 60 | 0.3 | 0.05 | 6.5 | 1.1 |
| 34 | Эстон | 45 | 1.3 | 15 | 226 | 0.1 | 0.01 | 3.0 | 0.2 |

*Эх сурвалж: http://en.wikipedia.org/wiki/Table_of_administrative_country_subdivisions_by_country*

Монгол Улс нь дэлхийд 1 хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр тэргүүлдэг хэрнээ газар нутагтайгаа харьцуулбал харьцангуй олон засаг захиргааны нэгжүүдтэй байгаар Хүснэгт 11-ээс тодорхой харж болохоор байна. Тухайлбал хүн ам цөөнтэй хэрнээ анхдагч нэгжийн (аймаг) тоо 22 байгаа нь Монголоос том нутагтай, хүн ам ихтэй Канад, Австрали, Саудын Арави, Казахстан, Судан, Ардчилсан Конго, Аргентин зэрэг улсаас их байна. Мөн хоёрдогч түвшний засаг захиргааны нэгжийн (сум) тоо Хятад, Казахстан, Судан, Ардчилсан Конго,

Саудын Арави, Ливи, Индонез зэрэг улсуудаас их байна. Газар нутаг өргөн уудам, хүн ам цөөнтэй хэрнээ хоёрдогч түвшний засаг захиргааны нэгжид ногдох газар нутгийн дундаж хэмжээгээр дээрх сонгосон 34 улсаас 20 улсын дараа орох бага хэмжээтэй байгаа нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь дэлхийн улсуудтай харьцуулахад хэт олон хэсэгт хуваагдаж, жижгэрсэн болох нь харагдаж байна.

**Скандинавын орнууд:** Скандинавын зарим орны туршлагаас харахад жижиг нэгжүүдийг бие даасан нэгж болгохоосоо өмнө тэдгээрийг нэгтгэн хэмжээг нь томсгож, эдийн засгийн баазыг өргөтгөх замаар энэ асуудлыг амжилттай шийдсэн байна. Тухайлбал: Швед Улс 10000-аас доош хүн амтай засаг захиргааны нэгжүүдийг (коммун) сайн дураараар өөр хоорондоо нэгдэх хүртэл улсын төсөв хуваарилахгүй байх шийдвэр гаргаж, нэгдэх эцсийн хугацаа 1980 он гэж 1974 онд хуулиар тогтоож өгчээ. 1974 оны энэ хуулиар 1980 оноос хойш нэгдэж чадаагүй нутаг дэвсгэрийн нэгжүүдийг хүчээр нэгтгэх эрхийг засгийн газарт олгосон байна. Ингээд 1989 он гэхэд сайн дураараа нэгдсэн болон Засгийн газраас хүчээр нэгтгэсэн нэгжүүдийн тоо 2281-ээс 290 болж даруй 8 дахинаар буурсан. Эдгээр коммунуудыг нэгтгэсний хамгийн гол ач холбогдол нь бие даан өөрийн нийгэм-эдийн засгийн асуудлаа шийдэж чаддаг хүн амын зохистой төвлөрөл бүхий бүтэц бий болгосон явдал юм.

Хүснэгт 11. Европын зарим улсуудын municipality буюу засаг захиргааны жижиг нэгжүүдийн (сумуудын түвшний) тооны өөрчлөлт

| Улсын нэр | 1950 | 2017 | Өөрчлөлт, % |
|---|---|---|---|
| Дани | 1387 | 98 | -92.9 |
| Литва | 581 | 60 | -89.7 |
| Швед | 2281 | 290 | -87.3 |
| Грек | 5774 | 1034 | -82.1 |
| Их Британи | 2028 | 435 | -78.6 |
| Латви | 570 | 118 | -79.3 |
| Бельги | 2669 | 589 | -77.9 |
| Нидерланд | 1015 | 443 | -56.4 |
| Герман | 25930 | 12229 | -52.8 |
| Норвеги | 744 | 431 | -42.1 |
| Австри | 3999 | 2357 | -41.1 |
| Финланд | 547 | 348 | -36.4 |
| Испани | 9214 | 8111 | -12.0 |
| Швейцарь | 3097 | 2758 | -10.9 |
| Эстон | 254 | 227 | -10.6 |
| Франц | 38814 | 36682 | -5.5 |
| Польш | 2399 | 2418 | 0.8 |
| Унгар | 3122 | 3153 | 1.0 |
| Португал | 304 | 308 | 1.3 |
| Итали | 7781 | 8100 | 4.1 |
| Румын | 2948 | 3176 | 7.7 |
| Молдав | 881 | 980 | 11.2 |

| | | | |
|---|---|---|---|
| Чех | 4104 | 6248 | 52.2 |

*Эх сурвалж: World Bank, 2003; Dexia, 2009/2010 edition in Analytical study on optimal administrative-territorial structure for republic of Moldova*

1960-аад оноос Европын орнууд өөрийн бие даасан удирдлагын тогтолцоо бүхий засаг захиргааны жижиг нэгжүүдээ нэгтгэн цөөлж, хүн ам, эдийн засгийн төвлөрлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлсэн. Баруун болон Хойд Европын бараг бүх орнууд засаг захиргааны жижиг нэгжүүдээ цөөлжээ (Хүснэгт 12). Зарим орнуудад эдийн засгийн зарчмаар буюу өөрөө өөрийгөө санхүүжүүлэх механизм, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, жижиг нэгжүүдийн эдийн засгийн нөөц, хөрөнгө оруулалтыг нэгтгэн төвлөрүүлж, үр өгөөжийг нь дээшлүүлэх зарчмаар хийгдсэн бол зарим цөөн улсууд шууд Засгийн газрын шууд удирдлагаар энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлсэн байна.

Зураг 3. Засаг захиргааны жижиг нэгжүүдийн (сум) хүн амын дундаж тоо, 2017




*Эх сурвалж: Dexia, EU sub-national governments: 2008 key figures, 2009/2010 edition*

Европын орнуудын бие даасан өөрийн удирдлага бүхий засаг захиргааны дундаж 1 жижиг нэгжид ногдох хүн амын тоо Монгол Улсын дундажтай харьцуулахад харьцангүй өндөр байна. Тодруулбал Монгол Улсын дундаж хөдөөгийн сумын хүн амын тоог харьцуулахад Их Британиас 50, Даниас 16, Шведээс 12, Финландаас 5, Европын холбооны улсуудын дунджаас 2 дахин бага байна (Зураг 3).

Зураг 4. Дэлхийн улсуудын засаг захиргааны анхдагч болон хоёрдогч нэгжүүдийн хуваарь



*Эх сурвалж: http://en.wikipedia.org/wiki/File:World_administrative_levels.png*

Түүнчлэн дээрх зургаас засаг захиргааны 2 догч түвшний нэгжийн харьцангуй их байгааг дэлхийн улсуудтай харьцуулсан газрын зурагнаас тодорхой харж болохоор байна (Зураг 4).

## 4.4.Нийгэм эдийн засгийн судалгаа

Хүн амын нутагшилт бүс нутгийн судалгаанд холбогдох нийгэм эдийн засгийн бүлэгт одоогийн байдлын судалгааг улс орны, бүсийн нутгийн, аймаг, сумд, баг, хорооны түвшинд анхдагч болон хоёрдогч датаг сүүлийн 5-10 жилээр эхний ээлжинд дараах дэд ангиллаар мэдээллийн сан үүсгэхээр боловсруулалтын бэлтгэл ажил хийж байна. Үүнд:

1. Хүн амын нийгмийн үзүүлэлт
   1.1 Хүн амын тоо /хот, хөдөөгөөр, насны бүлэг, хүйсээр/
   1.2 Ажилгүйдэл
   1.3 Ядуурал
2. Дотоодын нийт бүтээгдэхүүн ба эдийн засгийн бүтэц
   2.1 ДНБ-ны жилийн цэвэр өсөлт, бууралт
   2.2 ДНБ-ны салбарын бүтцээр
3. Хөдөө аж ахуйн салбар
   3.1 Малын тоо / төрлөөр /
   3.2 Газар тариалан / тариалсан талбай, хураасан ургац, төрлөөр /
4. Аж үйлдвэр
   4.1 Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлвэрлэл /бүх төрлийн үйл ажиллагааны салбараар, эзлэх хувиар/
   4.2 Жижиг дунд үйлдвэрлэл / салбараар, эзлэх хувиар /
5. Хөрөнгө оруулалт
6. Нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаархи судалгаа

Нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хүснэгтийн дагуу сүүлийн 5-10 жилийн тоон мэдээлэл цуглуулахаар бэлдээд байна.

**Нийгмийн дэд бүтцийн чиглэлээр:** Монгол улсын хэмжээнд нийгмийн дэд бүтцийн төлөвлөлт буюу боловсрол, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, соёлын байгууллага, орон сууцны хангамжийн талаарх судалгааг хийж байна.

Судалгаа 1990/1991 он, 2005/2006 он, 2017/2018 оны байдлаар, мөн аймаг болон бүс нутаг тус бүрээр нь тоо хэмжээг нэгтгэж, харьцуулах байдлаар хийж байгаа болно.

Боловсролын салбарын судалгаа: Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их дээд сургуулиудын тоо хэмжээ болон сургалтанд хамрагсад, төгсөгчдийн тоог мөн 1990/1991 он, 2005/2006 он, 2017/2018 оны байдлаар, мөн аймаг болон бүс нутаг тус бүрээр нь судалж нэгтгэсэн.

Мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын байгууллага, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудыг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн гэсэн чиглэлээр тоо хэмжээг тусд нь гаргаж байна.

Эрүүл мэндийн салбарын судалгаа: Эмнэлгийн багууллага, эмнэлгийн орны тоо, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоо болон 1 эмч, 1 сувилагчид ногдох хүний тоо гэсэн чиглэлээр 2000, 2010, 2018 оны байдлаар нь судалгааг гаргасан бөгөөд мөн эмнэлгийн байгууллагын тоог улсын болон хувийн гэсэн ангиллаар харьцуулан судалж байна.

Дээрх тоо хэмжээг Улаанбаатар хот болон бүс, аймаг, сумын хэмжээнд гаргаж харьцуулах судалгааг хийж байна.

Орон сууцны хангамжийн судалгаа: Монгол улсын хэмжээнд орон сууцны барилгын тоо хэмжээг бусад зориулалтын буюу орон сууцны бус барилгын тоо хэмжээтэй харьцуулах, мөн орон сууцны барилгыг талбайн хэмжээгээр нь судалгааг гаргаж байна.

Дээрх тоо хэмжээг 2000, 2010, 2018 оны байдлаар Улаанбаатар хот, бүс, аймаг, сумын хэмжээнд гаргаж, харьцуулалт хийж байгаа болно.

Мөн орон сууцны барилгад оруулсан нийт хөрөнгийн хэмжээг 2000 оноос 5 жил тутамд буюу 2005, 2010, 2015, 2018 оны байдлаар судалгааг гаргасан.

Соёл, урлагийн салбарын судалгаа: Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа номын сан, музей болон үзмэр, шашны байгууллага, сүм хийд, биеийн тамир, спортын байгууллага, соёлын төв зэргийн тоо, энэ чиглэлийн байгууллагын нийт ажилтны тоо, үйлчлүүлэгчдийн тоо гэсэн чиглэлээр судалгааг хийх ба 1995, 2010, 2018 онуудын байдлаар нийслэл, бүс, аймаг, сумын хэмжээнд судалгааг хийх юм.

Дээрх чиглэлээр гаргасан судалгааг үндэслэн нэгдсэн харьцуулалт хийх, дүгнэлт гаргах замаар тулгамдсан асуудлууд болон тэдгээрээс гарах арга зам, төлөвлөлтийн оновчтой шийдлийг өөрийн зүгээс тодорхойлох зорилготой ажиллаж байгаа болно.

## 4.5. Хүн ам, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа

Хүн ам, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг дараах үзүүлэлтүүдээр цуглуулан мэдээллийн сан үүсгэж, боловсруулалт хийж байна.

1. Ажил хайгч иргэд болон бүртгэлтэй ажилгүй иргэд
   - Аймаг, дүүргүүдийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд ажил идэвхтэй хайж буй ажил хайгч иргэдийн тоо. Ажил хайгч иргэдийн иргэний харьяалалаар.
   - Ажил хайгч иргэдийн насны бүлэг, хүйс
   - Ажил хайгч иргэд, боловсролын түвшнээр
   - Бүртгэлтэй ажилгүй иргэд, иргэний харьяалалаар
   - Бүртгэлтэй ажилгүй иргэд бүсээр, хүйсээр, боловсролын түвшнээр

2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ
    - Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалга
    - Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, насны бүлэг, ажил мэргэжлийн ангилалаар, өмчийн хэлбэрээр
3. Ажлын шинэ байрны талаарх мэдээлэл
    - Шинээр бий болсон ажлын байр байршлаар
    - Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн хүйс
4. Монгол Улсын засгийн газраас авч хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд
    - Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
    - Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр
    - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
    - Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
    - Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
    - Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
5. Гадаадаас ажиллах хүч авах
    - Хөдөлмөр эрхлэж буй гадаадын иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
    - Хөдөлмөр эрхлэж буй гадаад иргэд байршлаар /ажиллаж буй аймаг, дүүрэг/
    - Хөдөлмөр эрхлэж буй гадаадын иргэд, хүйсээр, улсаар.
6. Гадаадад ажиллах хүч илгээх
    - Шалгалтын бүртгэл, хамрагдсан, тэнцсэн иргэдийн тоо
    - Ажлын байрны санал
    - БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр илгээсэн иргэдийн тоо

Зам тээврийн судалгаа

- Монгол Улсын авто замын салбарын бүтэц, бүрэлдэхүүн
- Улсын чанартай авто замын сүлжээний өнөөгийн байдал
- Авто замын салбарт 2018 онд улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй, төсөл, арга хэмжээнүүд

Өнөөгийн байдлын судалгаагаар цуглуулсан материалууд /Нийслэл, аймаг, сум, баг, хорооны түвшинд хүн амын тоо, нас хүйсний бүтэц, ХАА, МАА-н үйлдвэрлэлийн хэмжээ, хөдөлмөр эрхлэлт, төсвийн байгууллагуудын ажилтнуудын тоо, зэрэг мэдээллүүдийг цуглуулж боловсруулалт хийж байна.

## 4.6.Амралт сувилал, аялал жуулчлалын судалгаа

Аялал жуулчлалын тухай хууль, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, эрхзүйн орчны судалгаа, Монгол Улсын болон гадаадын иргэдийн Монгол Улсын хилээр нэвтэрсэн иргэдийн судалгаа, боомтуудаар, гадаадын зорчигчдын тоо бүсээр, жуулчдын бааз, зочид буудалын тоо, аялал жуулчлалын голлох маршрут, амралт рашаан сувилалын судалгаа, томоохон рашаанууд аймгаар, Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс”-ын судалгаа, Монгол улсад зохион байгуулагддаг эвент арга хэмжээний судалгаа, аялал жуулчлалын томоохон төсөл, хөтөлбөрүүдийг цуглуулах судлах ажлыг гүйцэтгэж байна.

## 4.7. Газар ашиглалт, газар зохион байгуулалтын судалгаа

Газар ашиглалт, газар зохион байгуулалтын чиглэлээр одоо боловсруулж буй улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлтэй танилцаж ... чиглэлээр санал боловсруулж хүргүүлсэн мөн газрын нэгдмэл сангийн тайлангуудыг шаардлагатай он тус бүрээр харьцуулан судалж байна. Мөн улс, аймаг, сум, баг, хорооны хил хязгаар, засаг захиргааны нэгжийн төвүүдийг зурагт оруулж зураглалын суурь бэлтгэж байна..

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл

Улсын газрын нэгдмэл сангийн тайлан /2016,2017 он/

Газрын сэдэвчилсэн зураглал, мэдээллийн сангийн хүрээнд:

- Хүн амын нягтшил/Сумын хэмжээнд//2017 оноор/
- Аймаг нийслэл, сум дүүргийн хүн амын байдал/2017 оноор/
- Томоохон гол мөрд дагасан хүн амын байдал/2017 оноор/
- Хүн амын шилжилт хөдөлгөөнийг аймгууд болон нийслэлийн хэмжээнд/2010-2017 оны хугацаанд/
- Хүн амын шилжилт хөдөлгөөнийг бүсийн хэмжээнд/2010, 2017 оны хэмжээнд/
- Сумдын хүн амын өөрчлөлтийн байдал 1990, 2000, 2010, 2017 оны байдлаар
- Хүн амын ачааллыг насны ангилалаар /хүүхэд, өндөр настанаар/2010 болон 2017 оны байдлаар/
- ОХУ болон БНХАУ-тай хиллэх сумын хүн амын байдал, сумдын тоо
- Улсын чанартай авто зам, хатуу хучилттай замтай холбогдсон сумд
- Аймаг нийслэлийн эдийн засгийн байдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр/2000, 2010, 2017 оны хэмжээнд/
- Хот хөдөөгийн өрхийн тоог 2017 оны байдлаар аймгууд болон нийслэлийн хэмжээнд тус тус гарган зураглалыг хийж гүйцэтгэв.
- 2017 оны байдлаар нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн сумдын сэдэвчилсэн зураглалуудыг хийж гүйцэтгэсэн.
- Холбогдох тоон мэдээллийн сан үүсгэн баяжуулан ажиллаж байна.
- Зүүн хойд азийн бүс нутгийн эдийн засгийн интеграцийн сэдэвчилсэн зураглал
- Сумдын Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө хийгдсэн байдал
- Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл

Дээрх судалгааг хийж гүйцэтгэхдээ “Үндэсний статистикийн хорооны статистик үзүүлэлт тоон мэдээлэл”, “Улсын газар зохион байгуулалтын 2017 оны тайлан” зэрэгт тусгагдсан тоон мэдээллүүдийг ашиглан ArcGis программ хангамж дээр сэдэвчилсэн зураглалыг хийсэн.

## 4.8. Хүрээлэн буй орчин ба хүн амын нутагшилт суурьшил

Монгол орны өргөн уудам газар нутагт нь байгаль экологийн хувьд харилцан адилгүй уур амьсгал, экосистемийн төлөвтэй. Энэ агуулгаар Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлийн хөгжлийн ерөнхий төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн бодлого, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийг хийхдээ орон зайн хувьд байгаль орчны дараахь хүчин зүйлүүдийг харгалзан, байгалийс өгөгдсөн нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөх хэрэгтэй.

- Уур амьсгалын өөрчлөлт, цаашдын хандлага

- Усны нөөц, түүний тархалт, цаашдын хандлага
- Газрын доройтол, цөлжилт, бэлчээрийн экосистемийн төлөв байдал
- Ойн нөөц, түүний тархалт
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ

Монгол орны нутаг дэвсгэр уул, нуруу, уудам тал хосолсон хотгор гүдгэртэй, эх газрын эрс тэс уур амьсгалтай учраас ургамалшлын хувьд өвөрмөц бөгөөд умраас урагшлахад дэлхийн ургамалшлын 3 үндсэн бүс болох ой, тал хээр, цөлийн бүс байдаг. Эдгээр 3 бүс нь бие биедээ алгуур шилждэг учраас дундаа шилжилтийн буюу завсрын бүс үүсгэдэг бөгөөд ой ба хээрийн бүсийн завсарт уулын ойт хээр, хээр ба цөлийн бүсийн завсарт цөлөрхөг хээрийн бүстэй.

Байгалийн эдгээр бүсүүд дахь дулаан хүйтний горим, жилийн нийлбэр тунадас зэрэг уур амьсгалын харилцан адилгүй хүчин зүйлээс шалтгаалан бэлчээрийн экосистемийн бүтэц, ургамалжилт, биологийн төрөл зүйл зэрэг экологийн систем нь дагаад өөр байдаг. Зураг 5-д Монгол орны тайга, ойт хээр, хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүсүүд дээр сумын төвүүд, аймгийн хил, төвийг давхцуулан харууллаа.

***Зураг 5. Монгол орны экологийн бүс ба хүн амын нутагшилт, суурьшил***






Монгол орны нийт 330 сумдыг экологийн бүсүүдээр ангилан үзвэл тайгын бүсэд 8 сум, ойт хээрийн бүсэд 105 сум, хээрийн бүсэд 127 сум, цөлөрхөг хээрийн бүсэд 68 сум, цөлийн бүсэд 23 сумын нутаг дэвсгэр оршиж байна. Нийт 21 аймгаас ойт хээр, хээр, цөлөрхөг хээр хосолсон Увс, Завхан, Өвөрхангай, Баянхонгор гэсэн 4 аймаг байдаг Сумдын нэг бүрчлэн экологийн бүсээр ангилсан болно.

Экологийн бүсүүд дэх тухайн сумын газарзүйн нөхцөл, экосистем болон уур амьгалын харилан адилгүй нөхцөл байдал сумдын байгаль орчин, нийгэм, эдийн засагт харилцан адилгүй нөхцөл байдрыг нөхцөлдүүлнэ.

***Хүснэгт 12. Сумдын түвшинд байгаль орчин, экологийн доройтлын давамгайлах нөлөө***

| Экологийн бүс | Сумдын байгаль орчны төлөв байдал, экологид үзүүлэх давамгайлах нөлөө | |
|---|---|---|
| | **Байгалийн хүчин зүйл** | **Хүний хүчин зүйл** |
| Тайга | • Ойн түймэр<br>• Ойн хортон шавжийн нөлөө ойн экосистемд нөлөөлж байна | • Ойн модны хулгайн тээвэр, зохисгүй ашиглалт |
| Ойт хээр | • Ойн түймэр<br>• Ойн хортон шавжийн нөлөө ойн экосистемд нөлөөлж байна.<br>• Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө<br>• Дулаарлаас үүдэлтэй гадаргын усны нөлөө, усны нөөцийн хомстол | • Бэлчээр, газар ашиглалтын нөлөө давамгайлна.<br>• Ойн модны хулгайн тээвэр, зохисгүй ашиглалт<br>• Ус ашиглалт, усын аюулгүй байдалд хүний үйл ажиллагаа нөлөөлж байна. |
| Хээр | • Энэ бүсэд уур амьсгалын өөрчлөлт, бэлчээр газар ашиглалтын хам нөлөө бэлчээрийн доройтолд илүү нөлөөлж байна.<br>• Энэ бүсийн ихэнх нутагт 10 жилийн 1-2 жилд нь ган болох эрэмбэтэй байдаг.<br>• Хангайн нуруунаас эх авч говь хээрийн бүсрүү урсдаг томоохон голууд нь уур амьсгалын өөрчлөлтын нөлөөнд илүү эмзэг, өртөмтгий байна.<br>• Цөлжилт хээрийн бүсэд, ялангуяа хээрээс цөлөрхөг хээрийн завсарын бүсэд илүү ажиглагдаж байна | • Бэлчээр, газар ашиглалтын нөлөө давамгайлж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй хам байдлаар нөлөөлж байна.<br>• Зарим усны сав газарт уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөө давамгайлж байна.<br>• Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй цөлжилт |
| Цөлөрхөг хээр | • Энэ бүсийн байгаль орчин, экосистемийн тогтвортой байдалд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө илүү давамгайлна.<br>• Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гангийн эрчим, давтамж нэмэгдэх хандлагатай байгаа. Цөлөрхөг хээрийн бүсэд 2 жилийн нэг нь гантай болдог.<br>• Харын зуд говь цөлийн бүсэд 2 жил тутамд харын зуд тохиолдог.<br>• Энэ бүсийн нуур, цөөрөм, булаг шанд илүү эмзэг, багасаж байгаа<br>• Гадаргын усны нөөц багатай, зуны хур борооны үед зарим хөв, баянбүрд тогтдог.<br>• Ган, бэлчээрийн хэт ашиглалтаас үүдэлтэй цөлжилт илүү ажиглагдаж байна. | • Уул уурхай, ашигт малтмалын олборлолт<br>• Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй цөлжилт<br>• Говийн бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашигласнаас үүдэлтэй бэлчээрийн экосистемийн доройтол нэмэгдэж байна.<br>• Сумдын засаг захиргааны хилд баригдсан бэлчээр ашиглалт нь уламжлалт нүүдлээр бэлчээр ашиглах тогтолцоог алдагдуулж байна. Энэ нь бэлчээр доройтох нэг шалтгаан болж байна.<br>• Энэ бүсэд ямааны тоо толгойн нэмэгдэж байгаа нь бэлчээрийн экосистемд нөлөөлж байна.<br>• Нөгөө талаас бод мал цөөрснөөс шалтгаалж малчид говийн харганыг түлшинд илүү ашиглаж |

| | | |
|---|---|---|
| | | байгаа нь тухайн экосистемийн тогтвортой байдалд нөлөөлж байна. |
| Цөлийн бүс | • Энэ бүсийн байгаль орчин, экологийн тогтвортой байдалд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө илүү давамгайлна.<br>• Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гангийн эрчим, давтамж нэмэгдэх хандлагатай байгаа. Цөлөрхөг хээрийн бүсэд 2 жилийн нэг нь гантай болдог.<br>• Харын зуд говь цөлийн бүсэд 2 жил тутамд харын зуд тохиолдог<br>• Цөлийн бүсийн бэлчээрийн экосистем нь уур амьсгалын өөрчлөлтөд илүү эмзэг.<br>• Гадаргын усын нөөц багатай, зуны хур борооны үед зарим хөв, баянбүрд тогтдог. Энэ нь мал амьтын гол үндсэн усны эх үүсвэрийн нэг болно.<br>• Ган, бэлчээрийн хэт ашиглалтаас үүдэлтэй цөлжилт илүү ажиглагдаж байна. | • Сумдын засаг захиргааны хилд баригдсан бэлчээр ашиглалт нь уламжлалт нүүдлээр бэлчээр ашиглах тогтолцоог алдагдуулж байна. Энэ нь бэлчээр доройтох нэг шалтгаан болж байна.<br>• Энэ бүсэд ямааны тоо толгойн нэмэгдэж байгаа нь бэлчээрийн экосистемд нөлөөлж байна.<br>• Нөгөө талаас бод мал цөөрснөөс шалтгаалж малчид говийн харганыг түлшинд илүү ашиглаж байгаа нь тухайн экосистемийн тогтвортой байдалд нөлөөлж байна. |

Дээрх газарзүйн онцлог, экологийн бүсээс шалтгаалсан харилцан адилгүй нөхцөл байдлыг хүн амын нутагшилт суурьшлийн хөгжлийн ерөнхий төсөл боловсруулахдаа харгалзан үзэж, уялдуулах шаардлагатай юм.

***Усны сав газар ба хүн амын нутагшилт суурьшил,***

Хуурай газрын хотжилтын хувьд дэлхийн ихэнх томоохон хотууд усны сав, эргийн экосистемийг дагасан хотжиж, суурьшсан байдаг. Хүн амын нутагшилт, суурьшлийн төлөвлөлтөд гадаргын усны тархалт, сүлжээг дагасан суурьшлийг төлөвлөх асуудал чухал байр суурь эзэлнэ.

Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй буюу Улаанбаатар хот болон 21 аймгийн төв болон 330 сумын төв, тосгоны байршил нь гадаргын усны тархалтын сүлжээтэй хэрхэн уялдаж дараахь зурагт харууллаа.

***Зураг 7. Томоохон гол, нуурын эрэг дагасан хот, суурин газар буюу суурьшил***



***Хүснэгт 13. Томоохон гол, нуурын эрэг дагасан хот, суурин газар буюу суурьшил***

| | **Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин** | | **Сумын төв, тосгон** |
|---|---|---|---|
| | Хотын нэр, тоо | Хүн ам | Тоо |
| Томоохон гол, нуурын эрэг дагасан суурьшил | ***Нийт 15 хот*** *(Өлгий, Ховд, Улаангом, Улиастай, Мөрөн, Цэцэрлэг, Баянхонгор, Арвайхээр, Булган, Эрдэнэт, Дархан, Сүхбаатар, Улаанбаатар, Чингис, Чойбалсан)* | | ***Нийт 156 сумын төв*** *(Баян-Өлгий 10, Увс 10,Завхан 12, Хөвсгөл 19, Булган 8, Архангай 14, Орхон 1, Дархан 3, Сэлэнгэ 15, Хэнтий 8, Төв 6, Дорнод 7, Сүхбаатар 1, Дундговь 1, Өмнөговь 1, Өвөрхангай 10, Баянхонгор 10, Говь-Алтай 2, Ховд 11)* |
| Бусад | ***Нийт 7 хот*** *(Алтай, Зуунмод, Даланзадгад, Мандалговь, Чойр, Сайншанд, Баруун-урт)* | | ***Нийт 160 сум, суурин*** *(Баян-Өлгий 1, Увс 6, Завхан 11, Хөвсгөл 4, Булган 7, Сэлэнгэ 3, Хэнтий 13, Төв 17, Дорнод 6, Сүхбаатар 12, Говьсүмбэр 3, Дорноговь 14, Дундговь 13, Өмнөговь 13, Өвөрхангай 9, Баянхонгор 8, Говь-Алтай 10, Ховд 5)* |

Нийт Улаанбаатар хот болон 21 аймгийн төвүүдээс томоохон гол, нуурын эрэг дагасан хот суурин газар 15 байгаа бол 7 нь ямар нэгэн гадаргын усны сүлжээ даган байгуулагдаагүй байна. Сумын төв, суурин газруудыг гадаргын усны сүлжээтэй уялдуулан үзвэл нийт 156 сумын төв, тосгон гол, нуурын эрэг дагасан суурьшжээ.

***Усны сав газар ба уул уурхай, ашигт малтмал***

Монгол Улсын Их хурлаас 2007 онд “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоолын 1-р хавсгалтаар 15 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод, 2-р хавсралтаар нийт 39 ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлж байхыг Засгийн газар даалгасан байдаг[13].

Монгол улсын хөгжилд багагүй үүрэг, роль гүйцэтгэх эдгээр ашигт малтмалын 54 ордын байршлыг улсын хэмжээнд хилийг нь тогтоосон 29 голын сав газрын гадаргын болон газрын доорх усны ашиглаж болох усны нөөцтэй орон зайн хувьд давхцуулан харууллаа.

Зураг 8. Усны сав газруудаарх хот, суурин газруудын болон усны ордуудын байршил




| ***Усны нөөцийн ангилал*** | ***Усны ашиглах боломжит нөөцийн тоон интервал, сая $м^3$*** | ***Усны сав газар,*** *тухайн усны сав газрын дугаараар* | ***Аймгийн төв, хот, тоо*** | ***Сумын төв, тосгон, тоо*** |
|---|---|---|---|---|
| *Маш бага* | *Гадаргын усны бараг нөөцгүй* | *25, 20, 16, 17, 18* | *4* | *79* |
| *Бага* | *< 80* | *26, 27, 29, 24, 5, 6, 7, 23, 22, 21, 19, 9, 10, 13, 14, 3,* | *11* | *154* |
| *Дунд* | *80 – 160* | *4, 28, 15* | *3* | *28* |
| *Их* | *160 – 240* | *8, 11* | *4* | *27* |
| *Маш их* | *240 <* | *9, 1, 2* | | *25* |

[13] “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулах тухай” УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоол. Улаанбаатар




***Хүснэгт 14. Усны сав газрын нөөц ба түүний дагуух суурин газруудын тоо***

| Усны нөөцийн ангилал | Усны ашиглах боломжит нөөцийн тоон интервал, сая м$^3$ | Усны сав газар, тухайн усны сав газрын дугаараар | Аймгийн төв, хот, тоо | Сумын төв, тосгон, тоо |
|---|---|---|---|---|
| Маш бага | < 25.0 | 2, 3, 4, 5, 6, 7, 11, 12, 15, 16, 19, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29 | 9 | 145 |
| Бага | 25 − 50 | 8, 17, 14, 13 | 6 | 93 |
| Дунд | 50 – 75 | 10, 18, 20 | 1 | 45 |
| Их | 75 – 100 | 1 | 1 | 11 |
| Маш их | 100 < | 9 | 2 | 19 |

## 4.9. Хот суурин газруудын засаг захиргааны бүтэц зохион байгуулалтын судалгаа

“Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын хүрээнд 2018 оны 09 сарын дугаар сарын 13-ны өдөр 21 аймгийн төвийн сумд болон аймгийн зэрэглэлтэй 3 сумдын засаг дарга нарт 1/1777 тоот албан бичгийг хүргүүлж хот, тосгоны захирагчийн алба болон орон нутгийн захиргааны бүтэц зохион байгуулалтын судалгааг авлаа. Тус судалгаагаар 19 сум хот,тосгоны захирагчийн ажлын алба ажилладаг, 7 суманд ажилладаггүй гэсэн дүн гарсан. Сумдын засаг даргын тамгын газрын бүтэц бүрэлдэхүүнийг задалж харахад захирагчийн албанд ажиллаж байгаа албан хаагчтай адил албан тушаалтай хүмүүс 2-4 байгаа юм. Мөн бид хот тохижилтын газар/хэлтэстэй хот тосгоныг судалгаанаас үзэхэд зарим сумдын хот тохижилт үйлчилгээний газар нь захирагчийн албанд, зарим нь аймаг болон сумын засаг даргын тамгын газарт харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Түүнчлэн орон тоо ажиллах хүчний хувьд харилцан адилгүй, зарим албан хаагчид 2-3 албан тушаалыг хашиж

байна иймээс энэхүү судалгаа нь засаг, захиргааны бүтэц, ажиллах хүчний зөв хуваарилалтын талаар асуудал их байна гэдгийг харуулж байна.

Хүснэгт 15. 24 сумдын засаг дарга нараас ирсэн албан бичиг

| № | Сумдын нэр | Явуулсан албан бичиг | | | Ирсэн албан бичиг | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Он, сар, өдөр | Хавсралт /хуудас/ | Дугаар | Он, сар, өдөр | Хавсралт /хуудас/ | |
| 1. | Архангай аймгийн Эрдэнэбулган | 1/1777 | 2018/09/13 | 3 | 3/519 | 2018/09/20 | 3 | |
| 2. | Баян-Өлгий аймгийн Өлгий | | | | | | | Цахим хаяг |
| 3. | Баянхонгор аймгийн Баянхонгор | | | | 461 | 2018/09/24 | 4 | |
| 4. | Булган аймгийн Булган | | | | | | | Цахим хаяг |
| 5. | Говь-Алтай аймгийн Есөнбулаг | | | | 2/393 | 2018/09/24 | 4 | |
| 6. | Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр | | | | Шаардлага биелүүлээгүй | | | |
| 7. | Дархан-Уул аймгийн Дархан | | | | 2/1526 | 2018/09/24 | 3 | |
| 8. | Дорноговь аймгийн Замын-Үүд | | | | 1/1062 | 2018/09/24 | 4 | |
| 9. | Дорноговь аймгийн Сайншанд | | | | 1/1724 | 2018/09/24 | 7 | |
| 10. | Дорнод аймгийн Хэрлэн | | | | 2/620 | 2018/09/19 | 4 | |
| 11. | Дундговь аймгийн Сайнцагаан | | | | 2/494 | 2018/09/24 | 3 | |
| 12. | Завхан аймгийн Улиастай | | | | | | | Цахим хаяг |
| 13. | Орхон аймгийн Баян-өндөр | | | | 2/1529 | 2018/09/24 | 8 | |
| 14. | Өвөрхангай аймгийн Арвайхээр | | | | | | | Цахим хаяг |
| 15. | Өвөрхангай аймгийн Хархорин | | | | 3/280 | 2018/09/19 | 4 | |
| 16. | Өмнөговь аймгийн Даланзадгад | | | | 703 | 2018/09/24 | 13 | |
| 17. | Сүхбаатар аймгийн Баруун-Урт | | | | | | | Цахим хаяг |
| 18. | Сэлэнгэ аймгийн Мандал | | | | 3/2266 | 2018/09/19 | 10 | |
| 19. | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар | | | | | | | Цахим хаяг |
| 20. | Төв аймгийн Зуунмод | | | | | | | Цахим хаяг |
| 21. | Увс аймгийн Улаангом | | | | | | | Цахим хаяг |
| 22. | Ховд аймгийн Жаргалант | | | | 1/575 | 2018/09/24 | 4 | |
| 23. | Хөвсгөл аймгийн Мөрөн | | | | 1/840 | 2018/09/19 | 3 | |
| 24. | Хэнтий аймгийн Хэрлэн | | | | | | | Цахим хаяг |

| № | Аймгийн нэр | Хотын нэр | Сумын Засаг даргын тамгын газрын нийт орон тоо | Хот,тосгоны захирагчийн албатай эсэх | Хотын ЗАА ажилладаг хот, тосгодын нэр | Хаана харьяалагддаг тухай | Орон тоо | тохижилт үйлчилгээний газар/ ангитай эсэх | тохижилт үйлчилгээний газар/анги нь хаана харьяалагддаг эсэх | тайлбар/ СЗДТГ-т шаардлагатай байгаа орон тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Архангай | - | 21 | үгүй | - | - | - | тийм | - | 3 |
| 2. | Баян-Өлгий | Өлгий | 20 | тийм | Өлгий | СЗДТГ | 4 | тийм | - | 5 |
| 3. | Баянхонгор | Баянхонгор | 62 | үгүй | - | - | - | - | - | |
| 4. | Булган | - | 34 | үгүй | - | - | - | тийм | СЗДТГ | 34 |
| 5. | Говь-Алтай | Алтай | 17 | тийм | Есөнбулаг | СЗДТГ | 3 | тийм | - | 4 |
| 6. | Говьсүмбэр | | | үгүй | Албан бичиг дахин явуулах | | | | | |
| 7. | Дархан-Уул | Дархан | 31 | тийм | Дархан | АЗДТГ | 8 | - | - | 7 |
| 8. | Дорноговь | Сайншанд | 26 | тийм | Сайншанд | СЗДТГ | 4 | тийм | - | |
| 9. | Дорнод | Чойбалсан | 31 | тийм | Хэрлэн | СЗДТГ | 4 | үгүй | - | |
| 10. | Дундговь | Мандалговь | 37 | тийм | Сайнцагаан | АЗДТГ | 2 | тийм | - | |
| 11. | Завхан | - | 27 | үгүй | - | - | - | - | - | 52 |
| 12. | Орхон | Эрдэнэт | 111 | тийм | Эрдэнэт хот | АЗДТГ | 13 | тийм | ЗАА | 10 |
| 13. | Өвөрхангай | Арвайхээр | 41 | тийм | Арвайхээр хот | АЗДТГ | 5 | тийм | АЗДТГ | 4 |
| 14. | Өмнөговь | - | 39 | тийм | Даланзадгад | СЗДТГ | 103 | үгүй | - | 2 |
| 15. | Сүхбаатар | - | 46 | тийм | Баруун-урт | СЗДТГ | 4 | - | - | |
| 16. | Сэлэнгэ | - | 41 | тийм | Сүхбаатар | СЗДТГ | 4 | тийм | - | 1 |
| 17. | Төв | Зуунмод | 32 | тийм | Зуунмод | СЗДТГ | 3 | тийм | - | |
| 18. | Увс | Улаангом | 52 | үгүй | - | - | - | тийм | - | 57 |
| 19. | Ховд | Ховд | 49 | тийм | Жаргалант | СЗДТГ | 4 | тийм | - | |
| 20. | Хөвсгөл | Мөрөн | 31 | үгүй | - | - | - | тийм | - | |
| 21. | Хэнтий | Чингис | 40 | тийм | Тахилгат | СЗДТГ | 36 | тийм | АЗДТГ | 40 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тосгон | | | | | |
| | | | | | Өлзийт | СЗДТГ | 12 | | | |
| 22. | Замын-Үүд | - | 33 | тийм | Замын-Үүд | СЗДТГ | 8 | тийм | - | 8 |
| 23. | Зүүнхараа | - | 26 | тийм | Хэрх | СЗДТГ | 10 | тийм | - | 6 |
| | | | | | Түнхэл | СЗДТГ | 11 | | | |
| 24. | Хархорин | - | 40 | тийм | Хархорин | СЗДТГ | 10 | үгүй | - | - |
| Нийт дүн | | | | 7 үгүй | | | | | | |
| | | | | 19 тийм | | | | | | |

Хүснэгт 16. ХОТ, ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ БҮТЭЦ

| № | Аймгийн нэр | Хотын нэр | Сумын нэр | Хотын захирагч | Ерөнхий менежер | Албаны дарга | Хотын ерөнхий архитектор | Хотын архитектор | Дэд бүтэц, зам тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Газар зохион байгуулалт, барилга, дэд, бүтэц хариуцсан мэргэжилтэн | Дэд бүтэцхариуцсан мэргэжилтэн | Хөдөө аж ахуйн мэргэжилтэн | Нийгмийн бодлогын мэргэжилтэн | Зам тээвэр, харилцаа холбоо хариуцсан мэргэжилтэн | Үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | Нийтийн тээвэр, аялал жуулчлал, хотын экологи, ногоон байгууламж, ХАА, газар тариалан, ногоон хөгжил хариуцсан мэргэжилтэн | Тээвэр, авто зам хариуцсан мэргэжилтэн | Худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | Хог хаягдлын менежмент, хөрс болон орчны бохирдол, инженерийн дэд бүтэц, зам тээвэр реклам сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн | Ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн | Зам талбай хариуцсан мэргэжилтэн | Хот тохижилт, ногоон байгууламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Хот тохижилт, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Архангай | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2. | Баян-Өлгий | Өлгий | Өлгий | | | | 1 | | | | 1 | | | | | | | 1 | | | | | |
| 3. | Баянхонгор | Баянхонгор | Баянхонгор | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4. | Булган | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5. | Говь-алтай | Алтай | Есөнбулаг | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6. | Говьсүмбэр | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7. | Дархан-Уул | Дархан | Дархан | | | 1 | | | | | | | | | | | | | | | | | |
| 8. | Дорноговь | Сайншанд | Сайншанд | | | 1 | | 1 | | | | | | 1 | | | | | | | | | |
| 9. | Дорнод | Чойбалсан | Хэрлэн | | | 1 | | 1 | 1 | | | | | | | | | | | | | | 1 |
| 10. | Дундговь | Мандалговь | Сайнцагаан | | 1 | 1 | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11. | Завхан | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 12. | Орхон | Эрдэнэт | Баян-Өндөр | | | 1 | | 1 | | | | | | | | | | | | | | 1 | |
| 13. | Өвөрхангай | Арвайхээр | Арвайхээр | | 1 | | | 1 | | | | | | | 1 | | | | | 1 | | | 1 |
| 14. | Өмнөговь | | Даланзадгад | | | 1 | | | | | | | | | | | | | | 3 | 1 | 1 | |
| 15. | Сүхбаатар | | Баруун-Урт | | | | | | | 1 | | | | | | | | | | | | | |
| 16. | Сэлэнгэ | | Сүхбаатар | | | 1 | | | | | 1 | | | | | | | 1 | | | | | |
| 17. | Төв | Зуунмод | Зуунмод | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 18. | Увс | Улаангом | Улаангом | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 19. | Ховд | Ховд | Жаргалант | | | | | | | | 1 | | | | | 1 | | | 1 | | | | |
| 20. | Хөвсгөл | Мөрөн | Мөрөн | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 21. | Хэнтий | | Тахилгат | 1 | | | | | | | | 5 | 2 | | | | | | | | | | |
| | | | Өлзийт | 1 | | 1 | | | | | | 1 | | | | | | | | | | | |
| 22. | Замын-Үүд | | Замын-Үүд | 1 | | 1 | | 1 | | | | | | | | | 1 | 1 | | 1 | | | |
| 23. | Зүүнхараа | | Хэрх | 1 | | | | | | | | 1 | | | | | | | | | | | |
| | | | Түнхэл | 1 | | | | | | | | 1 | | | | | | | | | | | |
| 24. | Хархорин | | Хархорин | | | | | | | | | | | | | | | | | | | | 1 |
| Нийт дүн | | | | 5 | 2 | 9 | 1 | 5 | 1 | 1 | 3 | 8 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 3 | 1 | 5 | 1 | 2 | 3 |

**Хүснэгт 7.** Хот, тосгоны захирагчийн ажлын албаны бүтэц

| № | Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн | ЗАА-ны ахлах мэргэжилтэн | Барилга хөрөнгө оруулалт СӨХ хариуцсан мэргэжилтэн | Сантехникч | Сүлжээний инженер | Автотехнизийн засварчин | Байцаагч | Цахилгаан эрчим хүчний асуудал хариуцсан мэргэжилтэн | Цахилгаанчин | Зам талбайн үйлчлэгч | Галч | Үйлчлэгч | Цэцэрлэгч | Сахиул | Харуул/ жижиүүр | Ачигч | Ялгагч | Жолооч | Нягтлан | Нярав | Бичиг хүргэгч | Төрийн сангийн төлөөлөгч | Хуулийн зөвлөх, хүний нөөц | Бичиг хэргийн ажилтан | Барилгын Инженер | Худалдаа, үйлчилгээ, тохижилт хариуцсан мэргэжилтэн | Барилгын инженер ахлах мэргэжилтэн | Байгаль орчин, аялал жуулчлал, хот тохижилт хариуцсан мэргэжилтэн | СӨХ хариуцсан ажилтан | Хот төлөвлөлт, барилга, орон сууц, нийтийн аж ахуй, ХААжиллагаа хариуцсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2. | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5. | | 1 | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 1 | | | | |
| 6. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7. | | | | | | | | | | | | | | | | | | 1 | | | | | | | | | | | | |
| 8. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 9. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 10. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 11. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 12. | | | | | | | | 1 | | | | | | | | | | 1 | 1 | | | | 1 | 1 | 1 | | 1 | | | |
| 13. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 14. | | | | 2 | 2 | 1 | 1 | | 4 | 23 | 1 | 4 | 5 | 3 | 13 | 13 | 5 | 16 | 1 | 1 | 1 | | | 1 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15. | | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 1 | 1 | |
| 16. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 17. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 1 |
| 18. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 19. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 20. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 21. | | | | | | | | | | | 7 | | | | | | | 8 | 4 | 6 | 3 | | | | | | | | | |
| | | | | | | | 1 | | | | 4 | | | | | | | 1 | | 1 | 1 | | | | | | | | | |
| 22. | | | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 23. | | | | | | | | | | | | 1 | | | 2 | | | 1 | 1 | 1 | | 1 | | 1 | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | 2 | | | 2 | 1 | 1 | | 1 | | 2 | | | | | | |
| 24. | | | | 1 | | | | | | | | | 2 | | | 3 | | 3 | | | | | | | | | | | | |
| нийт | 1 | 2 | 2 | 3 | 2 | 1 | 2 | 1 | 4 | 23 | 12 | 5 | 7 | 3 | 17 | 16 | 5 | 33 | 8 | 10 | 5 | 2 | 1 | 5 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |

| № | Хот төлөвлөлт, хотын тохижилт соёлжилт, худалдаа үйлчилгээ, худалдан авах ажиллагаа, дотоод асуудал, хэвлэл мэдээлэл олон нийт хариуцсан мэргэжилтэн | Барилга хот төлөвлөлт ногоон байгууламж газар ашиглалт хог хаягдлын менежмент хариуцсан мэргэжилтэн | Эдийн засагч статистикч | Санхүү нягтлан бодох бүртгэл, хүний нөөц, бичиг хэрэг | НЗОС-ны хувьчлал, СӨХ-ны үйл ажиллагаа, хугацаат мэдээ тайлан | Төсөвчин | Дулааны инженер | Инженер, барилга, шугам сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн | Дэд бүтэц хариуцсан ахлах мэргэжилтэн /Зам тээвэр, мэдээлэл холбоо, дулаан, цэвэр ус, ариутгах татуурга, цахилгаан | Хот тохижилт, ногоон байгууламж, төв суурингийн усан хангамж, орчиний аюулгүй байдал хариуцсан улсын байцаагч /хог хаягдал, реклам, зар сурталчилгаа/ | Дэд бүтэц, дулаан цэвэр бохир ус, үерийн байгууламж, инженерийн шугам сүлжээ хариуцсан | Дулаан, ус, цахилгаан инженерийн шугам сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн | Цахилгаан эрчим хүчний хангамж, дтспетчерийн шуурхай удирдлага хариуцсан | НААУГ-ын үйл ажиллагаа, хот тохижилт мэдээллийн байгууламж, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах | НИЙТ | ЗАА-нд шаардлагатай байгаа орон тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | | | | | | | | | | | 0 | |
| 2. | | | | | | | | | | | | | | | 4 | |
| 3. | | | | | | | | | | | | | | | 0 | |
| 4. | | | | | | | | | | | | | | | 0 | |
| 5. | | | | | | | | | | | | | | | 3 | 1 |
| 6. | | | | | | | | | | | | | | | 0 | |
| 7. | | 1 | | 1 | 1 | | | | | | 1 | | 1 | 1 | 8 | 8 |
| 8. | | | | | | | | | | | | 1 | | | 4 | |
| 9. | | | | | | | | | | | | | | | 4 | |
| 10. | | | | | | | | | | | | | | | 2 | |
| 11. | | | | | | | | | | | | | | | 0 | |
| 12. | | | | | | 1 | 1 | 1 | | | | | | | 13 | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13. | | | | | | | | | | | | | | | 5 | |
| 14. | | | | | | | | | | | | | | | 103 | |
| 15. | | | | | | | | | | | | | | | 4 | |
| 16. | | | 1 | | | | | | | | | | | | 4 | |
| 17. | | | | | | | | | 1 | 1 | | | | | 3 | |
| 18. | | | | | | | | | | | | | | | 0 | |
| 19. | 1 | | | | | | | | | | | | | | 4 | 1 |
| 20. | | | | | | | | | | | | | | | 0 | |
| 21. | | | | | | | | | | | | | | | 36 | |
| | | | | 1 | | | | | | | | | | | 12 | |
| 22. | | | | | | | | | | | 1 | | | | 8 | 4 |
| 23. | | | | | | | | | | | | | | | 10 | 1 |
| | | | | | | | | | | | | | | | 11 | 2 |
| 24. | | | | | | | | | | | | | | | 10 | |
| нийт | 1 | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 248 | 17 |

## 4.10. Судалгаа, шинжилгээ, харьцуулалт дүгнэлт

Өнөөгийн Монгол улсын хүн амын нутагшилтын тогтолцоо, чиг хандлагад анализ судалгааг хийж, хөгжлийн давуу болон сул тал, нөөц, боломжийг тооцсоны үндсэн дээр тогтвортой хөгжлийг хангах стратегийн зорилтыг тодорхойлно. Үндэсний нутагшилт, суурьшлын тогтолцоонд хүн ам, эдийн засагт эзлэх байр сууриас хамааралтай Улаанбаатар хотын үзүүлэх гол хүчин зүйлүүдийн нөлөөллийг нарийвчлан судлана.

Бэлчээрийн мал аж ахуй зонхилсон, хангай, хээр, говь, тал хосолсон өргөн уудам газар нутагтай, хүн амын тоо цөөн, нягтаршил бага, аж үйлдвэр сул хөгжсөн зэрэг шалтгаанаар 1950-иад оныг хүртэл хот, суурин газрын хөгжил эрчимжиж чадаагүй. Иймд Монгол Улсын хотжилтын ү йл явц харьцангуй залуу бөгөөд хот байгуулах туршлага, соёл дутмаг байдаг.

Монгол Улсад хуучин ЗХУ болон бусад социалист орны техник, эдийн засгийн туслалцаатайгаар нийслэл Улаанбаатар болон бусад томоохон хот, аймгийн төвд шинэ үйлдвэрийг барьж байгуулсны үр дүнд хотжилтын үйл явц түргэссэн. Энэ үед Улаанбаатар хэд хэдэн үе шаттайгаар хаяагаа улам тэлж, Дархан, Эрдэнэт, Налайх, Багануур зэрэг аж үйлдвэр, уул уурхайн шинэ хот баригдаж, Чойбалсан, Ховд зэрэг хотын хүн амын суурьшил нэмэгджээ.

Монгол Улсын хүн ам 1918 онд 647.5 мянга байсан бол 2017 оны байдлаар 3177 мянгад хүрч, XX зуунд бараг дөрөв дахин өсчээ. Томоохон өсөлт нь 1960 ба 1970-аад онд болж, тухайн үед хүн амын жилийн дундаж өсөлтийн коэффициент 3.0 хувьд дөхөж, хүн ам 25 хүрэхгүй жилийн дотор хоёр дахин өссөн ажээ. Эдгээр жилүүдэд төрөлт ихтэй байсантай холбогдон сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны залуучууд олноор нэмэгдэж байна. 1990 оноос хойш улс оронд үүссэн эдийн засгийн хямралтай холбогдон хүн амын өсөлт буурсан нь үндсэндээ төрөлтийн огцом бууралтын үр дүн байлаа.

Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын үндсэн 2 хэлбэр нь хот, хөдөө бөгөөд хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилт эрчимтэй явагдаж 2017 оны байдлаар 68,7 хувьд хүрээд байна. Тодруулбал нийт хүн амын 45 хувь нийслэлд (агломераци буюу том хот дагасан), 29 хувь нь нийт 350 хот, суурин газарт (Шугаман буюу авто замын тэнхлэг дагасан), үлдэх 26 хувь нь хөдөөд (жигд буюу засаг захиргааны нэгжүүд дагасан) амьдарч байна (Зураг 9).

**Зураг 9. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцооны өнөөгийн байдал**


Агломераци
Нийслэл = 1,4 сая
Давуу тал
• Том зах зээл
•Эдийн засгийн хурдацтай өсөлт
• Бизнесийн өрсөлдөх чадвар
Сул тал
• Орон нутгийн хөгжлийн нөөцийг (хүн, мөнгө) татах
• Өсөлтийг сааруулах (орчны бохирдлын зардал, замын түгжрэл)
• Орчны бохирдол
Хэт төвлөрөл
Монгол Улсын хүн ам 3,2 сая
Шугаман (тэнхлэг)
Аймаг, сумын төв, бусад суурин = 350 суурин газар 0,9 сая
Давуу тал
• Байгаль, экологийн эрүүл орчин
• Байгалийн жигд ашиглалт
• Нутаг дэвсгэр эзэнгүйдэх аюулгүй байдлыг багасгах
Сул тал
•Үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих зах зээл бага
• ХАА, уул уурхай, байгалийн нөөцийн орлогын хот руу чиглэсэн алдагдал
• Хүн амын гадагш шилжих хөдөлгөөн
• Хүн амын удмын сан, төрөл ойртолт
• Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиггүй байдал
Хэт сарнил
Хөдөөгийн иргэд 0,9 сая
Жигд тархалт

Хүснэгт 17. Хүн амын нутагшилт, суурьшлын байдалд хийсэн SWOT дүн шинжилгээ

| | |
|---|---|
| **Давуу тал** | • Хүн амын нутагшил, суурьшил, хөдөлгөөнд тавигддаг байсан засаг захиргаа, хууль эрх эдийн засгийн хориг саад багассан<br>• Зам тээвэр, эрчим хүчний харьцангуй сайн үндсэн сүлжээ бүрэлдсэн<br>• Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээний дэд бүтэц бүрэлдсэн<br>• Хүн амын нутаг дэвсгэрээр жигд тархан суурьшсан<br>• Хүн амзүйн цонх үе нээгдсэн<br>• Уул уурхай, үйлдвэрлэлийн хөгжлийг дагаад суурьшлын шинэ төвүүд бий болох таатай нөхцөл бүрдсэн |
| **Сөрөг тал** | **Хот байгуулалтын хувьд:**<br>- Хүн амын хэт төвлөрөл (1 хотод нийт хүн амын 44.0 хувь), хэт сарнил (350 гаруй хот, суурин газарт нийт хүн амын 30.0 хувь амьдардаг)<br>- Орон нутагт хүн ам, зах зээлийн зохистой төвлөрөл бүрдээгүйгээс ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн<br>- Хөдөөнөөс төвийг чиглэсэн их нүүдлээс шалтгаалж, нийслэлд хүн амын хэт төвлөрөл үүссэнээр авто зам, ус, цахилгааны хангамж зэргээр дэд бүтцэд сөргөөр нөлөөлөх болсон.<br>**Нийгмийн хувьд:**<br>- Засаг захиргааны хэт олон жижиг нэгжид хуваагдсанаар цус ойртолт зэрэг хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг<br>- Хэдий засаг захиргааны нэгж тус бүрт эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний дэд бүтэц байгаа ч чанар, хүртээмж муу учир өртөг зардал ихтэйгээр эдгээр үйлчилгээгээр төв рүү таталцдаг.<br>- Гадаадад 120.0 мянга гаруй монгол иргэн харьцангуй бага цалин хөлстэйгээр ажиллаж, амьдарч буй бол монголд 20.0 мянга орчим гадаадын иргэн харьцангуй өндөр цалин хөлстэй ажиллаж байна. Өөрөөр хэлбэл хүн ам, хөдөлмөрийн нөөц болон эдийн засгийн гадагш чиглэсэн урсгал харьцангуй их байна.<br>**Эдийн засгийн хувьд:**<br>- Аймаг, сум жижигрэх тусам 1 хүнд ногдох эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээний өртөг зардал нэмэгдэж, эсрэгээр тэдгээрийн чанар, хүртээмж тааруу байна.<br>- Төсвийн үрлэгэн тогтолцоо<br>- Эдийн засгийн хувьд аймаг, сумд нь улсын төсвөөс бүрэн хараат байдалтай<br>**Хууль, эрхзүйн орчны хувьд:**<br>- Сум, орон нутгийн бие даан хөгжих, нутгийн өөрөө удирдах эрхзүйн орчин маш сул<br>- Сум, орон нутгийн байгууллагын төсвийн эрх мэдэл бага.<br>**Экологийн хувьд:**<br>- Ажиллах хүчний дийлэнх буюу 34.0 хувийг эзлэх хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйн салбар уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг болж, энэ салбарт ажиллагсдын тогтвортой амьжиргаанд сөргөөр нөлөөлөх болсон.<br>- Нийт сумын тал орчим хувьд улирлын бэлчээр дутмаг.<br>- Усны хомсдол нэмэгдэж, усны сав газрын хэмжээнд олон сумд хамрагддаг нь тэдгээрийг усны нэгдсэн менемент хийхэд сул тал болдог. |
| **Аюул занал, эрсдэл** | - Нийт хүн амын 44.0 хувь оршин суух нийслэл Улаанбаатар хотод хүрээлэн буй орчны бохирдол, дэд бүтцийн ачаалал ихэссэнээс хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэхэд ноцтой аюулд хүргэж байна.<br>- Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн томоохон ордуудыг түшиглэсэн хот байгуулалтын бодлого байхгүйгээс ажилчид тогтвор суурьшилтай ажиллах, гэр бүлийн орчноос хол амьдарч байгаагаас үүдэлтэй гэр бүл салалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд гарч байна.<br>- Үйлдвэрлэлийн хөгжил, төвлөрлийг даган сүүлийн жилүүдэд нэмэгдсээр буй |

| | |
|---|---|
| | гадаадын ажиллах хүчний өсөлт, дотоодын ажиллах хүчний эрэлт хэрэгцээний хомсдол<br>- Орон нутгийн хөгжлийг уясан төсвийн хараат байдал |
| **Боломж** | - Хүн амд төрийн үйлчилгээг ойр хүргэх үүднээс аймаг, сум бүр дээрхи одоогийн төрийн үйлчилгээний (эрүүл мэнд, боловсрол зэрэг) дэд бүтцийг тогтвортой ашиглах шаардлагатай.<br>- Уул уурхай, үйлдвэрлэлийн өсөлтийг даган их хөрөнгийг үр ашигтай шингээх чадавхи бүхий шинэ хотыг төлөвлөн хөгжүүлбэл нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулж чадна. |

**Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоо алдагдсан байна.** Тухайлбал нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг хэрнээ нийт хүн амын нэг хотод ногдох хувиар дэлхийд тэргүүлж байна. Дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой Улаанбаатар хотод нийт улсын хүн амын 50 шахам хувь амьдарч байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд ноцтойгоор нөлөөлж байна. Иймд хотыг дахин төлөвлөж хөгжүүлэхээс өмнө Монгол Улсын болон нийслэлийн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой бодлогыг боловсруулах шаардлагатай байна. 2017-2022 онд Монгол Улсын хүн ам 3.2-с 3.5 сая болж, хотын хүн ам буюу нийслэлийн хүн ам 200-300 мянгаар нэмэгдэх төлөвтэй байна. Хэдий Оюутолгой, Тавантолгой, Сайншанд, Багануурын оюутны хотхоныг түшиглэсэн нийт 160-170 мянган хотын хүн амын төвлөрөл бий болохоор төлөвлөж буй хэдий ч тэдгээрт хүн амын суурьшлын шинэ төв бий болгох талаархи алхмууд удаашралтай байна.

Зураг 10. Монгол Улсын болон дэлхийн хотжилтын түвшин




Эх сурвалж: UN, Population Division, World population prospects 2017

Зураг 11. Хотын хүн амын нийт хүн амд эзлэх хувиар дэлхийн улсуудтай харьцуулалт, 2016




Эх сурвалж: UN, Population Division, World population prospects 2017

Монгол Улсад 1990 оноос хойш хотжилтын түвшин хурдацтай нэмэгдэж, 68,6 хувь буюу Итали, Унгар зэрэг өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хүрсэн байна. Иймд бусад өндөр хөгжилтэй орнуудын жишгийн дагуу хотуудад, ялангуяа нийслэл хотод хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах шаардлагатай. 1990-2017 онд Монгол Улсын хүн ам 2.0 саяас 3,2 сая болж, 55 хувиар, тэр дундаа хотын хүн ам 1.0 саяас 2.3 сая болж 2.3 дахин, нийслэлийн хүн ам 0.5 саяас 1.3 сая болж, 2.6 дахин ихээр өссөн байна. Үндсэндээ дээрх хугацаанд өссөн хүн ам нь нийслэлийн хүн ам болж байна.

Хүн ам ихээр шилжин ирж байгаагаас Улаанбаатар хотын дэд бүтэц, нийгэм, төрийн үйлчилгээний ачаалал даац нэмэгдэж, хотын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх боллоо. Сүүлийн 20 жилд шилжин ирэгсдийн тоог аймгуудын хүн амтай харьцуулбал нийт 8 аймгийн хүн амын тоотой дүйцэхүйц 452 мянган хүн орон нутгаас Улаанбаатар хотод шилжин иржээ. Улмаар Монгол Улсын хотжилтын түвшин дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүрсэн.




Зураг 12. Монгол Улсын хүн амын өсөлт, байршлаар

Өнгөрсөн зууны турш хүн амын тооны динамикаас харахад хөдөөгийн хүн амын тоо тогтвортой байгаа нь хөдөөд нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх хүн ам бэлчээрийн даацаас хамаараад харьцангуй тогтвортой байж ирснийг харуулж байна (Зураг 3). Харин хүн амын өсөлт нь үндсэндээ хотын хүн амын өсөлт байх хандлагатай байна. Аймгийн төв хотуудын хувьд төмөр замын тэнхлэг дагасан Эрдэнэт, Дархан, Сайншанд, Замын-Үүд, Чойр болон автозамын гол тэнхлэгүүдийг даган байршсан, автозамын гол тэнхлэгийн дагуух Налайх, Багануур, Баянхонгор, Арвайхээр хотуудын хүн ам өссөн тэнхлэгийн дагуух хот суурин газруудад нийгэм-эдийн засгийн таталцал явагдаж байгааг харуулж байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхэд давуу талаасаа сул тал нь илүү ихээр давамгайлсан байгаа өөрчлөлтийг хийх шаардлага нэгэнт тулгараад байгааг харуулж байна. Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн харилцаанд шилжсэнээр хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд нэлээд өөрчлөлт оржээ.

Хүснэгт 18. Хүн амын шилжих хөдөлгөөнд татаж буй болон түлхэж буй хүчин зүйлс

| | | | |
|---|---|---|---|
| **ТАТАХ ХҮЧИН ЗҮЙЛС**<br>Хөдөө орон нутгийн иргэдийг УБ хот болон Төвийн бүс рүү шилжин ирэх хөдөлгөөнд татаж буй | **Нийгэм:**<br>1. Гэр бүл, хамаатан садны хэлхээ холбоотой<br>2. Гэр бүл болох сонголт их<br>3. Боловсрол, эрүүл мэндийн сайн үйлчилгээнд татагдах<br>**Эдийн засаг:**<br>1. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд зах зээл том<br>2. Өргөн хэрэглээний барааны үнэ харьцангуй хямд<br>3. Хүн амын худалдан авах чадвар өндөр<br>4. Ажлын байр олох магадлал өндөр<br>5. Өндөр цалинтай ажил олох боломцоотой<br>6. ХАА-н бүтээгдэхүүний хэрэглэгчдийн зах зээлд ойр<br>**Хүрээлэн буй орчин:**<br>1. Зарим бүс нутгаас харьцангуй дулаан<br>2. Ойт хээр, хээрийн бүс нь зарим бүсээс газрын үржил шим илүү | **ТҮЛХЭХ ХҮЧИН ЗҮЙЛС**<br>Хөдөө орон нутгаас хүн амыг нийслэл рүү шилжин явах хөдөлгөөнд түлхэж буй | **Нийгэм:**<br>1. Ажилгүйдэл<br>2. Ядуурал<br>3. Боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээний чанар хүртээмж сул<br>4. Ялгаварлан гадуурхах үзэл илүү<br>5. Гэр бүл болох сонголт бага<br>**Эдийн засаг:**<br>1. Зах зээл бага<br>2. Ажлын байрны хомсдол<br>3. Хүнсний болон хувцас зэрэг өргөн хэрэглээний барааны үнэ харьцангуй өндөр<br>4. Дэд бүтэц сул<br>5. Хүн амын худалдан авах чадвар сул<br>**Хүрээлэн буй орчин:**<br>1. Уур амьсгалын өөрчлөлт<br>2. Ган, зуд, үеийн байгалийн гамшиг<br>3. Усны доройтол<br>4. Орчны бохирдол |

Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулахын тулд бүсүүдэд болон нийслэлийн дагуул хотуудыг нийслэлтэй өрсөлдөх чадвар бүхий татах хүчин зүйлстэй болгож хөгжүүлэх шаардлагатай юм.

Хүн амын өөрчлөлтийг нутагшилт, суурьшлаар нь аймгийн төв буюу хот, сумын төв, хөдөө нутгаар нь 2003-2013 оны өөрчлөлтийг дараахь зурагт харууллаа.

Зураг 13. Аймгийн төв, сумын төв болон сумдын хүн амын тооны өөрчлөлт




Улаанбаатар хотыг оруулаад нийт 22 аймгийн төв буюу улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин газраас 4 хотын хү ам буурсан, 10 хотын хүн амын хэвийн өсөлттэй, 8 хотын хүн ам механик өсөлтэй байна.

Харин сумын төв, суурин газраас 166 сумын төвийн хүн буурсан, 59 сумын төвийн хүн ам хэвийн өссөн, 92 сумын төвийн хүм механик өсөллтэй байна. Сумын түвшинд зөвхөн хөдөө нутагт нүүдэллэн амьдарч буй хөдөөгийн хүн амын өөрчлөлтөөр 215 сумын хөдөөгийн хүн ам буурчээ.

Зураг 14. Монгол Улсын хөдөөгийн сумдын хүн амын өөрчлөлт, 1990-2017 онд




Хүснэгт 19. Хүн амын тоо нь хамгийн ихээр өссөн хот, сум, суурин газрууд, 2005-2017 онд

| № | Хот, сум | 2005 | 2017 | Жилийн өсөлт % | Үүрэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цогтцэций | 2128 | 7262 | 20.1 | Уул уурхай |
| 2 | Ханбогд | 2618 | 6682 | 12.9 | Уул уурхай |
| 3 | Замын-Үүд | 8058 | 17880 | 10.2 | Гадаад худалдаа |
| 4 | Даланзадгад хот | 15810 | 24467 | 4.6 | Уул уурхай |
| 5 | Баруун-Урт хот | 13616 | 20713 | 4.3 | Засаг захиргаа |
| 6 | Улаанбаатар хот | 933971 | 1399094 | 4.2 | Засаг захиргаа, эдийн засаг |
| 7 | Налайх хот | 26112 | 36668 | 3.4 | Дагуул хот |
| 8 | Чойр хот | 8971 | 12531 | 3.3 | Засаг захиргаа |
| 9 | Гурвантэс | 3457 | 4799 | 3.2 | Уул уурхай |
| 12 | Өндөрхаан хот | 16849 | 22465 | 2.8 | Засаг захиргаа |
| 13 | Сайншанд хот | 18473 | 24415 | 2.7 | Тээврийн зангилаа, уул уурхай |
| 14 | Арвайхээр хот | 23566 | 31090 | 2.7 | Засаг захиргаа, тээврийн зангилаа |
| 16 | Алтанбулаг | 3913 | 5070 | 2.5 | Гадаад худалдаа |

Сүүлийн 12 жилийн хугацаанд хүн амын тоо хамгийн ихээр өссөн хот, суурин газруудад уул уурхай дагасан Өмнөговь аймгийн Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сум, Даланзадгад хот, гадаад худалдаа хилийн боомт дагасан Замын-Үүд сум болон засаг захиргааны төв болсон Улаанбаатар, Баруун-Урт хот орж байна.

ЗУРАГ 15. МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨГИЙН 309 СУМДЫН ХҮН АМЫН ТООНЫ АНГИЛАЛ, 2017 ОН




Монгол Улсын нийт хөдөөгийн сумдын хүн амын тооны ангиллаар 2017 оны байдлаар авч үзвэл нийт сумдын 53 хувь нь 3000 хүртэл хүнтэй, 86 хувь нь 5000 хүртэл хүнтэй бол ердөө 14 хувь нь 5000-аас дээш хүнтэй байна. Хүн амын тоог нутагшилт, суурьшлийн хувьд аймгийн төв буюу хот, сум суурин газраар 1996, 2006, 2017 оны орон зайн өөрчлөлтийг харууллаа.

Зураг 16. Хот, сум, суурин газруудын хүн амын тооны өөрчлөлт, 1996-2013 онд






Хүн амын тоог нутагшилт, суурьшлийн хувьд аймгийн төв буюу хот, сум суурин газраар 1996, 2006, 2017 оны орон зайн өөрчлөлтөөс харахад сумдын хүн амын тоо илүү ихээр буурсан нь тодорхой харагдаж байна.

Хүснэгт 20. Монгол Улсын хилийн боомт оршдог сумдын хүн амын тооны өөрчлөлт

| № | Аймаг, сум | Боомт | Зэрэглэл | Хүн амын тоо | | Хүн амын жилийн дундаж өсөлт, хувиар | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1990 | 2017 | 1990-2000 | 2000-2010 | 2010-2017 | 1990-2017 |
| **1. БНХАУ-тай хиллэдэг боомтууд** | | | | | | | | | |
| **1.1** | Дорнод, Халхгол | Сүмбэр-Рашаан | 2 талын түр | 1858 | 3047 | 9.8 | -1.1 | -1.0 | 2.4 |
| **1.2** | Дорнод, Халхгол | Баянхошуу-Өвдөг | 2 талын, байнгын | 1858 | 3047 | 9.8 | -1.1 | -1.0 | 2.4 |
| **1.3** | Дорнод, Чойбалсан | Хавирга-Ар Хашаат | 2 талын, байнгын | 2845 | 2725 | 0.6 | -1.1 | 0.2 | -0.2 |
| **1.4** | Сүхбаатар, Эрдэнэцагаан | Бичигт-Зүүнхатавч | олон улсын, байнгын | 4826 | 6677 | 2.1 | 1.1 | 0.4 | 1.4 |
| **1.5** | Дорноговь, Замын-Үүд | Замын-Үүд-Эрээн | олон улсын, байнгын | 1332 | 18241 | 36.0 | 12.5 | 4.6 | 47.0 |
| **1.6** | Дорноговь, Хатанбулаг | Ханги-Мандал | 2 талын, байнгын | 2761 | 2919 | 1.5 | -0.2 | -0.8 | 0.2 |
| **1.7** | Өмнөговь, Ханбогд | Гашуунсухайт-Ганцмод | 2 талын, байнгын | 1929 | 6978 | 2.0 | 5.3 | 14.0 | 9.7 |
| **1.8** | Өмнөговь, Гурвантэс | Шивээхүрэн-Сэхээ | 2 талын, байнгын | 2652 | 4869 | 2.3 | 3.1 | 2.1 | 3.1 |
| **1.9** | Говь-Алтай, | Бургастай- | 2 талын | 2000 | 2063 | 2.7 | -1.8 | -0.1 | 0.1 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Алтай | Ласемяо | түр | | | | | | |
| **1.10** | Ховд, Булган | Байтаг-Улиастай | 2 талын түр | 8545 | 10126 | 1.0 | -0.1 | 1.3 | 0.7 |
| **1.11** | Ховд, Булган | Булган-Такашикен | олон улсын, байнгын | 8545 | 10126 | 1.0 | -0.1 | 1.3 | 0.7 |
| **1.12** | Баян-Өлгий, Сагсай | Даян-Хуншанзюй | 2 талын, түр | 4765 | 5259 | 0.2 | -0.3 | 1.6 | 0.4 |
| **2. ОХУ-тай хиллэдэг боомтууд** | | | | | | | | | |
| **2.1** | Баян-Өлгий, Ногооннуур | Цагааннуур-Ташанта | олон улсын, байнгын | | 7976 | -4.1 | 0.4 | 1.1 | 0.7 |
| **2.2** | Увс, Тэс | Тэс-Шарсуурь | 2 талын, даваа-бямба | 7679 | 5273 | -1.1 | -2.4 | 0.2 | -1.2 |
| **2.3** | Увс, Давст | Боршоо-Хандгайт | 2 талын, байнгын | 2298 | 1703 | -1.7 | -1.0 | -0.3 | -1.0 |
| **2.4** | Завхан, Тэс | Арцсуурь-Цагаантолгой | 2 талын, даваа-бямба | 3055 | 2937 | 0.1 | 0.0 | -0.7 | -0.1 |
| **2.5** | Хөвсгөл, Ханх | Ханх-Монд | 2 талын, даваа-баасан | 1192 | 2783 | 8.5 | 1.3 | 1.7 | 4.9 |
| **2.6** | Сэлэнгэ, Алтанбулаг | Алтанбулаг-Хиагт | олон улсын, байнгын | 3714 | 5089 | -0.5 | 4.4 | 0.1 | 1.4 |
| **2.7** | Сэлэнгэ, Сүхбаатар | Сүхбаатар-Наушки | олон улсын, байнгын | 25346 | 22911 | -1.9 | 0.8 | 0.5 | -0.4 |
| **2.8** | Дорнод, Баян-Уул | Ульхан-Дээд Ульхан | 2 талын, даваа-баасан | 3988 | 4654 | 2.9 | -1.4 | 0.8 | 0.6 |
| **2.9** | Дорнод, Чулуунхороот | Эрээнцав-Соловьевск | олон улсын, байнгын | 2338 | 1785 | -3.1 | 0.2 | 1.3 | -0.9 |

Сүүлийн жилүүдэд ОХУ-тай харилцан визгүй горимоор зорчих болсонтой холбоотойгоор зорчигч тээврийн урсгал нэмэгдсэн болон БНХАУ-тай хил залгаа боомтуудаар уул уурхайн бүтээгдэхүүний экспорт ихээр нэмэгдсэнтэй холбоотойгоор хилийн боомтууд дагасан сумдын хүн амын тоо өсч байна.

**Засаг захиргааны нэгжүүдээр хүн амын тоо ихээхэн ялгаатайгаас болж төрийн үйлчилгээний чанар, хүртээмж ихээхэн ялгаатай байна.**

Тухайлбал Улаанбаатар хотын дүүргүүдийн хүн амын тоо өөр хоорондоо 82 дахин их, хороодын хүн амын тоо 35 дахин их, аймгийн хүн амын тоо 8 дахин их, багийн хүн амын тоо 50 дахин ихээр хоорондоо зөрүүтэй байна. Түүнчлэн засаг захиргааны нэгжүүд, хот суурин газруудын ангиллын тодорхой шалгуур үзүүлэлтүүд байхгүйгээс болж хүн амын тоогоор сумаас том баг, аймгаас том сум, дүүргээс том хороо, хотоос тосгон байсаар байна. Үүнээс хамаарч боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны үйлчилгээний чанар хүртээмж сул байна. Учир нь хэт цөөн хүнтэй засаг захиргааны нэгжид чадавхитай боловсон хүчин дутагдалтай байгаагаас болж үйлчилгээний чанар муу байгаа бол хүн амын тоо хэт их нэгжид төрийн үйлчилгээний хүртээмж сул байна.

**Зураг 17. Аймгуудын 1 суманд ногдох дундаж хүн амын тоо, 2017 он**




**Зураг 18. Аймгуудын 1 багт ногдох дундаж хүн амын тоо, 2017 он**



Зураг 19. Улаанбаатар хотын дүүргийн хүн амын тоо, 2017 он




Баянзүрх дүүргийн хүн 336 мянгад хүрснээр Багахангай дүүргээс 82 дахин их хүнтэй болсон нь төрийн албан хаагчдын төрийн үйлчилгээний ачааллыг эрс нэмэгдүүлж байна.

**Зураг 20. Улаанбаатар хотын дүүргүүдийн 1 хороонд ногдох хүн амын дундаж тоо, 2017 он**



**Зураг 21. Улаанбаатар хотын хамгийн олон болон цөөн хүн амтай 10 хороодын хүн амын тоо, 2017 он**



# V. ОРОН НУТГИЙН СУДАЛГАА

Орон нутгийн судалгааны хүрээнд говийн бүсийн 4 аймаг болон Увс, Орхон, Дорнод, Архангай аймагт ажилласан бөгөөд судалгааны явцад аймгийн ХАНСХЕТ боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах Ажлын хэсэгт ХАНСХЕТ төслөө танилцуулж, ажлын хэсгийн хурлыг хийсэн. Мөн сумдад ХАНСХЕТ төслийн танилцуулга хийсэн. Аймаг, сум бүрээс нийт хөгжлийн болон хот байгуулалттай холбоотой 5-10 баримт бичиг авч, 30 гаруй сэдвээр маягтын дагуу статистикийн мэдээ материалыг цуглуулж, фото зургийн болон дүрс бичлэгийн камер болон дроноор бичлэг хийж, баримтжуулах судалгааг хийсэн. Мөн фокус бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагыг хийж, домофон бичлэгээр ярилцлагыг бичиж авсан.

Хүснэгт 21. Томилолтоор ажиллах хугацаанд цуглуулсан мэдээ материалуудын жагсаалт

| № | Агуулга | Хэвлэгдсэн он | Хамрах хугацаа | Хуудас |
|---|---|---|---|---|
| | **1. Хэвлэмэл хэлбэрээр** | | | |
| 1.1 | Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг | 2015-2018 | 2016-2025 | 150 хх |
| 1.2 | Сумдын хөгжлийн бодлогын баримт бичиг | 2015-2018 | 2016-2021 | 250 хх |
| 1.3 | Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө | 2017 | 2017 | 150 хх |
| 1.4 | Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр | 2016 | 2016-2020 | 10 хх |
| 1.5 | Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр | 2016 | 2016-2020 | 10 хх |
| 1.6 | Аймгийн түүхт ойн хүрээнд гаргасан нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны талаархи нэгдсэн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий ном | 2011-2018 | 2011-2018 | 350 хх |
| 1.7 | Сумын түүхт ойн хүрээнд гаргасан нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны талаархи нэгдсэн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий ном | 2011-2018 | 2011-2018 | 250 хх |
| 1.8 | Аймгийн аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр | 2015-2018 | 2017-2025 | 5 хх |
| 1.9 | Сумын аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр | 2015-2018 | 2017-2025 | 5 хх |
| 1.10 | Аймгийн жилийн статистикийн эмхэтгэл | 2010-2018 | 2010-2017 | 65 хх |
| 1.11 | Аймгийн аялал жуулчлалын газрын зураг | 2015-2018 | 2015-2018 | хх |

| 2. Тоон хэлбэрээр цуглуулсан мэдээ материалууд | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1 | Аймгийн сумдын газрын нэгдмэл сангийн тайлан | 2010-2017 | 2010-2017 | 20 хх |
| 2.2 | Аймгийн жилийн статистикийн эмхэтгэл | 2010-2018 | 2010-2017 | 65 хх |
| 2.3 | Сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө | 2010-2018 | 2015-2025 | 350 хх |
| 2.4 | Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө | 2018 | 2017 | 150 хх |
| 2.5 | Аймаг, сумдын хүн амын тоо, багийн түвшинд | 2018 | 2010-2017 | 80 хх |
| 2.6 | Сумдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн мэдээ, багийн түвшнээр | 2018 | 2010-2017 | 100 хх |
| 2.7 | Сумдын газар тариалангийн үйлдвэрлэлийн мэдээ | 2018 | 2010-2017 | 55 хх |
| 2.8 | Аймаг, сумдын боловсролын байгууллагын мэдээ, суралцагчид, хүчин чадал, багшлах боловсон хүчний тоогоор | 2018 | 2017-2018 | 85 хх |
| 2.9 | Аймгийн хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний мэдээ | 2018 | 2010-2018 | 55 хх |
| 2.10 | Сумдын төрийн захиргааны байгууллагын ажиллагсдын тоон мэдээ | 2018 | 2018 | 35 хх |
| 2.11 | Сумдын эрүүл мэндийн байгууллагын тоон мэдээ, хүчин чадал, зэрэглэл, боловсон хүчин, үйлчлүүлэгсдийн тоо | 2018 | 2018 | 25 хх |
| 2.12 | Хилийн боомтоор нэвтэрсэн гадаад, дотоодын зорчигсдын тоо болон ачаа нэр төрлөөр | 2018 | 2010-2018 | 35 хх |
| 2.13 | Аймаг, сумдын орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл | 2018 | 2018 | 5 хх |
| 2.14 | Аймаг, сумдын нутагт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй орд газруудын талаархи мэдээлэл | 2018 | 2018 | 5 хх |
| 2.15 | Аймаг, сумдын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаархи үнэлгээний мэдээ | 2018 | 2016-2020 | 10 хх |
| 2.16 | Аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаархи тайлан | 2017-2018 | 2018 | 5 хх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.17 | Аймаг, сумдын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын талаархи мэдээ | 2017-2018 | 2018 | 5 хх |
| 2.18 | Замын-Үүд чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө | | | |
| 2.19 | Хамрын хийдийн аялал жуулчлалын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | 2017 | 2017-2020 | 2 хх |

### Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймагт ажилласан тухай

**Ажлын зорилго**: Төвийн даргын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна”, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.79-д “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах”, мөн Засгийн газрын 2017 оны 05 дугаар тогтоолд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах”-аар тус тус заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн танилцуулга хийх, анхан шатны шаардлагатай нийгэм-эдийн засгийн мэдээ, материал цуглуулах, орон нутгийн саналыг тусгах, орон нутагт байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтарч ажиллахад оршино.

**Ажилласан хугацаа:** 2018 оны 10 дугаар сарын 23 –аас 11 дүгээр сарын 4-ийг дуустал 12 хоног томилолтоор ажиллав.

**Багийн бүрэлдэхүүн:** Төвийн бүсийн өмнөд хэсгийн Говь-Сүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь гэсэн 4 аймгуудын нутгаар “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын орон нутгийн судалгааны ажлаар 8 хүний бүрэлдэхүүнтэй 2 баг ажиллав. Багийн бүрэлдэхүүнд Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Давааням, газарзүйч, бүс нутаг судлаач Д.Отгонбат Г.Балжмаа, газар зохион байгуулагч Б.Идэрхангай болон Хот суурин, дэд бүтцийн судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн хот төлөвлөлтийн эдийн засагч А.Сугар, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн Б.Ганпүрэв, архитектор Б.Цолмон нар ажиллав.

**Нэгдүгээр маршрут:** Улаанбаатар хот - ГС. Чойр - ГС. Шивээговь - ДГ. Айраг - ДГ. Иххэт - ДГ. Алтанширээ - ДГ. Сайншанд хот - ДГ. Зүүнбаян - ДГ. Өргөн - ДГ. Эрдэнэ - ДГ. Замын-Үүд - ДГ. Улаанбадрах - ДГ. Хөвсгөл - ДГ. Хатанбулаг - ӨМ. Ханбогд - ӨМ. Оюутолгой - Даланзадгад хот - Улаанбаатар хот /Нийт 2778 км/

**Хоёрдугаар маршрут:** Улаанбаатар хот - ДУ. Говь-Угтаал - ДУ. Гурвансайхан - ДУ. Мандалговь хот - ДУ. Эрдэнэдалай - ӨМ. Мандал-Овоо - ӨМ. Булган - ӨМ. Сэврэй - ӨМ. Гурвантэс - ӨМ. Ноён - ӨМ. Баяндалай - ӨМ. Даланзадгад хот - ӨМ. Цогтцэций - ӨМ. Баян-Овоо - ӨМ. Ханбогд - ӨМ. Оюутолгой - ӨМ. Даланзадгад хот - Улаанбаатар хот /Нийт 2940 км/

Дээрхи маршрутийг тогтоохдоо хуучин сум дундын төв буюу бүлэг суурингийн төвүүдийг хамруулж гаргав.




*Зураг. Маршрут-1 чиглэл*



**Гүйцэтгэсэн ажил**:

1. *“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн орон нутаг дахь ажлын хэсгийг хуралдуулж мэдээлэл өгөх,*

Говьсүмбэр аймгийн Чойр хотод 2018.10.24-25-хооронд ажиллаж аймгийн засаг даргын А/248 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралд Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи танилцуулга хийж, ажлын явцын талаар мэдээлэл хийсэн мөн аймгийн талаас танилцуулга хийж санал солилцож хамтран ажиллалаа. Ажлын хэсгийн гишүүд болох аймгийн /*Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийн хөтөлж хавсаргав*/ Аймгийн тамгын газарт шаардлагатай мэдээ материалуудын жагсаалтыг хавсралтаар гаргаж албан бичгээр хүргэсэн. Говьсүмбэр аймгийн ГХБХБГ-ын дарга Б.Отгончимэг, аймгийн ерөнхий архитектор бөгөөд барилгын хэлтсийн дарга Б.Даваажаргал нартай хамтран ажиллаж аймгийн нийгэм эдийн засгийн байдал, хот төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлуудтай танилцав.

Дорноговь аймгийн Сайншанд хотод 2018.10.26-28-ний хооронд ажиллаж 2018 оны 10 дугаар сарын 26-ны 18 цагаас ажлын хэсгийн хурлыг хуралдуулж Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи 45 минутийн танилцуулга хийж, мөн аймгийн талаас танилцуулга хийж санал солилцож хамтран ажиллалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн зорилго, ач холбогдол, гарах үр дүн, хийгдэх ажлууд, мөн аймаг сумын тулгамдаж байгаа асуудлуудын талаар ярилцаж мэдээ мэдээлэл солилцож ажиллав.

Өмнөговь аймгийн Даланзадгад хотод 2018.11.01-03-ний хооронд ажиллаж 2018 оны 11 дүгээр сарын 2-ны 9 цагаас ажлын хэсгийн хурлыг хуралдуулж Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи 45 минутийн танилцуулга хийж, мөн аймгийн талаас танилцуулга хийж санал солилцож хамтран ажиллалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн зорилго, ач холбогдол, гарах үр дүн, хийгдэх ажлууд, мөн аймаг сумын тулгамдаж байгаа асуудлуудын талаар ярилцаж мэдээ мэдээлэл солилцож ажиллав.

Дундговь аймгийн Мандалговь хотод 2018.11.03-04-ний хооронд ажиллаж 2018 оны 11 дүгээр сарын 3-ны 17.30 цагаас ажлын хэсгийн хурлыг хуралдуулж Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи танилцуулга хийж, мөн аймгийн талаас танилцуулга хийж санал солилцож хамтран ажиллалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн зорилго, ач холбогдол, гарах үр дүн, хийгдэх ажлууд, мөн аймаг сумын тулгамдаж байгаа асуудлуудын талаар ярилцаж мэдээ мэдээлэл солилцож ажиллав.

2. *Аймаг, сумаас нийгэм-эдийн засгийн статистик мэдээлэл цуглуулах*

Үндэсний статистикийн хороо болон судалгаанд хамрагдсан аймаг сумдын статистикийн мэдээ, эмхэтгэл, аймгаас, сумдаас авах мэдээ материалуудыг жагсаалтын дагуу цаасаар болон цахим хэлбэрээр авлаа. /*Авсан мэдээ материалуудын жагсаалтыг хүснэгтээр хавсаргав*/

3. *Аймгийн ерөнхий архитектороос мэдээ материал солилцох,*

Судалгааны ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн Аймгийн ерөнхий архитектор Б.Даваажаргал, Дорноговь аймгийн Аймгийн ерөнхий архитектор Оюунтөгөлдөр, Замын-Үүд сумын архитектор Баярболд, Өмнөговь аймгийн Аймгийн ерөнхий архитектор Золбоо, Дундговь аймгийн Аймгийн ерөнхий архитектор Нэргүй нартай уулзаж тухайн аймаг сумдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байдал, ерөнхий төлөвлөгөөний

хэрэгжилтийн талаар мэдээлэл авч Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаар мэдээ материал солилцож ажиллалаа.

4. *Өмнө нь хийгдсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний материал цуглуулах,*

Говьсүмбэр аймаг 3 сумтай, Үүнээс Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг /Сүмбэр сум/ 2013 онд Форум арт ХХК боловсруулсан, Шивээговь сумын төвийн ерөнхий төлөвлөгөөг Нарт дизайн ХХК боловсруулсан, Баянтал сумын ерөнхий төлөвлөгөөг ХБХДТ ХХК боловсруулж экспертизийн шатанд явж байна. Эдгээр 2 сумын ерөнхий төлөвлөгөөний зураглал тайлбар бичгийг файлаар авлаа.
Дорноговь аймаг 14 сумтай, Үүнээс Алтанширээ, Иххэт, Дэлгэрэх, Хөвсгөл, Сайхан дулаан, Хатанбулаг, Улаанбадрах сумын ерөнхий төлөвлөгөөг 2015 онд Инженер геодези ХХК боловсруулсан. Даланжаргалан, Өргөн, Мандах сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Шинэ хотжилт ХХК гүйцэтгэхээр 2011 онд гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн боловч бүрэн дуусгаж хүлээлгэж өгөөгүй байна. Дээрхи сумдын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах шинээр төлөвлөлт хийх шаардлагатай байна. Хамрын хийдийн аялал жуулчлалын бүсийн ерөнхий төлөвлөгөөг Ньюурбанизм ХХК, Замын-Үүд боомтын ерөнхий төлөвлөгөө хийгдэж байна.
Өмнөговь аймаг 15 сумтай Ханбогд, Цогтцэций сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний материалуудыг цахим хэлбэрээр авч ажиллалаа.
Дундговь аймаг 15 сумтай

5. *Аймаг, сумын хөгжлийн бодлогын баримт бичигтэй танилцаж, хувилж авах.*

“Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого”-ийг Аймгийн 2003 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн ИТХ-ын 01 дүгээр тогтоолоор баталсан. Үүнд сумдыг бүлэг суурингийн тогтолцоонд оруулж баруун бүсэд Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг сумдыг хамруулж бүсийн төвийг Эрдэндалай, төвийн бүсэд Дэлгэрцогт Сайнцагаан, Өлзийт, Хулд, Луус сумдыг хамруулж бүсийн төвийг Сайнцагаан, зүүн бүсэд Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан сумдыг хамруулж бүсийн төвийг Говь-Угтаал суманд байхаар тогтоосон байна.
Дорноговь аймгийн зарим сумд эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөг 2024,2030 онуудаар товхимол хэлбэрээр гаргасан бөгөөд эдгээр товхимолуудыг авч ажиллав. Аймгийн хөгжлийн бодлого эрхзүйн баримт бичгүүд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны тайлан мэдээлэл, сумдын хөгжлийн хөтөлбөрийг цаасан болон файл хэлбэрээр авлаа.

Сум орон нутгийн мэдээллийг газар дээр нь нягтлан зохих шатны байгууллагуудаар албажуулан цаас болон цахим хэлбэрээр авах, нэгдсэн мэдээллийг цахим хэлбэрээр бүрдүүлэх нийт 4 аймаг 42 сумдын судалгааг жагсаалтын дагуу гаргуулж нийт 3400 орчим фото зураг авч баталгаажуулав.

## 5.1 ГОВЬСҮМБЭР АЙМАГ.

Улсын бага хурлын 1991 оны 6-р сарын 21-ны өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй Чойр хотыг байгуулжээ. Харин Улсын Их Хурлын 1994 оны 5-р сарын 6-ны өдөр 32 дугаар тогтоолоор Чойр хотын хилийн цэсээр Говьсүмбэр аймаг 1994 оны 8 сард байгуулагдсан.

**Байршил**: Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт хойд өргөргийн 46057’- 47002’, зүүн уртрагийн 1070 57’- 1090 04’-т байрладаг. Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км-ийн зайд оршдог.

Хойд талаараа Төв аймгийн Баянжаргалан, Баянцагаан, Баян сумдтай, зүүн ба зүүн хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дархан, Дэлгэрхаан сумдтай, баруун болон баруун өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэдэг.

**Талбай**: 5,5 мянган километр хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэй.

**Уур амьсгал**: Далайн түвшнээс дээш 1000-1200 метрийн өндөрт оршдог говь, тал хээр хосолсон эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм. Говьсүмбэр аймагт жилд унах тунадасны хэмжээ говийн бүсийнхээс илүү /дунджаар 200-250 мм/ бөгөөд температурын ялгаа зундаа +37, өвөл -37 градус байдаг. Говьсүмбэр аймаг нь нүүрс, тоосгоны шавар, эрдэс будаг, хайлуур жонш, шохойн болон бал чулууны байгалийн баялаг нөөцтэй.

***Баянтал сум***

*Өнөөгийн байдал:* БНМАУ-ын Бага хурлын 1990 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 34-р тогтоолоор Зөвлөлтийн цэргийн ангийн хотхоныг түшиглүүлэн Улаанбаатар хотын харьяа Баянтал хороо нэртэйгээр 1991 оны 1-р сард байгуулсан. Улсын бага хурлын 1991 оны 6-р сарын 21-ны өдрийн 46 дугаар тогтоолын дагуу 1991 оны 7-р сараас Чойр хотын Баянтал хороо болж, улмаар 1994 онд Засаг захиргааны шинэ бүтэц зохион байгуулалтанд орсноор Говьсүмбэр аймгийн Баянтал сум болон байгуулагдсан. Төвийн 1 дүгээр баг, хөдөөгийн 2 дугаар баг гэсэн 2 багтай нийт 418 өрхийн 1240 хүн амтай. Үүнээс эрэгтэй 630 буюу 50,82 хувь, эмэгтэй 610 буюу 49,18 хувийг тус тус эзэлдэг: Жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 66341 толгой мал тоологдож, урьд оноос 12% буюу 7220 толгойгоор өссөн дүнтэй байна. Сумын хэмжээнд шинээр 7 мянгат малчин нэмэгдэж, 1 мянгат малчин шилжин явсан, мал нь цөөрч мянгад хүрхээ больсон 2 малчин өрх нийт 20 мянгат малчинтай.

- Улаанбаатар хотоос 200 км-т
- Аймгийн төвөөс 27 км зайд байрладаг.

Төмөр замын 14, 16, 18-р зөрлөгүүдийг харьяалж, баруун талаараа Дундговь аймгийн Цагаандэлгэр, хойд талаараа Төв аймгийн Баян, Баянжаргалан, зүүн, урд талаараа Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум зэрэг сумдуудтай хиллэдэг.

**Газар нутаг:** Нийт газар нутгийн хэмжээ 91606 га.Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрүүд бий болж ажлын байр шинээр нэмэгдэж шилжин ирэх хүмүүсийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа. Мөн “Чойр эдийн засгийн чөлөөт” бүс шинээр байгуулагдаж байгаа. Энэ нөхцөл нь хүн амын шилжилт хөдөлгөөний тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж байна.Сумын хүн амын 80 хувь нь залуу болон дунд насныхан, 15 хувь нь хүүхэд, 5 хувь нь хөгшид байна. Тус суманд жилд Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-н салбар Тэжээлийн үйлдвэр“Бармааш” ХХК, Хүдрийн үйлдвэр “Бигом-Чойр” ХХК, Ноосны үйлдвэр “Чойр-Хайрхан” ХХК, Төмрийн үйлдвэр “Тамирын их урсгал” ХХК зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг.

Бүгд мал 66341 Үүнээс: Тэмээ-119, Адуу-3165, Үхэр-1225, Хонь-18493, Ямаа-14367 байгаа бөгөөд 80 малчин өрх, 66 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 34 хувийг эзэлж байна.

Цахилгаан Станц: Ус хангамж: Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 6 худаг, цэвэр усны 750 м, бохир усны 1.42 км урт шугам хоолойтой.Дулаан хангамж: Сумын төвд 1 төвлөрсөн уурын зуух, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 9 жилийн 4 дүгээр сургууль, 4 дүгээр цэцэрлэг, Соёлын төв, “Талын Илч” ОНӨГазар зэрэг бүх байгууллагууд, айл, өрхийн орон сууц нэгдсэн дулаантай, цэвэр бохирын шугаманд бүрэн холбогдсон.

Орон сууцны хангамж нь: Сумын төвд угсармал 5 давхар 6 барилга буюу 690 өрхийн 1-4 өрөө байртайгаас одоогоор 2 барилга нь ашиглалтанд орсон нэгдсэн инженерийн бүрэн хангамжтай. Цаашид үлдсэн барилгууд нь 100 мянган айлын хөтөлбөрт хамрагдаж Засгийн газрын 2012 оны 82 дугаар тогтоолоор үлдсэн 555 айл өрхийн орон сууцыг засварлахаар болсон.

*Тулгамдсан асуудал:* Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа боловч гүйцэтгэгч компаниас одоог хүртэл орон нутагт хүлээлгэж өгөөгүй байна.

***Шивээговь сум***

*Өнөөгийн байдал:* Улсын Бага Хурлын 1991 оны 6-р сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт Чойр хот байгуулах шийдвэр гарснаар Шивээговь хороо улсын зэрэглэлтэй Чойр хотын бүрэлдэхүүнд багтсан юм. Улсын Их Хурлын 1994 оны 5-р сарын 6-ны өдрийн 32 дугаар тогтоол гарч Чойр хотын хилийн цэсээр 1994 оны 8 дугаар сард Говьсүмбэр аймаг байгуулагдаж Шивээговь, Баянтал хороодыг сум болгон өөрчилсөн байна.

Одоо тус сум 85755 га эдэлбэр газар нутагтай. Зүүн, зүүн урд, урд талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан сум, баруун талаараа Дундговь аймгийн Баянжаргалан сум, хойд, зүүн хойд талаараа Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумтай хил залгадаг. Улаанбаатар хотоос 275 км, Говьсүмбэр аймгийн төвөөс 35 км, Дорноговь аймгийн төв Сайншандаас 210 км, Дундговь аймгийн төв Мандалговиос 186 км, Хэнтий аймгийн Дархан сумаас 90 км, Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас 50–иад км, Дундговь аймгийн Баянжаргалан сумаас 60 км зайтай байрлаж байна.

Тус сум нь Улаанбаатар, Замын үүдыг холбосон босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто замаар холбогдсон, монгол улсын хойд, урд хоёр хөрш орныг холбодог олон улсын транзит төмөр зам дайран өнгөрдөг, Багануураас Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, Шивээговь, Дундговь аймгийн Баянжаргалан сумыг холбосон цахилгаан эрчим хүчний 35, 110 Квт-ын өндөр хүчдэлийн шугамд холбогдсон, харилцаа холбоо зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн сум юм.

Сумын нийт хүн амын 80 хувь, айл өрхийн 70 орчим хувь нь төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдарч байна. Сумын хэмжээнд ЗДТГ, “Шивээ-Овоо “ХК, “Шивээ сервис” ХХК, сургууль, цэцэрлэг, соёлын төв, холбоо, цахилгаан түгээх сүлжээ, цагдаагийн хэсэг, “Илчлэг-Шивээ” ОНӨҮГазар, зочид буудал, ресторан, эмийн сан, супермаркет, дэлгүүрүүд, ШТСүлжээ гэх мэт 40 гаруй АБ, ААН-үүд үйл ажиллагаагаа явуулдаг.

"Шивээ-Овоо" ХК нь 550 гаруй ажилчидтай 2014 онд анхны 2 сая дахь тн нүүрсээ олборлон борлуулсан. улсын төсөвт говьсүмбэр аймгаас оруулж байгаа нийт төсвийн 83,7% буюу 721,5 тэрбум төгрөг оруулж Говьсүмбэр аймгийн төсвийн 75 хувийг дангаараа бүрдүүлж байна.

*Тулгамдсан асуудал:*

Одоогийн байдлаар Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан төлөвлөгөөгөөр хэрэгжиж чадахгүй байна. Учир нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр батлагдсан газар ашиглалтын бүсчлэл тэдгээр нь өнөөгийн байдлаар тухайн зориулалтын бүсчлэлээр ажиллахад сумын төвөөс хэт алслагдсан, дэд бүтэц тавигдаагүй, болон зах зээлээс хэт алслагдсан гэх шалтгаанаар хувь хүн болон ААН байгууллагад газар эзэмшүүлэх, өмчлүүлэхэд хүндрэлтэй байна.
Санал: Ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийлгэх

## 5.2 ДОРНОГОВЬ АЙМАГ.

Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. Аймгийн төв нь Сайншанд хот.

Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь оршин суудаг. Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүдийн, улирлын ажиллагаатай Баянбулаг-Мандалын боомтуудтай. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэн. Тус аймагт ЭМШИУС-ын Дорноговь аймаг дахь салбар сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын МСҮТөв, Ерөнхий боловсролын 23 сургууль, 17 дотуур байр, 21 цэцэрлэг, эрүүл мэндийн 72 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн төвд “Саран хөхөө” театр, Нийтийн номын сан, Музей сургалт судалгааны төв, ноён хутагт Данзанравжаагийн музей, Хүүхдийн ордон, сумдад соёлын төвүүд ажилладаг.

**Нутаг дэвсгэр**: 109,5 мянган кв км. Сайншанд хот нь Улаанбаатар хотоос 465 км, БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг.

**Засаг захиргаа:** 14 сум, 64 багтай

**Уур амьсгал.** Тус аймаг бүхэлдээ говийн бүсэд хамаардаг, говь хээр хосолсон нутагтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4,2-4,6 м/сек, зарим үед 35 м/сек хүртэл ширүүсэх тохиолдол бий. Цаг агаарын тааламжгүй нөлөөлөл болох хүчтэй цасан ба шороон шуурга, ган, зудын аюул цөөн бус удаа тохиодог, сүүлийн жилүүдийн хуурайшилтын улмаас цөлжилтийн явц хурдасч байна. Говийн эмзэг байгалийг нөхөн сэргээх боломж хязгаарлагдмал. Гадаргын усны нөөц бараг үгүйгээс гүний усыг татаж ахуй амьдрал болон мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд ашигладаг.

**Аж үйлдвэр, Тээвэр.** Гадаргад нь кайнозойн эриний хурдас их тархсан бөгөөд хайлуур жоншны орд олонтой. Зэс молибден (цагаан суварга), чулуун нүүрс (Алагтогоо), төмөр (Чандмань уул) болон барилгын материалын баялаг бий. Хайлуур, жонш олборлох уурхай байдаг. Дорноговь аймгийн нутгаар төмөр зам нэвтрэн єнгөрөх бөгөөд Сайншанд хот нь манай орны төмөр замын чухал зангилаа юм. Дорноговь аймгийн Замын-Үүд, Хангийн хилийн боомт нь Монголоос Хятад руу гарах хилийн том боомт юм.
**Боловсрол, эрүүл мэнд.** Дорноговь аймагт Ерөнхий боловсролын 20 сургууль, 17 дотуур байр, 21 цэцэрлэг, эрүүл мэндийн 72 байгууллага, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв зэрэг эрүүл мэнд, боловсролын байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг. Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн

нэрэмжит "Саранхөхөө" театр, Иргэдийн хөгжил төв, Усан спорт сургалтын төв, Нийтийн номын сан, Орон нутгийн судлах музей, Ноён хутагт Данзанравжаагийн музей, Орон нутгийн 3 телевиз, Дорноговийн мэдээ сонин зэрэг соёл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

***Даланжаргалан сум***

<u>*Өнөөгийн байдал:*</u> 1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харьяалагдан 1957 онд одоогийн төвлөрч байгаа Цомог хэмээх газарт суурьшсан байна. Тус сум 404.5 мян.га газар нутагтай, нутгийнхаа баруун болон хойд талаараа Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай, бусад талаараа өөрийн аймгийн Айраг, Иххэт сумдтай хиллэн оршдог. Нийслэл Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Сайншанд сумаас 156 км-т төвлөрдөг. Даланжаргалан сум нь засаг захиргааны анхан шатны Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-Овоо гэсэн 5 нэгжтэй, 2700 хүн амтай, 821 өрхтэй, 126,7 мян.толгой малтай, эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй, сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар цоо шинээр үүсэн хөгжиж байна. Сумын нутаг дэвсгэрээр Монгол орныг дамжин Ази Европ тивийг холбосон авто болон төмөр зам дайран өнгөрдөг төдийгүй, их хөлийн газар юм. Тус суманд ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, 300 гаруй сурагчидтай 9 жилийн болон бага сургууль, эрүүл мэндийн төв, 143 хүүхэдтэй “Номт ирээдүй” цэцэрлэг, соёлын төв, цагдаагийн хэсэг, Сүгмэл эм эргэлтийн сан, Зэвсэгт хүчний 281-р байгууламж зэрэг төрийн байгууллагууд, Боржгинтуяа хоршоо, Чандмана түрүү хоршоо, хувийн хэвшлийн Их жаргалан трейд, Говь оюу уул, Их голын говь, НИК, Чулуутдаваа, Дэлгэрэх-Уран-Эрдэнэ, Тэгшбаярлах, Даланчандмана, Мишээл арвижих, Налгархайрхан, Даланжаргалан оюу зэрэг ХХК-ууд, Эндвет ЗБН, Түмэнсүрэгмэндсайхан, АМАНА зэрэг ХХК-ууд хувийн мал эмнэлгүүд, Их Нартын БНГ-ын хамгаалалтын захиргаа, ХААН болон Төрийн банкууд, Ахмадын хороо, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Залуучуудын холбоо, ҮЭХолбоо, МАН-ын хороо, Ардчилсан намын хороо зэрэг ТББ-ууд, УБТЗ-ын харъяа Цомог, Олон-Овоо, Өлзийт зөрлөгүүд, Чулуун заводын үйлдвэр, МАК ХХК-ны “Элдэвийн нүүрсний уурхай”, Хагас коксын үйлдвэр, Өндөр буянт, Гермесгахиур, МАК ХХК-уудын Цементийн үйлдвэрийн төслүүд, Кевин инвест ХХК-ны жонш баяжуулах үйлдвэр, нүүрс олборлож буй Чингэсийн хар алт, Штайнколе, Пауэрленд ХХК-ууд, төмрийн хүдэр олборлох МГМК ХХК, жонш олборлох Талст дөл, Тэнүүн байгаль ХХК зэрэг албан байгууллага, ААН-үүд, ХХК-ууд байнгын үйл ажиллагаа явуулж байна. Даланжаргалан сум усан болон утаат болор, чүнчигноров, гартаам, мана, өнгөт чулуу, төмрийн хүдэр, хайлуур жонш, нүүрс, хүрмэн чулуу, бал чулуу, шохойн чулуу, барилгын материалын түүхий эд зэрэг ашигт малтмал элбэгтэй.

**Тулгамдсан асуудал:** Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй байгаа. Инженерийн шугам сүлжээний ажил 1989 онд хийгдэж байсан боловч зах зээл өөрчлөгдсөнөөр ажлын явц зогссон. Одоогоор инженерийн шугам сүлжээний ажлыг дахин хэрэгжүүлэхээр зураг төслийн шатанд явагдаж байгаа үүнийг түргэн шуурхай хэрэгжүүлэ дуусгах шаардлагтай. Сумын хэмжээнд ажиллах хүчний дутагдалтай суманд нийт 19 галч хэрэгтэй байгаагаас одоогоор 7 хүн ажиллаж 12 хүний дутагдалтай байна.

***Айраг сум***

<u>*Өнөөгийн байдал:*</u> Сайншанд сумаас баруун хойш 124 км, Улаанбаатар хотоос Зүүн урагш 330 км-т төмөр замын дагуу байладаг. Тус сум нь Ардын хувьсгалын өмнө Сэцэнхан аймгийн Боржигон Сэцэн вангийн хошуу нутаг бөгөөд 1937 оны өмнө Бага Нардын хийд, Нүдэнгийн гандан хийд, Хонгорын сайн усны хурал, Бударын хурал зэрэг 2 хийд 2 хурал, 8 жастай байжээ. Айраг сум нь анх 1927 онд 8 аравт, 130 өрх 600 хүн амтай байгуулагдсан бол 1959 онд 23? өрх,61? гишүүнтэй. 3900 толгой малтай, 98,3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй хөдөө аж ахуйн “ОЧ" нэгдэл байгуулагдаж байсан юм. Тус нэгдэл 1989 оны

байдлаар 900 орчим гишүүнтэй, 70000 малтай, 10 сая төгрөгийн хөрөнгөтэй, орлогынхоо 55-60 хувийг гишүүдийнхээ хөдөлмөрийн хөлсөнд олгодог байжээ. Одоогийн байдлаар Айраг сум нь 4 багтай 3599 хүн амтай 744000 км/ам нутагтай, 1028 өрх, түүнээс 231 малчин, 67000 малтай. Сумын төв нь Цагаандөрвөлж, Төсвийн 7 байгууллага,төрийн өмчит 3 нэгж, тусгай зөвшөөрөлтэй аж ахуй 7, патентаар үйл ажиллагаа явуулдаг 47, Газар нутгийн ихэнхэд жоншны илэрцтэй тул уул уурхай хөгжсөн учир жоншны ашиглалтын лиценцтэй 62 нэгж компани, хайгуулийн 62 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Тус суманд 320 хүүхдийн суудалтай ЕБСургууль, 50 ортой дотуур байр, 15 ортой хүн эмнэлэг, 75 ортой хүүхдийн цэцэрлэг, 100 суудалтай соёлын төв ажилладаг. Төвийн эрчим хүчинд холбогдсон, үүрэн телефоны үйлчилгээ нэвтэрсэн. Нийслэл болон аймгийн төвтэйгөө төмөр зам,авто засмал замаар холбогдсон томоохон сум юм. Энэ сумын нутагт Хэцүү тээгийн агуй, Бага нардын хад,Баруун цагаан дэлийн агуй, Нүдэнгийн хонхор, Бага тээгийн уул гэх мэт сонирхол татсан олон газар байдаг.

<u>Тулгамдсан асуудал:</u>
Айраг сум нь говь хээрийн бүс нутагт, хонхор газар авто болон төмөр замаар хүрээлэгдэн оршдог тул үер усны аюулд өртөх магадлал өндөр байдаг. 2018 онд Монгол орон даяар их хэмжээний үер усны аюулууд тохиолдсон тэдгээрийн хамгийн их хэмжээний хохиролд өртсөн сум Айраг сум юм. Одоогоор үерийн ус зайлуулах хоолой шуудуу хангалттай бус шаардлага хангахгүй байгаа үүнийг шинэчлэх орчин үеийн дэвшилтэд техник технологийг судлах түүнийг нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагтай байна. Үүнээс гадна 1980 онд үйл ажиллагаа явуулдаг байсан ч одоогоор устаж үгүй болоод байна тиймээс цэвэрлэх байгууламж барих шаардлагатай. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй. /Боловсон хүчний дутагдалтай ЕБС/

***Иххэт сум***

<u>Өнөөгийн байдал:</u> Сайншанд сумаас 170 км, Улаанбаатар хотоос 360 км зайтай байрладаг..
Тус сум нь ардын хувьсгалаас өмнө Сэцэн хан аймгийн Боржгин цэцэн вангийн хошуунд харьяалагдаж байсан ба Баруун Ганжуурын хийд, Элдэв хайлантын, Хашаатын, Өлзийтийн хурал, 1924 онд Оцол сансар уулын хошууны Цэнгэл Мааньт дараа нь Иххэт сум болжээ.

Одоо тус сум 4200 кв/км нутагтай. 3 багтай 2144 хүн амтай. 85288 толгой малтай. Төрийн 7 байгууллага, банк санхүүгийн 2 байгууллага,"Ингэт алтай "ХХК, худалдаа үйлчилгээний төв "Баян хэт" хоршоо, "Баян тэгш "ХХК" уул уурхайн компани зэрэг 10 гаруй нэгж ажилладаг. Төвийн эрчим хүчинд холбогдож үүрэн телефоны үйлчилгээ нэвтэрсэн. Тус суманд 410 хүүхдийн суудалтай ЕБСургууль, 60 ортой дотуур байр, 12 ортой хүн эмнэлэг, 100 ортой хүүхдийн цэцэрлэг, 180 суудалтай соёлын төв ажилладаг.

Улс болон орон нутгийн төсвөөр хийгдсэн хөрөнгө оруулалт 222.8 саяд хүрсэн.

Тал хээр, говь хөндий хосолсон зундаа 26.5 хэм дулаан, өвөлдөө 21.5 хэм хүйтэрдэг, дундажжр 7.2 мм хур тундас унадаг цаг агаарын тааламжтай бүс сайхан нутаг юм. Энэ нутагт жоншны арвин нөөцтэй учир Хажуу улааны жонш, Хашаатын нүүрс орд баялгууд бий. Энэ суманд Чингэсийн үе залгамжилсан 37 хаадын сүүчийн хаан болох Тогоон төмөр хааны эртний хотын балгас олон байшинтын туурь, Даяанчийн хад, Хүн чулуун хөшөө, Бурхантын гэрэлт хөшөө, бүсийн чулууны мэлхий сэнжит хад гээд эртний хаадын хот

суурингийн үлдэгдэл, байгалийн өөрөө бүтээсэн гайхамшигт сонин тогтоц арвин баялагтай сайхан нутаг юм.

_Тулгамдсан асуудал:_
Боловсон хүчний дутагдалтай төрийн албанд ажиллаж буй төрийн албан хаагчид удаан хугацаагаар ажилдаггүй, 12 жилийн бүрэн дунд боловсролын сургууль байхгүй 10 жилийн дунд боловсролын сургуултай үүнээс шалтгаалж ЕБС-ийн сурагчид Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дорноговь аймгийн Айраг сум, болон аймгийн төв Сайншанд хотод суралцдаг. Аялал жуулчлалын салбарт одоогоор батлагдсан чиглэл, хөтөлбөр, бодлого байхгүй. Бохир болон цэвэр устай хэрэглээний халуун ус одоогоор байхгүй. Нийгмийн үйлчилгээ болох зочид буудал, зоогийн газар, үсчин гэх мэт үйлчилгээний байгууллага ААН дутагдалтай.
Санал:

***Алтанширэз сум***

_Өнөөгийн байдал:_ Алтанширээ сум нь Аймгийн төвөөс 86 км, Улаанбаатар хотоос 450 км-т байрладаг. 7200 кв км нутагтай. Тус сум нь Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн Хондогын хошуу гэж олонд алдаршсан ба Хун дуут Чогдон хун тайж гэдэг уртын дуучаараа алдартай. Мөн Хондогын 20 босоо бөх, номч мэргэн гэвш Анги Шагдар зэрэг алдартан төрсөн нутаг.

2017 оны жилийн эцсийн байдлаар тус сум нь 4 баг, 1282 хүн амтай 111,092 толгой малтай, төсвийн зургаан байгууллагатай. Төвийн эрчим хүчинд холбогдож, үүрэн телефоны бүх оператор нэвтэрсэн. Тус суманд 320 хүүхдийн суудалтай ЕБСургууль, 30 ортой дотуур байр, 10 ортой хүн эмнэлэг, 50 ортой хүүхдийн Цэцэрлэг, 200 суудалтай Соёлын төв ажилладаг. Энэ суманд хүрэн нүүрс, хайлуур жонш, алт, төмрийн хүдэр, уран зэрэг байгалийн баялаг, нөөц ихтэйгээс гадна газрын тосны хэд хэдэн хайгуулууд хийгдэж байна.

Энэ сумын нутагт байгалийн сайхан Ширийн чулуу, Сэнжит хад, Хүрээ хийдийг холбосон гүнж их зам, Зэл чулуу, Цээлийн тогоо, Дэрсэнэ усны цагаан чулуун хөшөө, хаан хатны бүлш, Могой булаг, Буур мод гэх мэт хүний сэтгэлийг татах үзэсгэлэнт болон түүх дурсгалын газруудтай.

**Тулгамдсан асуудал:** Сумын хэмжээнд боловсон хүчний дутагдалтай /Малын эмч, хууль зүйн мэргэжилтэн гэх мэт.

***Зүүнбаян баг***

_Өнөөгийн байдал:_ Монгол улс зах зээлийн системд шилжин нийгмийн цоо шинэ тогтолцоонд орж шинэ үндсэн хууль батлагдсанаар улс орон даяар баг сумын тогтолцоотой болсон. Үүгээр 3-р хороо гэж 40-өөд жил нэрлэгдэж ирсэнийг 1993 онд шинээр зохион байгуулж 3-р баг болсон түүхтэй. Одоо аймгийн хамгийн их хүн ам, ААН, БА, олон малтай том баг болсон.

Сайншанд сумын 3 дугаар баг нь тус сумын зүүн, зүүн хойд хэсгээр оршдог 29713,5 мянган.га нутаг дэвсгэртэй. Багийн Засаг дарга, Бүртгэл мэдээллийн ажилтан-1, Ниймгийн ажилтан-1, Хэсгийн ахлагч-7, гэсэн нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 1770 өрх, 5711 хүн амтай. Үүнээс гэрт 800, байшинд 970 өрх амьдарч байна.Нийт хүн амын тоо 5704, үүнээс эмэгтэй 3025, эрэгтэй 26798үүнд: Хөдөлмөр эрхлэж байгаа: 1938, Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй: 752, Малчин өрх 77, мал бүхий 37 өрхтэй. 2016 оны жилийн эцсээр нийт малын тоо 28365 толгой мал тоолуулсан. Үүнд: Адуу-1936, Үхэр- 756, Тэмээ- 590, Хонь- 12206, Ямаа- 12877 толгой байна.

Тулгамдсан асуудал:
_Санал:_

***Өргөн сум***

<u>*Өнөөгийн байдал*</u>: Дорноговь аймгийн Өргөн сум нь 1924 онд байгуулагдсан. Хуучнаар Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу. Баянмөнх, Сүмийнбулаг, Сүмбэр, Сэнж гэсэн 4 анхан шатны нэгж болох багтай. Суманд нийт 1921 хүн 2013 оны эцэст тоологдсоноос 980 эрэгтэй, 938 эмэгтэй байна. Манай сум нь Их говийн зоригтний өлгий нутаг гэдгээрээ алдартай.

Манай сум нь Дорноговь аймгийн зүүн урд талд байрладаг. Сумынхаа зүүн урд талаар БНХАУ-тай 69 км газраар хиллэдэг. Урд талаараа тус аймгийн Эрдэнэ , зүүн талаараа Сүхбаатар аймгийн Баяндэлгэр , хойд талаараа өөрийн аймгийн Алтанширээ , баруун талаараа өөрийн аймгийн Улаанбадрах болон Сайншанд сумдтай тус тус хиллэдэг. Өргөн сум нь

- Улаанбаатар хотоос 507 км
- Аймгийн төвөөс 60 км
- БНХАУ-ын хилээс 230 км-т оршдог.

Малын сүргийн бүтэц:2013 оны эцэст манай сум нь 96802 толгой мал тоолуулан төрөл бүр дээрээ өссөн үзүүлэлт гарсан байна. Нийт малын 1.1 хувийг тэмээ,7.2 хувийг адуу, 4.6 хувийг үхэр, 42.8 хувийг хонь, 43.7 хувийг ямаа тус тус эзлэж байна.

Ерөнхий боловсролын сургууль:1940 онд байгуулагдсан. Хичээлийн байр нь 1974 онд баригдсан, 250 хүүхдийн хүчин чадалтай одоогоор 247 хүүхэд суралцаж, 30 багш, ажиллагсадтайгаар ерөнхий боловсролын үйл ажиллагаа явуулж байна.

Цэцэрлэг:1956 онд байгуулагдсан. Удирдах - 1, гүйцэтгэх - 4, үйлчилгээний - 6 ажилтантай , 68 хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсролыг олгож байна.

Эрүүл мэндийн төв:Сумын эрүүл мэндийн төв нь 1940 онд байгуулагдсан. 73 жилийн түүхтэй эмнэлэг. Тус эмнэлэг нь их эмч -1, дүн бүртгэгч их эмч-1, багийн бага эмч-3, эх баригч бага эмч-1, вакцинатор бага эмч-1, сувилагч-5, тогооч-1, үйлчлэгч-2, жолооч-1 ня-бо-1 гэсэн нийт 17 орон тоотойгоор эрүүл мэндийн үйл ажиллагааг явуулж байна.

Соёлын төв:Соёлын төвийн барилга 1991 онд ардтүмний хандиваар баригдсан. Соёлын төв нь эрхлэгч, бүжгийн багш, хөгжмийн багш, номын санч, үйлчлэгчгэсэн 5 оронтоотойгоор соёл урлагийн үйл ажилллагааг явуулдаг.

<u>*Тулгамдсан асуудал:*</u>

Боловсон хүчний хувьд их эмч 1, багийн эмч 1, сувилагч 2, бага ангийн багш 1, нийгмийн бодлогын мэргэжилтэн, хууль зүйн мэргэжилтэн дутагдалтай байна. Зөөврийн худгаас ундны усаа хангадаг. Одоогийн байдлаар ухаалаг худаг төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй. АННБ бүгд инженер техниктээ холбогдсон ч бохир усны асуудлыг шийдэж чадаагүй учир нь өдөрт 3 цагаар усаа тээвэрлэдэг усны нөөц бага бохирын усны хоолойн шугам сүлжээ тавигдаагүй байна. 12 жилийн бүрэн дунд боловсролын сургууль байхгүй 10 жилийн дунд боловсролын сургуултай сурагчид Сайншанд хот, Замын-үүд сумдад суралцдаг.

***Эрдэнэ сум***

<u>*Өнөөгийн байдал:*</u> Эрдэнэ сум нь 9600 кв.км нутагтай. Сайншандаас 100 км, Улаанбаатар хотоос 600 км-т төмөр замын дагуу оршдог. Тус сум Бүрдэнэ, Еншөөв, Цагаан хөтөл, Дөрвөлж, Улаан-Уул гэсэн нийт 5 багтай. Хүн ам 2320. Төвийн эрчим хүчинд холбогдсон. Үүрэн телефон үйлчилгээ нэвтэрсэн. Тус суманд 240 суудалтай ЕБ-ын сургууль, 50 ортой дотуур байр, 10 ортой хүн эмнэлэг, 75 ортой хүүхдийн цэцэрлэг,

160 суудалтай соёлын төв ажилладаг.2016 онд цаг уурын станцыг эрдэнэ сумандаа байгуулсан.
*Тулгамдсан асуудал:*
***Замын-Үүд сум***

*Өнөөгийн байдал:* Замын-Үүд сум нь нийт 16000 гаруй оршин суугчтай, өдөрт дунджаар 5500-6500 зорчигч, 1500-2000 тээврийн хэрэгсэл улсын хил нэвтэрдэг бөгөөд олон улсын шинжтэй байнгын ажиллагаатай “Замын-Үүд” авто зам болон төмөр зам, хоёр талын түр ажиллагаатай “Ханги” хилийн боомтууд үйл ажиллагаа явуулж байна.Тус суманд байрлах Замын-Үүд өртөө нь Монгол улс, БНХАУ-г холбосон төмөр замын цорын ганц боомт бөгөөд БНХАУ талын Эрээн хоттой холбогдоно. Тус боомтоор 2004 онд 950,000 хүн хил нэвтэрсэн тооцоо бий. Чойр хотоос Сайншандаар дайран Замын-Үүд орох 432 км урттай засмал замтай.

"Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс" 2004 онд бий болжээ. Уг бүс нь Замын-Үүд болон Хятадын хилийн хооронд 900 га газрыг эзлэн оршино

**“Замын-Үүд” авто замын боомт**.Монгол орны үүд хэмээн хүндлэгддэг Замын-Үүдийн нутгаар худалдаа арилжааны Торгоны, Гүнжийн, Цайны зам дайран өнгөрдөг байсан түүхтэй.
Энэхүү худалдаа арилжааны түүхэн зам эдүгээ ч бүдгэрсэнгүй. ‘’Монгол-Хятадын хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр’’-ийн дагуу 1992 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Замын-Үүд авто замын боомт нь нээгдэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.
**Замын-Үүд” төмөр замын боомт**:Монгол Улс 1956 оны 01 дүгээр 03-ны өдөр БНХАУ-тай ган замаар холбогдож, гадаад харилцаанд нэгэн шат ахисан түүхтэй.
Энэхүү түүхэн үйл явдалтай зэрэгцэн БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай 1956 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн хэлэлцээрээр Замын-Үүд төмөр замын боомт байгуулагдаж, Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн хэлэлцээрээр Олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай байхаар тогтоожээ.
**Ханги боомт**.Ханги боомт нь 2012 оны 12 дугаар сарын 11-ний өдөр байгуулагдаж, ‘’Монгол-Хятадын хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр’’-ийн дагуу жил бүрийн 03, 05, 08, 11 дүгээр сарын 16-30-ны хооронд улирлын чанартайгаар зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулж байна.
**Газар нутаг:** Замын-Үүд нь Монгол Улсын зүүн урд хязгаарт байрлалтай. Дэлхийн бөмбөрцгийн уртрагийн 112˚, өргөрөгийн 44˚-ын солиболцолд оршдог. Монгол орны физик газарзүйн мужлалаар: Говийн их мужийн Дорноговийн талархаг мужийн цөлөрхөг дэд хэсэгт багтана. Харин геотектоникийн мужлалаар: Өмнөд говийн геосинкпиналь атриат тогтолцооны Замын-Үүдийн хотгорт багтдаг. Ургамал газар зүйн мужлалаар: Евро – Азийн хээрийн мужийн Умард говийн цөлийн хээрийн тойргийн Борхойн талын районд хамаарагдана. /А А. Юнатов 1950 он/ /МУ-ын БОЯ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, ШУА-ийн геоэколгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний судалгааны дүгнэлт УБ 1998 он 20-р талд/ Үнэмлэхүй өндөр нь 930 – 1100 метр. Дэлхийн дундажаар жилд 860 мм, Монгол улсын дунджаар 250 мм тунадас унадаг бол Замын-Үүдэд 111 мм тунадас ордог.Монгол Улын Их Хурлын 1994 оны 5 дугаар сарын 6-ны 34 дүгээр тогтоолоор Замын-Үүд сумын хилийн цэсийг тогтоосон бөгөөд Эрдэнэ сумын нутгаас Улаан-Овоо, Хөтөл-Ус, төмөр замын 1085-

р км, Хамуутын худаг, Улаан-Овооны бууцаар хязгаарласан 44 км нутгаар, БНХАУ-ын хилээс хилийн 354 дүгээр баганаас 361 дүгээр тэмдэгт /багана/-ээр 45.3 км нутгаар зааглаж, хиллэсэн нутгийн нийт талбай нь 49.5 га-аас сумын төв суурин газар 1560 га /0.3%/, төмөр зам 64 га /0.1%/, нуур тойром 58 га /3.5%/, авто зам 72 га /2.5%/, бэлчээрийн эдэлбэр газар 48400 га /98.5% / тус тус эзлэнэ. Үүнээс зам тусгай хэрэгцээний буюу хилийн зурвас,шугам сүлжээний газар сумын нийт талбайн 67.2 хувийг эзэлдэг. Нийт 48.6 мянган га нутаг дэвсгэртэй. Монгол улсын хэмжээгээр дунджаар нэг сум 3000 хүн амтай, 100.000 толгой малтай, 450 мянган га нутаг дэвсгэртэй. Сумын нутаг дэвсгэр нь манай улсын нийт сумуудын нутаг дэвсгэрийн дундажаас 12 дахин бага, хүн ам нь бараг 2 дахин их газрын ачаалал ихтэй. Цөлжилтөд нэн хүчтэй нэрвэгдсэн газрын нэг. Харин нийгэм эдийн засгийн болон гадаад харилцааны хувьд олон улсын хэмжээнд нэн ирээдүйтэй бүс нутагт тооцогддог онцлогтой.

**Засаг захиргааны нэгжийн хувьд:** Замын үүд сум нь ардын хувьсгалаас өмнө засаг захиргааны нэгжийн хувьд Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуунд харъалагдаж байжээ. Дорноговь аймгийн Замын -Үүд сум нь 1956 онд БНМАУ –ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 131 дүгээр зарлигаар Замын-Үүд хороо, 1994 онд УИХ-ын 34 дүгээр тогтоолоор сум болон шинэчлэн зохион байгуулагдсан, Улаанбаатар хотоос 780 км, аймгийн төв Сайншандаас 230 км, МУ-ын хилээс 4.5 км-т оршдог, МУ-ын хилийн томоохон боомт билээ. Одоогийн байдлаар тус сум нь засаг захиргааны нэгжийн 3 багтай.

Замын-Үүд нь 13768 суурин хүн ам, 4083 өрхтэй, хүн ам 2009 оныхоос 111.2 %-иар , өрх 113.6 %-иар өссөн. Замын-Үүдэд оршин суугчдын нөхцөл байдал нь түр оршин суугч, албан томилолтоор шилжин ажиллагсад, улирлын байдлаар ажил эрхлээд буцдаг хүн ам ихтэй. Хүн амын өсөлтийн хэтийн төлөв тухайн аймаг сумын хөгжил нь оршин суугаа хүн амаас шууд хамааралтай байдаг. Иймд Замын-Үүд сумын нийт хүн амын хэтийн төлөвийг ердийн болон нийгмийн өөрчлөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, төрөлт нас баралт, ажиллах хүчний тоо, нэн шаардлагатай байгаа ажлын байрны тоо зэрэгтэй уялдуулан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хэрэгжих 21 жилийн буюу 2009-2030 он хүртэлх хугацаанд тооцож гаргав. 2030 оны түвшинд Замын-Үүдийн хүн ам 23000 орчим хүн амтай болж өсөх ба 5800 орчим өрхтэй болох тооцоог гаргасан.

*Тулгамдсан асуудал:*

Замын-Үүд сумын хүн амын тоо хурдацтай өсөж байгаатай холбоотойгоор нийгэм болон төрийн үйлчилгээг ард иргэдэд бүрэн хүргэж чадахгүй байна. Сумын нутаг дэвсгэрт түр оршин суугч, дайран өнгөрөх иргэд, хилийн боомтыг түшиглэсэн хүн амын хөдөлгөөн ихтэй эдгээр нь хүн амын зохистой бодлого явуулах төлөвлөлтийг үнэн бодитой найдвартай төлөвлөхөд хүндрэл үүсгээд байна. Гэсэн хэдий ч одоог хүртэл сумын статустай байгаа тул санхүү төсвийн хүртээмж муу байна. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх шаардлагтай.

***Хөвсгөл сум.***

*Өнөөгийн байдал:* Хилийн сум. БНХАУ-тай хиллэдэг. Аймгаас 170, хотоос 650 км. 1574 хүн ам, 420 өрх, 327 малчин өрхтэй. 121 мянган толгой малтай. Анхны сумын нэг. 12 жилийн сургууль, сум дундын эмнэлэгтэй. Сумын нутаг дэвсгэрт хайгуулын 23, ашиглалтын 1 лицензтэй. Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Аргаль, цагаан зээр, хулан бий. Бэлчээрийг хулан цагаан зээр талхалдаг. Малын өвчлөл ихтэй. 9-н жилийн сургуультай, 250 хүүхдийн суудалтай сургуульд 232 хүүхэд суралцаж байна. Нутгийн бренд бүтээгдэхүүн ингэний хоормог, цагаан эсгий хийдэг.9 ноён хутагттай. Сумаас 30км-т Эргэлийн зоо байдаг. Үлэг гүрвэлийн өндөг, чулуужсан мод олддог. Говийн 5-р ноён хутагт Д. Данзанравжаагийн төрсөн газар бөгөөд Шувуун шанд гэдэг газар төрсөн.

*Тулгамдсан асуудал:*

*Санал:*

***Хатанбулаг сум.***

*Өнөөгийн байдал:* 2947 хүн ам 965 өрхтэй. 9-н жилийн 540 хүүхдийн хүчин чадалтай сургуульд 360 сурагч сурдаг. Багшлах боловсон хүчин дутагдалтай. 60 хүүхдийн дотуур байр, 100 хүүхдийн цэцэрлэг,10 ортой эрүүл мэндийн төвтэй. 278.3 мянган толгой малтай. Дэд бүтэц зам харилцаа сул хөгжсөн. 2017 онд төвийн эрчим хүчний системд холбогдсон. Цахилгаан стандартын шаардлага хангагдаагүй хэлбэлзэл ихтэй. Төвлөрсөн уурын зуухгүй. Дэд бүтцийн шугам сүлжээний зураг төсөл хийгдсэн. Таван толгойн уурхайгаас нүүрсээ татдаг. Шилэн кабелд холбогдоогүй. Исатком компаниас сарын 890 мянган төгрөгний төлбөртэй бага хурдтай интернет үйлчилгээ авдаг. Жи-мобайл, Юнителийн үүрэн телефоны сүлжээ орсон. Төсвийн 5 байгууллагатай. 25 аж ахуй нэгжтэй, 30 дэлгүүртэй, Амжиргааны түвшин сайн. Мал, мах, ноос ноолуур өндөр үнэтэй. Мон Лаа төмрийн хүдрийн уурхай ажилладаг. Сумын нутаг дэвсгэрт ашиглалтын 3 лицензтэй. Ханги мандалын хилийн боомттой. Боомтоор өдөрт 100 орчим хүн орж гардаг. Хилээр нэвтэрч байгаа хүнээс 1000 төгрөгний хураамж авдаг. Айл баян, Их Говийн энержи гэсэн 2 нүүрсний уурхайтай. Хилийн цэргийн дугаар анги, зэвсэгт хүчний агаарын довтолгооныг эсэргүүцэх анги байрладаг. Хилийн 8 заставтай. 6 нь тус сумын нутаг дэвсгэрт байрладаг. 6 багтай, төвийн 2 баг хөдөөгийн 4 баг. Жижиг дунд үйлдвэр хөгжөөгүй. Эдийн засгийн гол хөгжүүлэх чиглэл нь мал аж ахуй. Аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр баталсан. Говийн бага дархан цаазат газартай. Аргалийн нөөц ихтэй. Ан агнуураас төсвийн орлогын нилээд хувийг бүрдүүлдэг. Ан агнуурын 2 компани байрладаг. Анчин отог аялал жуулчлалын бааз 25 км-т байрладаг. Анчин отог жуулчны бааз нь 12 гэртэй, гэрийн диаметр нь 36 метр Гиннесийн номонд бичигдсэн.

*Тулгамдсан асуудал: Суманд цахилгаан эрчим хүчний хэлбэлзэл ихтэй. Шилэн кабельд холбогдоогүй.*

## 5.3 ӨМНӨГОВЬ АЙМАГ.

**Засаг захиргааны нэгж:** Өмнөговь аймаг нь 165,0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 15 сум, 58 багтай. Аймгийн төв Даланзадгад хот.

**Хүн ам:** Өмнөговь аймаг нь 2017 оны жилийн эцэст 65645 хүн амтай болж 2016 оны жилийн эцсийн хүн амын мэдээнээс 3,0 хувиар буюу 1984 хүнээр өслөө. Нийт хүн амын 50,3 хувь эрэгтэйчүүд, 49,7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын 39 хувь Даланзадгад хотод, 21,4 хувь нь Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын төвд суурьшиж байна. Хөдөлмөр эрхлэх насаар нь ангилвал 32,1 хувийг 0-15 насны хүүхэд, 62 хувийг 16-59 насны, 5,9 хувийг 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Өрхийн тоо 21278 болж өмнөх оноос 609 өрхөөр буюу 2.86 хувиар өссөн дүнтэй байна.

**Газар нутаг:** Өмнөговь аймаг нь Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баянхонгор, баруун хойд хэсгээр Өвөрхангай, хойд талаараа Дундговь, зүүн талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино.

Аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай. Монгол улсын хэмжээнд хамгийн том 165,0 мянган кв.км нутаг дэвсгэртэй ба хүн амын суурьшил сийрэг 3,4 квадрат километр нутагт 1 хүн, 13,2 квадрат километр нутагт 1 өрх ноогдон хүн ам суурьшиж байна.

**Хөдөө аж ахуй**: 2017 оны эцэст 5819 малчин өрх байгаа нь өнгөрсөн оноос 172 өрхөөр өссөн байна. Аймгийн хэмжээнд 501 мянгат малчинтай болсон байна. Хамгийн олон малтай сумаар Номгон 289869, Ханхонгор 242353, Гурвантэс сум 205078, Булган 194503, Баяндалай 190396 толгой мал тус тус тоолуулсан байна. Малын таван төрлөөр нь авч үзвэл тэмээгээр Ханбогд сум 27932, адуугаар Манлай сум 11895, үхрээр Ханбогд сум 5313, хониор Ханхонгор сум 67161, ямаагаар Номгон сум 227212 толгойгоор тус тус тэргүүлж байна. Ханбогд сум нь тэмээн сүргээрээ аймагтаа болон улсад тэргүүлж байна. 2017 онд нийт мал 2654388 толгой болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 340.4 мянган толгойгоор таван төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс тэмээ 10739, адуу 13353, үхэр 4848, хонь 93075, ямаа 218410 толгойгоор тус тус өсчээ.

**Газар тариалангийн салбарт** 190,3 га талбайд тариалалт хийсний 82 га талбайд төмс, 82,8 га талбайд хүнсний ногоо, 25,5 га талбайд тэжээлийн ургамал тариалснаас 585,3 тонн төмс, 724,0 тонн хүнсний ногоо, 215,1 тонн тэжээлийн ургамал хураажээ.

**Боловсрол**. Аймгийн хэмжээгээр 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын төрийн хэвшлийн 21 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 431 бүлэгт өдрийн ангийн 11844 сурагчид хамрагдан суралцаж байна. Нийт суралцагчдын хүйсийн харьцаа эмэгтэй 50.5, эрэгтэй 49.5 байна.Өдрийн ангийн суралцагчидтай төрийн хэвшлийн сургуулиас хамгийн олон суралцагчидтай сургууль Даланзадгад сумын 1-р бүрэн дунд сургууль 1745, хамгийн цөөн суралцагчидтай сургууль Хүрмэн сумын ЕБС 126 суралцагчидтай байна. Энэ хичээлийн жилд аймгийн хэмжээнд 20 дотуур байранд868 хүүхэд амьдарч байгаагийн 56.2 хувийг эмэгтэй сурагчид эзэлж байна.Төрийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуульд 1004 ажиллагчид ажиллаж байгаагийн 62.2 хувь нь буюу 605 багш ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсрол олгох 28 төрийн өмчийн цэцэрлэгийн нийт 163 бүлэгт 5517 хүүхэд хүмүүжиж байна. Үүний 0.8 хувь буюу 46 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Энэ хичээлийн жилд СӨБ-д 607 ажиллагчид ажиллаж байгаагийн 26.2 хувь нь буюу 159 үндсэн багш ажиллаж байгаагаас 96.0 хувийг эмэгтэй багш нар эзэлж байна. 2017-2018 оны хичээлийн жилд Политехникийн коллеж-д

630 суралцагсад суралцаж байгаагийн 34.0 хувь нь эмэгтэй суралцагчид байна. Нийт суралцагчдын 36.2 хувь буюу 228 хүүхэд төгсөх ангийн суралцагчид байна. Энэ хичээлийн жилд 69 багш, ажилчид ажиллаж байгаагийн 43 буюу 62.3 хувийг багш эзэлж байна.

**Эрүүл мэнд**. Аймгийн хэмжээгээр эрүүл мэндийн байгууллага 87 ажиллаж байгаагаас улсын төсвийн эмнэлэг 21, өрхийн эмнэлэг 4, цэргийн ангийн 3 эмнэлэг, хувийн эмнэлэг 24, эмийн сан 38 тус тус ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарт 189 их эмч, 362 дунд мэргэжилтэн ажиллаж байна.2017 оны эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээгээр 1297 эх амаржиж, 308 хүн нас барсан нь урьд оны мөн үеэс төрөлт 7.4 хувиар, нас баралт 3.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд оны эхний 12 сарын байдлаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл 21 гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 22.0 хувиар, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5 гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 29.0 хувиар тус тус буурсан байна. Аймгийн хэмжээнд нийт халдварт өвчин 714 гарсаны 65.7 хувийг хурц халдварт өвчин эзэлж байгаа бөгөөд сумдаар авч үзвэл Даланзадгад, Ханхонгор, Цогтцэций сумдад өндөр үзүүлэлттэй байна.

**Уул уурхай:** Өмнөговь аймаг ашигт малтмалын 80 гаруй орд, 200 гаруй илрэлтэйгээс Тавантолгой, Оюу толгой, Нарийнсухайт стратегийн ач холбогдолтой 3 томоохон орд газарт тогтоогдож нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэс таван толгой, Энержи ресурс, Мөнх ноён суварга, Дун юань, Олон овоот гоулд, Зөв зүг, МАК, Чинхуа-Мак-Нарийн сухайт, Саус гоби сэндс, Өсөх зоос, Терра энержи, Жавхлант орд зэрэг 14 компаниуд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

**Уур амьсгал:** Байгаль цаг уурын хувьд эрс тэс эх газрын уур амьсгалтай, өвөлдөө -20-30 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 30-38 градус, салхины хурд 5-15 м/сек, заримдаа 34-45 м/сек хүрдэг,

**Аялал жуулчлал:** Аймгийн төвөөс баруун зүгт 220 км Сэврэй сумын нутагт 800 м өндөр, 150 км үргэлжилсэн Хонгорын голын үзэсгэлэнт элсэн уул,

- Монгол улсын алдарт 33 говийн нэг хэсэг болох хэдэн арван км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг сүүжийн алдарт их говиуд,
- 50-120 сая жилийн тэртээ амьдарч байсан эртний үлэг гүрвэлийн чулуужсан яс, өндөг, чулуужсан мод зэрэг палентологийн олдворууд олдсон Булган сумын нутагт байдаг Баян заг
- Дэлхийд ховорт тооцогдох Нэмэгт, Хэрмэн цав, Шаригийн ганга, Бүгийн цав, зэрэг байгалийн тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд, онгон зэрлэг байгаль,
- Хутагт Данзанравжаагийн байгуулсан энергийн төв болох Дэмчогийн хийд
- Аймгийн хамгийн баруун сум болох Гурвантэс сумын нутагт байдаг Хэрмэн цав
- Аймгийн хамгийн зүүн сум болох Манлай сумын нутагт байдаг үлэг гүрвэлийн чулуужсан мөр
- Дэлхийд ховордсон ан амьтан, ховор төрлийн ургамлаараа гадаадын жуулчин, аялагчдын сонирхлыг ихээхэн татаж байна.

***Мандал-овоо сум***

*Өнөөгийн байдал:* Өмнөговь аймгийн Мандал-овоо сум нь 1923 онд Богд хаан уулын аймгийн Дэлгэрхангай уулын хошууны Хана сум нэртэйгээр анх байгуулагджээ. Тус сум нь Дундговь аймгийн Дэлгэрхангай, Сайхан-овоо, Өвөрхангай аймгийн Төгрөг, Баянгол, Богд

сумдтай хил залган оршдог ба 6424 кв.м нутагтай. Тус сум нь Засаг захиргааны анхан шатны нэгж болсон 3 багтай. Тус сум 531 өрх, 1602 хүн амтай, үүнээс эрэгтэй 844, эмэгтэй 758 байна. Сумын Эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд 2017 оны жилийн эцэст 317 малчин өрхийн 185166 толгой мал тоолуулсан байна. Ханын хэцийн хүрэн тэмээ, нутгийн үүлдрийн улаан ямааг өсгөн үржүүлдэгээрээ аймагтаа алдартай. 9 жилийн сургуультай. 160 /320/ сурагчидтай. 120 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг, 80 хүүхэд хүмүүжиж байна.. 8 ортой эмнэлэгтэй. Сумын төв дээр 200 орчим өрхтэй 300 орчим нь малчин өрх.Ингэний сүүний үйлдвэртэй. Эрчим хүчээ Арвайхээр хотоос авдаг. Төвлөрсөн халаалтын системтэй. 2018 онд 10 ортой эмнэлэг баригдаж байна.

*Тулгамдсан асуудал:*

Гэр бүлийн нэг гишүүн нь ахлах ангийн хүүхдээ дагаж аймгийн төв рүү шилждэг. Малчдын бэлчээр, ус булаацалдах нь тулгамдаж буй асуудал болж байна.

*Санал:*

Аялал жуулчлалыг бодлогоор хөгжүүлэх шаардлагатай байна.

***Булган сум***

*Өнөөгийн байдал:* Булган сум нь 1952 онд байгуулагдсан. 249.8 мян.га нутаг дэвсгэртэй. Алтайн уулархаг нурууны төгсгөл болох оршдог бөгөөд газар нутгийн ихэнх хэсгийг говь, тал хээрийн бүс эзэлдэг. Нутаг дэвсгэрийн 19.7 хувь нь Говь-гурван сайханы байгалийн цогцолборт газрын улсын тусгай хамгаалалттай бүс нутагт хамрагддаг. Булган сум нь өөрийн аймгийн Мандал-Овоо, Ханхонгор, Баяндалай, Сэврэй, Өвөрхангай аймгийн Богд сумдтай хиллэдэг. Аймгийн төвөөс 98 км, Улаанбаатар хотоос 530 км-т оршдог. Байгалийн үзэсгэлэнт Баянзаг, Төгрөгийн ширээ, Хадатын рашаан, зэрэг газар нутагтай. 70 гаруй сая жилийн өмнө амьдарч байсан махан ба өвсөн тэжээлт үлэг гүрвэлүүдийн орд бүхий Баян заг, Төгрөг, Алаг цав, Авдрант зэрэг газар, Булгатай Хавцгайтын хадны сүг зураг, чулуун зэвсгийн үеийн орд газруудтай. Засаг захиргааны 4 нэгжтэй. 727 өрхийн 2122 хүн амтай. Сумын Эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй бөгөөд нутгийн монгол ямааг оросын Дон хавын ямаагаар эрлийзжүүлсэн ноолуурын чиглэлийн “Говь гурван сайхан” үүлдрийн ямааны өлгий нутаг. Булган Наран Хадат Дал Их булаг зэрэг услалтын систем бүхий 35 га газарт төмс хүнсний ногоо тариалан орон нутгийн иргэдийн хүнсний ногооны хэрэгцээг хангадаг төдийгүй улаан лооль, өргөст хэмх тариалдаг.

*Тулгамдсан асуудал:*

Цэвэрлэх байгууламж ашиглалтанд орсон боловч улсын комисс хүлээж аваагүй байна. ИШС-ний хувьд бүх нийтээр нь хамруулах зорилготой. Хүн амын нягтрал байхгүй, төв суурин бараадсан шилжилт хөдөлгөөн их байна.

***Сэврэй сум***

*Өнөөгийн байдал:* Сэврэй сум нь 621 өрхийн 2009 хүн амтай. Үүний 674 нь сумын төвд, 1335 нь хөдөөд оршин сууж байна. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой тасралтгүй өссөн ба 2017 оны жилийн эцсээр 177238 толгой мал тоолуулсан. Шинэ сургууль болон халаалтын шугамын өргөтгөлийн зураг хийлгэж байна. Сумын төв дээр 10-20 инженерийн шугам, сүлжээнд холбогдсон. Сумын онцлог нь уул уурхай огт байхгүй 100 хувь лицензгүй сум. Газар нутгын 83 хувь нь улсын тусгай хамгаалалтанд байдаг.

*Тулгамдсан асуудал:*

Эрүүл мэнд, боловсролын асуудал ахлах ангийн хүүхдээ дагасан гадагш шилжилт хөдөлгөөн ихтэй.

*Санал:*

Аймгийн төвд коллеж, их сургуультай болох

***Гурвантэс сум***

*Өнөөгийн байдал:* Гурвантэс сум нь 1954 онд анх Тост нэртэйгээр одоогийн Сэврэй сумын 1 дүгээр баг, Ноён сумын 3, 4, 5 дугаар багууд нийлж Улаан толгой гэдэг газар 281 өрх, 943 хүн амтай, 63,2 мянган малтай байгуулагджээ. 1959 онд орон даяар нэгдэлжих хөдөлгөөн ялсаны үрээр, 1960 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Гурвантэс сум гэж нэрлэгдэн, одоогийн байрлаж байгаа Уртын дэнжид төвлөрсөн байна. Тус сум нь 2,9 сая га газар нутагтай хойт, баруун, баруун урд талаараа Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баянговь, Баянлиг, зүүн, зүүн хойт талаараа өөрийн аймгийн Сэврэй, Ноён, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эзний хошуутай хиллэж, Говь-Алтайн нурууны цаад цөлөрхөг бүсэд оршдог. Улаанбаатараас 870 км, аймгийнхаа төвөөс 320 км алслагдсан байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, цаашид аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой газар нутагтай. Гурвантэс сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болох 4 багтай, Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй болон уул уурхай, нүүрс тээвэрлэлт. 4869 хүн ам, 1527 өрхтэй. 615 малчин өрх 205078 тоо толгой мал тоолуулсан. БНХАУ-ын ӨМӨЗОрны хөрш аймгаас өндөр хүчдэлд холбогдсон.

*Тулгамдсан асуудал:*

Аймгийн төвөөсөө алслагдсан, зам тээвэр муу, уул уурхайн тээврийн машинууд их явдаг учраас хүндрэлтэй. Эрчим хүчээ БНХАУ-аас авдаг дотоодоос авах боломж байдаггүй. Хилийн боомтоор асуудал ихтэй. 18 км-т газар өгдөггүй, тэнд бүх төрлийн л асуудал бий болсон хяналт шалгалт тавиад ч нэмэр байдаггүй.

*Санал:*

Аймгийн төвөөс сум хүртэл засмал замтай болох саналтай байна. Нүүрс тээврийн зам бол байнга бензин, тэсэлгээ, нүүрсний машинууд тасралтгүй явж байдаг.

***Баяндалай сум***

*Өнөөгийн байдал:* Тус сум нь урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Ноён, Сэврэй, сумдуудтай хил залган оршдог. Аймгийн төвөөсөө баруун зүгт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 670 киломитер, аймгийн төвөөсөө 86 километр зайд оршдог. Тус сум нь 2082 хүн амтай, төрийн анхан шатны нэгж 3 багтай, 12 жилийн сургууль, Хүн эмнэлэг, Цэцэрлэг, Соёлын төв, ХААН банк, Төрийн банк, Холбоо, ГМУҮГазар, зэрэг албан байгууллагууд, 20 иод аж ахуй нэгж, компиантай,190396 толгой малтай, 684 өрхтэй, эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон зам тээврийн зангилаа томоохон сумын нэг болон хөгжиж байна. ИШС-д төрийн үйлчилгээний байгууллагууд холбогдсон.

12 жилийн сургуультай, 320 хүүхдийн багтаамжтай сургуульд 270 орчим хүүхэд суралцаж байна. Багш ажилчид нийлээд сургуульд 40 орчим хүн ажиллаж байна. Сургуулийн дотуур байртай бөгөөд 120 хүүхдийн хүчин чадалтай дотуур байранд 30-40 хүүхэд л амьдарч байна. Энэ жил аймгийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн төвдөө бүрэн хэмжээний их засвар хийсэн. 2008 онд тус сум цэвэр бохирын системд холбогдсон.

*Тулгамдсан асуудал:*

Гэр хорооллын айлуудын байшинтай айл өрх цөөхөн байгаа бөгөөд байшинтай болвол ИШС-д холбогдох боломжтой болно. Сумын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт муу байна.

*Санал:*

Үйлдвэрлэл хөгжүүлэх

***Ханбогд сум***.

*Өнөөгийн байдал:* 15,150 км$^2$ нутаг дэвсгэртэй. 5 багтай. Сумын төвөөс баруун тийш 40 км зайд Оюутолгойн зэсийн орд байдаг бөгөөд "Оюутолгой" төсөл хэрэгжиж эхэлснээр сумын нутагт зэсийн уурхай ашиглалтад орсон. Улаанбаатар хотоос 650 км, Өмнөговь аймгийн төвөөс 250км зайтай. Тус сумын нутагт Галбын говь байдаг монгол улсдаа тэмээнийхээ тоогоор 1-рт ордог. Галбын улаан угшлын тэмээг өсгөдөг. Илүү нугаламт хонины үүлдэр

нутагшуулж байна. Галбын 3 хийд, Баяжихийн агуй бий. Ханбогд сумаас Оюу толгойн уурхайд 1127 хүн ажилладаг. 1020 суралцагчтай. 250 суудалтай соёлын төвтэй. Ус хангамжийн байгууламж ашиглалтанд орсон. Малын эрүүл мэндийн сум дундын төвтэй. 640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн цогцолбор баригдаж байна. Үлэмжийн чанар Соёлын өргөө ашиглалтанд орсон. Нийт 32 блок орон сууц хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Сумын хүн ам он гараад 8000-д хүрэх төлөвтэй байна. Нийт хөдөлгөөнт хүн ам 30000 орчим. Төрийн үйлчилгээний хүртээмж муу. 6000 гаруй нэгж талбар өмчлөлтэй. Хүн ам нь 2000 хүрсэн 3 баг бий. Оёдлын 2 үйлдвэртэй. Оюу толгойн уурхайд ханган нийлүүлэлт хийдэг. Говийн ургамлыг тарималжуулах суулгац үржүүлдэг мод үржүүлгийн газартай. Нутгийн бренд бүтээгдэхүүн ааруул, сүү, хоормог.

*Тулгамдсан асуудал:* Тоосжилт ихтэй.

***Цогтцэций сум.***

*<u>Өнөөгийн байдал:</u>* Сумын нийт хүн ам 7600. 2400 өрх, 300 орчим малчин өрхтэй. Бүртгэлгүй 20000 орчим хүн амтай. Хотжилт эрчимтэй явагдаж байна. Дэд бүтэц хөгжсөн. Ерөнхий төлөвлөгөөгөөр 25000 орчим хүн амтай хот болно гэж төлөвлөсөн. Ерөнхий боловсролын сургууль 1870 гаруй суралцагчтай, 3 цэцэрлэгтэй, 1265 цэцэрлэгийн насны хүүхэд байна. Сум дундын эмнэлэг гэсэн статустай эмнэлэгтэй. Нүүрсний тээвэрт явж байгаа 11000 орчим жолооч нарт эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. Шинээр нян судлал, рентгений кабинетын асуудлыг шийдвэрлэсэн. Сум орон нутгаас 300 сая төгрөгний хөрөнгө оруулалтыг эмнэлэгт хийсэн.

Тулгамдсан асуудал: Амьсгалын замын өвчлөл ихтэй. Тоосжилт тоосонцор хүлцэх хэмжээнээс 10-15 дахин их.

Санал: Агаарын бохирдлоос 20 гаруй тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлдэг бөгөөд орон нутгийн төсөвт мөнгө ордоггүй энэ асуудлыг шийдвэрлэх

## 5.4. ДУНДГОВЬ АЙМАГ

Дундговь аймаг нь 1941 онд Өмнөговь аймгаас 8 сум, Дорноговь аймгаас 3 сум, Төв аймгаас 7 сум тус тус шилжүүлэн 18 сумтайгаар одоогийн Өлзийт сумын нутаг Ембүү дэрсэнэ ус гэдэг газар Шарангад аймаг нэртэйгээр байгуулагджээ. 1942 онд аймгийн нэрийг Дундговь хэмээн өөрчилж аймгийн төв одоогийн оршин байгаа Зоогийн Хар овооны энгэрт суурьшсан байна.

Дундговь аймаг нь 2017 оны эцсийн байдлаар 14556 өрхийн 46.4 мянган хүн амтай байгаа бөгөөд иргэдийн 34.1 хувь нь 17 хүртэлх насны хүүхдүүд, 35.6 хувь нь 18-39 насны залуучууд, 22.2 хувь нь 40-60 насныхан, 8.1 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байна.

**Засаг захиргаа, нутаг дэвсгэр:** Дундговь аймаг нь Засаг захиргааны хувьд 15 сум, 66 багтай, 7469,0 мянган га нутаг дэвсгэртэй, газар нутгийн хэмжээгээр Монгол улсын нутаг дэвсгэрийн 4,5%-ийг эзэлдэг, аймгийн төв Улаанбаатар хотоос 265 км-т байрладаг, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймгуудтай хиллэдэг.

**Газрын гадарга, хөрсний бүтэц:** Аймгийн нутаг дэвсгэрийн хилийн тойрог 1230 км, нутгийн баруун цэг Гучингийн худгаас зүүн цэг Хөх дэл хүртэл 425 км, хойд цэг Ус хар толгойгоос урд цэг Өвөр цагаан дэрс хүртэл 283 км. Нийт газар нутаг нь тал хээр говийн бүсэд багтдаг. Тэгш тал газрын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 1530 м, хамгийн нам нь 980 м, хамгийн өндөр Дэлгэрхангайн уул далайн түвшнээс дээш 1913 м өндөр өргөгдсөн байдаг. Тус аймгийн нутагт уулын хөрс /хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн/ маш бага хувийг эзэлж Адаацагийн хойд тал, Бага газрын чулуу, Угтаалын уул, Их газрын чулуу орчимд тархсан. Нутгийн төв, хойд хэсгээр ухаа толгод нам уулсын /хүрэн, цайвар

хүрэн, цөлөрхөг хээрийн бор, хээржүү цөлийн бор/ хөрс, нутгийн төв, өмнөд хэсгээр тал хөндийн /цөлөрхөг хээрийн 20 төрлийн хөрс/ хөрс тархсан.

**Уур амьсгал:** Аймгийн нутаг дэвсгэрийг уур амьсгалын хувьд хуурай, сэрүүн, уулын хээрийн муж /Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг/, нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг/, нэн хуурай дулаан, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг/ гэж 3 хуваадаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард – 16-19 градус, зуны сард +17-21 градус, жилд орох хур тундасны хэмжээ 95-150 мм унадаг.

**Онцлог давуу тал** - Дуу хуур, гүүний айраг, хонины махны чанараараа улсдаа алдартай. Улсын дунджаар малтай нэг өрхөд ногдох малын тоогоор эхний байруудад ордог. Байгалийн эрдэс түүхий эдийн багагүй нөөцтэйн дотор улсын хэмжээний судлагдсан хүрэн нүүрсний нөөцийн 58,0 хувь, гөлтгөнийн 32,3 хувь, эрдэс будгийн 53,4 хувь нь тус аймагт байна. Аймгийн төв болон бүх сумын төв эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон, үүрэн телефоны сүлжээтэй Нийслэлд ойр учир бага зардлаар говь тал хээр, түүний үзэсгэлэнт байгалийг үзэх боломжтой. Энэ утгаараа аялагчдын тоо жил бүр өсч байна. Жилд нартай өдрийн тоо харьцангуй олон, салхины хурд их учир нар, салхины эрчим хүчийг ашиглах өргөн боломжтой. Сайхан-Овоо сумын нутагт Өгөдэй хааны өвөлжөө, Буган чулуун хөшөө, Замбага хайрхан уулын хүннүгийн үеийн булш, дундад зууны үед холбогдох шаазан хотын туурь, Гурвансайхан сумын нутаг Ярх уулын хуучин чулуун зэвсгийн бууц суурин, дарханы газар хүрэл зэвсэг үйлдвэрлэлийн дурсгал, Дэлгэрхангай суманд Өгөдэй хааны нас эцэслэсэн газар, Адаацаг сумын Сүм хөх бүрдэд их хаадын намаржаа, Өлзийт сумын Дэл уулын хадны зураг, Дэлгэрийн Чойрын хийд, Эрдэнэдалай сумын сангийн далай хийдийн Цогчин дугана, дөрвөлжин булш, хиргисүүрийн дурсгалууд эртний төрт улсуудын үед холбогдох булш бунхан эртний бэхлэлт цайз хэрэм зэрэг олон мянган жилийн турш хүмүүсийн аж төрж ирснийг илтгэх түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсээр нэн арвин. Эртний далайн ёроолын үлдэц бүхий Цагаан суварга, Морин толгойн цав, Өөш манхан зэрэг өвөрмөц тогтоцтой байгалийн шавар цав элсэн манхан, Их газрын чулуу, Бага газрын чулуу зэрэг боржин чулуун уул, заг, хайлаасан төгөл, Олдох, Гурван төгрөг, Эргэнэг, Хаяа, Нэмнээ, Номгон, Хайрхан, Загийн ус зэрэг үзэсгэлэнт газруудтай. Аймгийнхаа ард иргэдийн ахуй амьдралын хэвшил, уламжлал, байгалийн онцлог давуу тал, нөөц бололцоотой уялдуулан улсдаа “Дуу хуурын өлгий нутаг” хэмээн алдаршсан дуу хуур, эртний түүхэнд мөртэй үзэсгэлэнт Дундговь нутгийн аялал жуулчлал, гүүний айраг, ингэний хоормог, мах, хүрэн нүүрсний үйлдвэрлэлийг аймгийн брэндээр тодорхойлон бүс нутгийн төдийгүй улсын хэмжээнд эдгээр брэнд бүтээгдэхүүний үйлчилгээг бий болгож улмаар зарим бүтээгдэхүүнийг экспортод гаргах бодлого барин ажиллаж байна.

***Говь-Угтаал сум***

*<u>Өнөөгийн байдал:</u>* Говь-Угтаал сум нь 1924 онд байгуулагдсан Засаг захиргааны 3 нэгжтэй, Аймгаас 110 км-т Улаанбаатар хотоос 270 км алслагдсан аймгийн зүүн бүсийн төвд оршдог сум юм. Нийт 541 өрхтэй, үүнээс хөдөөд 282 өрх байна. 1591 хүн амтай, үүнээс 816 эрэгтэй, 775 эмэгтэй, 166403 толгой малтай. Тус сум нь 270.0 мянган га нутаг дэвсгэртэй нийт нутаг нь тал хээрийн бүсэд оршдог. 320 хүүхдийн сургуультай, одоогийн байдлаар 170 гаруй хүүхэд суралцаж байна. Сургуульд 17-18 багш ажиллаж байна. 1997 он хүртэл 10 жилтэй байсан бөгөөд одоогийн байдлаар 9 жилийн сургуультай. Ахлах ангийн сурагчид аймгийн төв болон Чойр, Улаанбаатар хот руу шилжин сурч байна. 80 хүүхдийн багтаамжтай дотуур байранд 36 хүүхэд сууж байгаа. Үүний ихэнх нь малчин

өрхийн хүүхдүүд амьдарч байна. 10 ортой эмнэлэг болон амбулатортой. Их эмч, сувилагчийн дутагдалтай байна. 2017 онд 12 эх амаржсан. Энэ онд одоогийн байдлаар 4 эх амаржаад байна. Шүдний их эмч ажилладаг бөгөөд хаварт 7, 7 хоногоор тойргийн 7 суманд тойрч ажилладаг. Тухайн эмч нь тэтгэвэртээ гарсан эмч байгаа бөгөөд боловсон хүчний дутмаг байдлаас болоод одоо хүртэл ажиллаж байна. Энэ салбарт техник технологийн болоод инженер техникийн ажилчин дутмаг байна. Боловсон хүчний дутмаг байгаа талаар ЭМЯ-руу хандаж байгаа ч шийдэлд хүрэхгүй байна. Ээлжинд 4 сувилагч ажиллаж байгаа бөгөөд үүний 2 нь бас тэтгэвэртээ гарсан байдалтай байна.

1990-д он хүртэл төвлөрсөн халаалтын системтэй байсан. Одоо 1 уурын зуухтай түүнээс эмнэлэг, сургууль, захиргаа гэх мэт байгууллагууд халаалтаа авж хэрэглэдэг. Одоогоор үйл ажиллагаа явуулж буй уурхай байхгүй. Тус суманд хувийн хөрөнгө оруулалтаар 12 айлын 3 давхар орон сууц энэ жил ашиглалтанд орсон байна. Үүний зарагдаж буй үнэ: 1 мкв- 1сая төгрөг. Хувиараа бизнес эрхлэгчид нь талх нарийн боовны үйлдвэр, сүү цагаан идээ, гэрээр гутал засвар, дугуй засвар, блокний үйлдвэр ажиллуулж байна. Хэрэглээний бараа бүтээгдэхүүний дийлэнхи хувийг Улаанбаатар хотоос хангадаг. 2 бензин колонктой. АИ92 бензин 2017 оноос орж ирсэн. Үнэ ханшийн хувьд А92-1982, дизель түлш-2250 төгрөгийн ханштай байна. Өвс тэжээлийн улсын нөөцийн салбартай. Цаг уурын болон FM-н станцтай, 150 км-н радиуст мэдээллээ цацдаг. Үүрэн телефоны 4 оператор үйл ажиллагаатай. Сумын хөдөлмөр халамжийн бүртгэлд-60 гаруй иргэд идэвхитэй ажил хайж байгаа гэж бүртгүүлсэн байгаа.

<u>*Тулгамдсан асуудал:*</u>

Тойргоос УИХ-д гарсан гишүүд ямарч ажил хийхгүй байна. Сургууль, дотуур байрны засвар халаалтын гэх мэт ажил хийх шаардлагатай байна гэсэн хүсэл саналуудыг хүргүүлсэн боловч ямарч өөрчлөлт хэрэгжилт гарахгүй байна. Их эмч, сувилагч дутагдалтай. Нарийн мэргэжлийн эмчгүй ажиллаж байгаа учраас сумандаа эх барих зорилтгүй байгаа.

<u>*Санал:*</u>

- Боловсон хүчин дутагдалтай байгаа талаар ЭМЯ-руу хандаж байгаа ч шийдэлд хүрэхгүй байна.
- Их газрын чулуу руу морин болон хөсөг тэргэн аяллын маршрут гаргаж дотоодын болон гадаадын жуулчдыг аялуулах, малчин өрхийн хувийн бизнесийг дээшлүүлэх.

***Гурвансайхан сум***

<u>*Өнөөгийн байдал:*</u> Гурвансайхан сум 1924 онд Гучин сум нэртэй байсныг нэрийг нь өөрчилж Цагаан хошууны Гучин жасын суурин дээр анх байгуулагдсан. 1952 онд тус газраас нүүн одоогийн байгаа Чингийн Суугаантад суурьшсан байна. Гурвансайхан сум нь байршлын хувьд аймгийн төвөөс зүүн урагш 71 км, Улаанбаатар хотоос 300 км-т оршдог. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 541.647 га нутаг дэвсгэртэй, говийн бүсэд багтдаг, сумын хамгийн хойд талын цэг Баянзүрх уул, урд цэг Хэрээ шарга овоо, Зайрмагтайн худаг, зүүн захын цэг Хамар цагаан жаргалан уул, баруун захын цэг Хөөврийн худаг хүрдэг. Өөрийн аймгийн Өлзийт, Өндөршил, Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Сайнцагаан сумуудтай нутгийн хил залгадаг. Сумын нутаг дэвсгэр нь ихэнхдээ жижиг ухаа толгод зонхилох Их газрын чулуу, Гурвансайхан, Ярх, Уул халтарганатай, Чин, Суудал уул зэрэг үзэсгэлэнт газруудтай. 2003 га газрыг улсын тусгай хамгаалалтын газрын дурсгалт газрын ангилалд бүртгэн авсан. 2008 онд Гурвансайхан уул, Тэвшийн хяр, Гурвансайхан булаг, Ярх уул зэрэг 64000 га газар нутгийг ховор ан амьтан, эмийн ургамал, чулуун зэвсгийн үеийн олдвор зэргийг харгалзан аймгийн тусгай хамгаалалтанд аваад байна. Буянт уул, Билгэх, Эхийн суурин зэрэг газруудыг түүх соёлын онцлогыг харгалзан сумын хамгаалалтанд байдаг.

Манай суманд ашигт малтмалын Цагаан тээгийн гантиг, Лог үнстийн нүүрс, Гурвансайхан ураны баялаг ордуудтай цаашид хайгуул хийж нөөцийг нь тогтоохоор олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл 35 байна. 2016 оны жилийн эцсийн мал тооллогоор 222079 толгой мал тоолуулаад байна. Сумын нийт хүн ам 2149. 678 айл өрхтэйгээс 465 нь хөдөөд байна. 12 жилийн сургуультай.

Сургуульд 300 хүүхэд суралцдаг энэ жил анхны 12 жилийн төгсөлтөө төгссөн байгаа. 100 хүүхдийн цэцэрлэгтэй. 2018 онд инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж эхэлсэн бөгөөд 2019 онд хийгдэж дууcна. Энэ ажлын хүрээнд тус сумын гэр хорооллын бүх айлуудыг холбох Улаанбаатар хотын иргэдтэй адил цэвэр, бохир, дулааны болно. Гэр хорооллын айл өрх ИШС-д холбогдчихвол цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нь нэмэх зорилготой байгаа.

_Тулгамдсан асуудал:_

Эмнэлэгийн асуудлаа шийдэх гэж байгаа эмнэлэгийн тоног төхөөрөмж болон мэргэжилтэй боловсон хүчин, сувилагчийн орон тоо дутагдалтай байна. Мөн дотуур байрны асуудал байна.

_Санал:_

- Ирэх жил 2019 онд 100 хүүхдийн дотуур байр бариулах саналтай байна.
- Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрийн дагуу сумдад 1, 1 үйлдвэр барих зорилготой байгаа одоохондоо хэрэгжээгүй байгаа.
- Сумын Засаг даргын тамгын газрын байр болон соёлын төвийн барилгын сайжруулах шаардлагатай байгаа.

***Эрдэнэдалай сум***

_Өнөөгийн байдал:_ Эрдэнэдалай сум нь 1923 онд байгуулагдсан, төвийн нэр нь Сангийндалай. Улаанбаатар хотоос 275 км, Мандалговь хотоос 114 км зайд оршдог. Өвөрхангай аймгийн Сант, Баян-Өндөр, Төв аймгийн Дэлгэрхаан, Бүрэн болон өөрийн аймгийн Адаацаг, Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумтай хиллэдэг. Далайн түвшингээс 1835 м өргөгдсөн Монгол улсын төв хэсэгт байрласан тал хээр говь хосолсон 735,1 мянган га газар нутаг дэвсгэртэй. Эрдэнэдалай сум нь 2017 оны жилийн эцсээр 1745 өрх, 5730 хүн амтай, 52 байгууллага үүнээс төсвийн 8, аж ахуй нэгж 16, хот аймгийн удирдлагатай 6 салбар байгууллага, Төрийн бус олон нийтийн болон бизнесийн зэрэг 22 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. 12 жилийн сургуульд 1200 гаруй хүүхэд суралцаж, 60 гаруй багш, 40 орчим ажилтантай. Эмнэлэгт 20 гаруй ажилтан ажиллаж байна. 1 цэцэрлэгтээ 300 гаруй хүүхдүүд хамрагдаж байна. 22 ортой 2 давхар эмнэлгийн байр 2019 онд ашиглалтанд орно.

_Тулгамдсан асуудал:_

- Хүүхдийн эмч байхгүй, эмч, сувилагч тэтгэвэрт гарсан.
- Орос хэлний багш дутагдалтай.

# VI. ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын хэмжээнд хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоо алдагдсан байна. Тухайлбал нийт хүн амын 50 шахам хувь нь газар нутгийн 0,3 хувь хүрэхгүй нутагт буюу агаар орчны бохирдол ихтэй нийслэл хотод суурьшиж байгаа нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.
2. Хүн амын шилжилт хөдөлгөөний том хотын онол Монгол Улсад хамгийн тодоор хэрэгжиж байна. Тухайлбал энэхүү онолоор хамгийн том хот нь хоёрдогч хотоосоо хүн амын тоо нь 2 дахинаас илүү их бол том хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн зайлшгүй явагддаг гэж үздэг. Харин энэ харьцаа Монголд 15 дахин их буюу энэ үзүүлэлтээр дэлхийд эхний 4-т орж байна.
3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн хувьд нэг түвшин доторхи нэгжүүд нь хүн амын тоо, газар нутгийн хэмжээгээр хоорондоо эрс ялгаатай байна.  Тухайлбал аймгаас том сум, сумаас том баг, дүүргээс том хороо байсаар байна. Иймд бусад улс орнуудын жишгээр хүн амын тоогоор шалгуур тогтоож өгөхгүй бол цаашид ч энэ ялгаатай байдал нэмэгдсээр байх төлөвтэй байна.
4. Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдал орон зайн хувьд ялгаатай байна. Нийслэл, аймгийн төв хот зэрэг суурин газруудад ажилгүйдлийн түвшин өндөр байгаа бол сум, орон нутагт ажилгүйдлийн түвшин бага байна.
5. Хүн амын төвлөрөл багатай хөдөөгийн сум, орон нутагт эрүүл мэнд, боловсрол, төрийн захиргаа зэрэг төрийн үйлчилгээний чанар хүртээмж муу байна. Тухайлбал зарим сум, орон нутагт мэргэжлийн эмч, багш, галч, төрийн захиргааны ажилтан нарын ажлын байранд ажиллах хүн олдохгүй байна.
6. Хот суурин газруудын хувьд  ч хүн амын тоо болон газар нутгийн хэмжээгээр ялгаатай байна. Суманд харьяалагдаж байгаа хотуудаар аваад үзвэл хамгийн бага газар нутагтай Архангайн Цэцэрлэг хот бүхий Эрдэнэбулган сумаас Дундговийн Мандалговь хот бүхий Сайнцагаан сумын газар нутгийн хэмжээ 200 дахин зөрүүтэй байна.
7. Нийслэлийг чиглэсэн хүн амын хэт төвлөрлийн эрчим сүүлийн жилүүдэд саарч байгаа хэдий ч нийслэлийг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн үргэлжилсээр байна.
8. Хүн амын шилжилт хөдөлгөөнийг татах хүчин зүйлс нь нийслэл Улаанбаатар хотод хэт төвлөрсөн тул хүн амын хэт төвлөрлийг сааруулахад бэрхшээл учруулж байна. Иймд хүн амын шилжилт хөдөлгөөнийг татах хүчин зүйлсийг нийслэлээс сарниулан дагуул хот болон дунд хотуудад төвлөрүүлэх шаардлага үүсч байна.
9. Дэд бүтцийн үндсэн тэнхлэгийн дагуух болон уул уурхайн аж үйлдвэрлэл дагасан Замын-Үүд, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс зэрэг сумдад хүн амын суурьшил эрчимтэй явагдаж байгаа нь тэдгээрт засаг захиргааны болон хот тосгоны статусыг нэмэгдүүлж, тогтвортой хот байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.
10. Монгол Улсын нийт 350 гаруй хот, суурин газруудын 90 гаруй хувийнх нь хүн амын тоо 5000 хүрэхгүй байгаа нь олон улсын жишгээр тухайн суурин газарт жижиг, дунд

үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих зах зээлийн багтаамж багатайгаас эдийн засгийн хувьд бие даан хөгжих чадавхи хомс байгааг харуулж байна.

11. Дэлхийн дулаарал бүхий уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр гадаргын усны нөөц багасч, бэлчээрийн экосистемийн доройтол нэмэгдэж байгаа нь хот суурин газрууд болон хөдөөгийн хүн амын усны хангамж, экосистемийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна.

# Ашигласан материалууд

## 1. Ном, товхимол, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүллүүд

Аймгуудын Статистикийн хэлтэс. 2018.Статистикийн эмхэтгэл 21 аймаг – 2017 он

Базаргүр Д. 2007. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм-эдийн засгийн газарзүйн тандах судалгаа.

Баттүвшин Б. 2005. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэл ба нийгмийн удирдлагын тогтолцооны эрхзүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл.

БСШУЯ, 2011, Боловсролын салбарын 2010-2011 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл

ЗГХЭГ. 2006. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үүсэл хөгжил, өнөөгийн байдал, шинэчлэл хийх саналын тухай.

ЖАЙКА. 2016. Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа http://open_jicareport.jica.go.jp/pdf/12283339_01.pdf

Монгол Улсын Засгийн газар. 2005. Аймгуудад хүргүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарийн санал зураг, сэтгүүл.

Монгол Улсын Засгийн газар. 2005. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх саналын тухай. Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан материал.

Сономдагва Ц. 1998. Монгол УЛсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт.

Үндэсний Статистикийн Хороо, 2011, Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого

Үндэсний Статистикийн Хороо, 2011. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2010.

Үндэсний Статистикийн Хороо. 2008. Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо

Цэдэндамба Л, Х.Маам. 2000. Монгол Улсын Өрнөд бүс.

Цэдэндамба Л. Р.Ринчинбазар, Д.Гансэлэм. Эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох арга зүйн асуудалд. Үндэсний Хөгжлийн хүрээлэн. Бүтээлийн эмхэтгэл.

ШУА. Газарзүйн хүрээлэн. 2005. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөх саналын хувилбар

Алтанбагана М., С.Давааням, Хэрлэнбаяр. 2016. Монгол Улсын хот байгуулалтын тайлан, БХБЯ-ны захиалгаар

Давааням С., Д.Бямбаа. 2011. Монгол Улсын Хүн амын суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар

Давааням С., М.Алтанбагана нар. 2011. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэтгэлийн талаар харьцуулсан судалгаа, бодлогын оновчтой хувилбарууд, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар

Chuluun, T, Altanbagana M., Davaanyam S. & Ojima D. 2006. Vulnerability and adaptation options of the coupled human-environmental system to global change in Mongolia. Pages 148 In: A program of Earth System Science Partnership Open Science Conference on “Global Environmental Change: Regional Challenges”, Beijing, China.

Chuluun, T. 2005. A new administrative-territorial division of Mongolia as a mechanism to increase adaptive capacity to climate change. Pages 436 In: The 6th open meeting of the international human dimensions meeting of global environmental change on “Global environmental change, globalization and international security: new challenges for the 21st century” Conference book, Bonn, Germany.

Dexia, EU sub-national governments: 2008 key figures, 2009/2010 edition

Expert Group. 2010. Analytical study on optimal administrative-territorial structure for republic of Moldova.

## 2. Хууль эрхзүйн баримт бичгүүд

Монгол Улсын Үндсэн хууль. 1993

Засгийн газрын тухай хууль

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хууль

Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохион байгуулалтын тухай хууль

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. 2001

Баруун, Хангайн, Төвийн болон Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд

Бүсчилсэн Хөгжлийн Хороо. 2005. Бүсчилсэн хөгжил гарын авлага.

# ХАВСРАЛТ 1. Орон нутагт томилолтоор ажилласан байдал

**Томилолтоор ажилласан байдлын зургууд**



*Зураг 1. "Говьсүмбэр аймгийн Чойр" хотод "Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөлд" хамтран ажиллах мэдээлэл солилцох, ажлын хэсгийг хуралдуулж мэдээлэл солилцох хурлын явц. ГХБХБГ-ын дарга Б.Отгончимэг, Усны сав газрын захиргааны газрын мэргэжилтэн Г.Батхүү, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Т.Баясгалан, Барилгын хэлтсийн дарга Б.Даваажаргал, Хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, болон бусад ажлын хэсгийн хамтаар*



*Зураг 2. "Говьсүмбэр аймаг Чойр" хотын төв*



*Зураг 3. “Дорноговь аймгийн Шивээговь суманд” “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн” танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц . Газрын даамал Э.Баярмагнай*



*Зураг 4. “Говьсүмбэр аймаг Шивээговь” сумын төв*



*Зураг 5. "Дорноговь аймгийн Даланжаргалан" суманд Засаг даргын тамгын газрын орлогч дарга О.Болд, Газрын даамал Ц.Даарийmaa болон Засаг дарга Ц.Уранцэцэг нартай "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн" танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 6. "Дорноговь аймгийн Даланжаргалан" сумын төв*



*Зураг 7. “Дорноговь аймгийн Айраг” суманд Засаг даргын орлогч Г.Амгаланбаатар, Байгаль орчны байцаагч Б.Бямбацогт нартай “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн” танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 8. “Дорноговь аймгийн Иххэт” суманд “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн” танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц /2018.10.27 Гэрэл зургийг ХАНСБНСТХ-ийн мэргэжилтэн Б.Идэрхангай*

*Зураг 9. "Дорноговь аймгийн Иххэт" сумын Нутгийн удирдлагын ордон*



*Зураг10. "Дорноговь аймгийн Алтанширээ" суманд Засаг даргын орлогч Б.Мөнхтулга болон Газрын даамал Ү.Нарангэрэл нартай "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн" танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 11. "Дорноговь аймаг Алтанширээ" сумын төв*



*Зураг 12. "Дорноговь аймгийн Сайншанд" хотод Орон нутаг дахь ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч Эрдэнэчимэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Ганбат, Аймгийн ерөнхий архитектур П.Оюунтөгөлдөр болон бусад ажлын хэсгийн гишүүдтэй "Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөлд" хамтран ажиллах мэдээлэл солилцох, ажлын хэсгийг хуралдуулж мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 13. “Дорноговь аймгийн Өргөн” суманд Тамгын газрын дарга мөн Газрын даамал Б.Адилбиш нартай “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн” танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*




*Зураг 14. “Дорноговь аймгийн Өргөн” сумын Нутгийн удирдлагын байр*



*Зураг 15. ”Дорноговь аймгийн Өргөн” сумын төв*




*Зураг 16. “Дорноговь аймаг Эрдэнэ” сум*



*Зураг 17. “Дорноговь аймгийн Замын-үүд” суманд Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга Батдулам, Замын-үүд сумын ерөнхий архитектор Баярболд, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Алтангэрэл, Газрын даамал Ж.Бат-Оргил, Байгаль орчин аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн мэргэжилтэн Анхбаяр болон бусад 20 гаруй хүмүүстэй “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн” танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*




*Зураг 18. "Дорноговь аймгийн Замын-үүд" сумын нутаг дэвсгэрт байрлах Замын-үүд хилийн боомттой одоогийн хүчин чадал, хил нэвтрэхүйл ажиллагаа, боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжиж буй газар, Замын-үүд эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагаа хэрэгжилттэй танилцав.*



*Зураг 19. . "Дорноговь аймгийн Хөвсгөл" суманд Тамгын газрын дарга Заясайхан-тай"Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн" танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 20. “Дорноговь аймгийн Хөвсгөл” сумын төв*



*Зураг 21. “Дорноговь аймгийн Хатанбулаг” суманд Сумын засаг даргын орлогч, Тамгын газрын дарга Т.Цэцэгсүрэн, Газрын даамал Л.Нармандах нартай “Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн” танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 22. “Дорноговь аймаг Хатанбулаг” сумын төв*



*Зураг 23. “Өмнөговь аймгийн Ханбогд” сумын тамгын газрын дарга болон бусад мэргэжилтэн албан хаагчидтай “Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн” танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 24. "Өмнөговь аймаг Ханбогд" сумын шинээр ашиглалтад орсон Соёлын төв ордон, баригдаж буй орон сууцны барилга*



*Зураг 25."Өмнөговь аймгийн Ханбогд" сумын нутаг дэвсгэр дэх Монгол Улсын стратегийн орд "Оюу-толгой ХХК"-ийн үйл ажиллагаатай танилцаж "Хүн амын нутагшилт суурьшил хөгжлийн ерөнхий төсөл"-ийн талаар танилцуулах үйл ажиллагааны явц*




*Зураг 26. “Өмнөговь аймаг Оюу-толгой” стратегийн орд газар түүний үйл ажиллагаатай Хөтөч Э.Өнөнболдын хамтаар танилцаж байна.*



*Зураг 27. “Өмнөговь аймгийн Цогтцэций” суманд Ханбогд сумын тамгын газрын дарга болон бусад 20 гаруй мэргэжилтэн албан хаагчидтай “Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн” танилцуулга хүргэж орон нутагтай мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 28. “Өмнөговь аймаг Цогтцэций” сумын төв*



*Зураг 29.”Өмнөговь аймгийн Цогтцэций” сумын нутаг дэвсгэр дэх Монгол Улсын стратегийн орд “Энержи-Ресурс ХХК”-ийн үйл ажиллагаатай Хөтөч П.Пүрэвдоржын хамтаар танилцаж “Хүн амын нутагшилт суурьшил хөгжлийн ерөнхий төсөл”-ийн талаар танилцуулах үйл ажиллагааны явц*




*Зураг 30. “Өмнөговь аймгийн Даланзадгад” хотод “Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөлд” хамтран ажиллах, мэдээлэл солилцох ажлын хэсгийг хуралдуулж мэдээлэл солилцох хурлын явц*




*Зураг 31. “Өмнөговь аймаг Даланзадгад” хотын Нутгийн удирдлагын ордон*



*Зураг 32. "Дундговь аймгийн Мандалговь" хотод Аймгийн ерөнхий архитектор "Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөлд" хамтран ажиллах мэдээлэл солилцох, ажлын хэсгийг хуралдуулж мэдээлэл солилцох хурлын явц*



*Зураг 33. "Дундговь аймаг Мандалговь" хотын төв*



Зураг 1. Дундговь аймгийн Говь-Угтаал сум















Зураг 2. Дундговь аймгийн Гурвансайхан сум





Зураг 3. Дундговь аймгийн Сайнцагаан сум /Мандалговь хот/




НУТГИЙН УДИРДЛАГЫН ОРДОН











Зураг 4. Дундговь аймгийн Эрдэнэдалай сум





Зураг 5. Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум






НУТГИЙН УДИРДЛАГЫН ОРДОН




Зураг 6. Өмнөговь аймгийн Булган сум



















Зураг 7. Өмнөговь аймгийн Сэврэй сум





Зураг 8. Өмнөговь аймгийн Гурвантэс сум





Зураг 9. Өмнөговь аймгийн Баяндалай сум



Зураг 10. Өмнөговь аймгийн Даланзадгад сум. Засаг даргын орлогч Мөнхбаяр



Зураг 11. Өмнөговь аймгийн Баян-Овоо сум








KOMATSU




4
Know safety
or no safety



Зураг 12. Өмнөговь аймгийн Ханбогд сум /Оюутолгойн уурхай/




Зураг 13. Өмнөговь аймгийн Ханбогд сум





ЦАХИЛГААНД ЗАЛГА
9999-1436
9999-2053
9901-7867
ЦАХИЛГААН ТАСАРВАЛ ТАНЫ БИЗНЕСТ ЯМАР ХОХИРОЛ УЧРАХ ВЭ?




ENERGY RESOURCES



Зураг 13. Өмнөговь аймгийн Цогтцэций сум



Зураг 14. Өмнөговь аймгийн Цогтцэций сум /Ухаа худаг/



Зураг 15. Өмнөговь аймгийн Даланзадгад сум



Зураг 16. Дундговь аймгийн Сайнцагаан сум /Мандалговь хот/

**ХАВСРАЛТ 2.** Томилолтоор ажиллах хугацаанд цуглуулсан мэдээ материалуудын жагсаалт

| № | Агуулга | Хэвлэгдсэн он | Хамрах хугацаа | Хуудас |
|---|---|---|---|---|
| | **1.Цаасаар** | | | |
| 1.1 | Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг | 2015-2018 | 2016-2025 | 150 хх |
| 1.2 | Сумдын хөгжлийн бодлогын баримт бичиг | 2015-2018 | 2016-2021 | 250 хх |
| 1.3 | Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө | 2017 | 2017 | 150 хх |
| 1.4 | Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр | 2016 | 2016-2020 | 10 хх |
| 1.5 | Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр | 2016 | 2016-2020 | 10 хх |
| 1.6 | Аймгийн түүхт ойн хүрээнд гаргасан нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны талаархи нэгдсэн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий ном | 2011-2018 | 2011-2018 | 350 хх |
| 1.7 | Сумын түүхт ойн хүрээнд гаргасан нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны талаархи нэгдсэн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий ном | 2011-2018 | 2011-2018 | 250 хх |
| 1.8 | Аймгийн аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр | 2015-2018 | 2017-2025 | 5 хх |
| 1.9 | Сумын аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр | 2015-2018 | 2017-2025 | 5 хх |
| 1.10 | Аймгийн жилийн статистикийн эмхэтгэл | 2010-2018 | 2010-2017 | 65 хх |
| 1.11 | Аймгийн аялал жуулчлалын газрын зураг | 2015-2018 | 2015-2018 | хх |
| | **2.Тоон хэлбэрээр цуглуулсан мэдээ материалууд** | | | |
| 2.1 | Аймгийн сумдын газрын нэгдмэл сангийн тайлан | 2010-2017 | 2010-2017 | 20 хх |
| 2.2 | Аймгийн жилийн статистикийн эмхэтгэл | 2010-2018 | 2010-2017 | 65 хх |
| 2.3 | Сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө | 2010-2018 | 2015-2025 | 350 хх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.4 | Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө | 2018 | 2017 | 150 хх |
| 2.5 | Аймаг, сумдын хүн амын тоо, багийн түвшинд | 2018 | 2010-2017 | 80 хх |
| 2.6 | Сумдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн мэдээ, багийн түвшнээр | 2018 | 2010-2017 | 100 хх |
| 2.7 | Сумдын газар тариалангийн үйлдвэрлэлийн мэдээ | 2018 | 2010-2017 | 55 хх |
| 2.8 | Аймаг, сумдын боловсролын байгууллагын мэдээ, суралцагчид, хүчин чадал, багшлах боловсон хүчний тоогоор | 2018 | 2017-2018 | 85 хх |
| 2.9 | Аймгийн хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний мэдээ | 2018 | 2010-2018 | 55 хх |
| 2.10 | Сумдын төрийн захиргааны байгууллагын ажиллагсдын тоон мэдээ | 2018 | 2018 | 35 хх |
| 2.11 | Сумдын эрүүл мэндийн байгууллагын тоон мэдээ, хүчин чадал, зэрэглэл, боловсон хүчин, үйлчлүүлэгсдийн тоо | 2018 | 2018 | 25 хх |
| 2.12 | Хилийн боомтоор нэвтэрсэн гадаад, дотоодын зорчигсдын тоо болон ачаа нэр төрлөөр | 2018 | 2010-2018 | 35 хх |
| 2.13 | Аймаг, сумдын орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл | 2018 | 2018 | 5 хх |
| 2.14 | Аймаг, сумдын нутагт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй орд газруудын талаархи мэдээлэл | 2018 | 2018 | 5 хх |
| 2.15 | Аймаг, сумдын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаархи үнэлгээний мэдээ | 2018 | 2016-2020 | 10 хх |
| 2.16 | Аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаархи тайлан | 2017-2018 | 2018 | 5 хх |
| 2.17 | Аймаг, сумдын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын талаархи мэдээ | 2017-2018 | 2018 | 5 хх |
| 2.18 | Замын-Үүд чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.19 | Хамрын хийдийн аялал жуулчлалын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | 2017 | 2017-2020 | 2 хх |

## Хавсралт 3. Орон нутагт томилолтоор ажиллах маршрутын газрын зураг

